



ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойн тусгай дугаар

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын мэндчилгээ
- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үүсэл, хөгжил-20 жилд
- Монгол Улсад хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн үүрэг
- Үндсэн хуулийн хяналт, ойлголт, чигхандлага Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал
- Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим
- Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид
- Сонгуулийн пропорциональ тогтолцоо ба Монгол Улсын Үндсэн хууль
- Орон сууцны даатгалын эрх зүйн зохицуулалт: АНУ-ын Флорида, Луизианамуж
- Үл хөдлөх хөрөнгө, тулгамдаж буй асуудал
- Форексийн бизнес түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал
- Залилан мэхлэх гэм тхэрэг
- Хугацаагүй хорих ял ба түүнийг эдлүүлэхэд анхаарах зарим асуудал
- Сөрөг нэхэмжлэл

СЭТГҮҮЛИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ

Ц.Нямдорж	- Хууль зүй, дотоод хэргийн сайд
Ц.Зориг	- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч
Д.Дорлигжав	- Улсын Ерөнхий прокурор
Ж.Амарсанаа	- Үндсэн хуулийн цэцийн дарга
Д.Олбаяр	- Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга
Д.Лүндээжанцан	- Улсын Их Хурлын гишүүн
Ц.Мөнх-Оргил	- Улсын Их Хурлын гишүүн
С.Батдэлгэр	- Улсын Дээд шүүхийн шүүгч
Ц.Шаравдорж	- Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга
П.Цагаан	- Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх
Б.Долгор	- Монгол Улсын Ерөнхий сайдын хуулийн зөвлөх
Ж.Бямбадорж	- Хүний эрхийн үндэсний комиссын дарга
Г.Баясгалан	- ХЭДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга
Б.Пүрэвням	- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны Ерөнхийлөгч
Ч.Отгонбаяр	- Монголын Нотариатчдын Танхимын Ерөнхийлөгч
Д.Батжаргал	- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал
С.Нарангэрэл	- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрдмийн зөвлөлийн дарга
Д.Сандаг-Очир	- Цагдаагийн ерөнхий газрын дарга
Д.Зүмбэрэлхам	- Төрийн албаны зөвлөлийн дарга
Д.Солонго	- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал
Б.Болдбаатар	- Дотоод хэргийн их сургуулийн захирал

СЭТГҮҮЛИЙН ШИНЖЭЭЧ ЭРДЭМТДИЙН ЗӨВЛӨЛ

С.Жанцан	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)
Ч.Энхбаатар	- Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D)
Ш.Чоймаа	- Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор (Sc.D)
Б.Амарсанаа	- Хууль зүйн доктор (LL.D)
Б.Гүнбилэг	- Хууль зүйн доктор (Ph.D)
Б.Тэмүүлэн	- Хууль зүйн доктор (Ph.D)
Г.Банзрагч	- Хууль зүйн доктор (Ph.D)
Д.Баярсайхан	- Хууль зүйн доктор (Ph.D)
Д.Гангабаатар	- Хууль зүйн доктор (LL.D)
Т.Мэндсайхан	- Хууль зүйн доктор (Ph.D)

ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ЗӨВЛӨЛ

Хүндэт зөвлөх: Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид
 Ерөнхий эрхлэгч: Д.Батжаргал
 Эрхлэгч: Б.Амарсанаа
 Хариуцагатай нарийн бичгийн дарга: С.Алтантуяа

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
 Сүхбаатарын талбай-7
 Утас: 312513, 99083007
 Факс: 315736
 Вэб сайт: www.legalinstitute.mn
 И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn



Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 20 жилийн ойд
зориулсан тусгай дугаар



ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн хоёр сар тутмын сэтгүүл

Цуврал 38

2012 он, Зургадугаар сар

№3

АГУУЛГА

ХУУДАС

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын мэндчилгээ	5
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үүсэл, хөгжил-20жилд Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Ч.Дашням	6

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ОНОЛ, АРГА ЗҮЙ

Монгол Улсад хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн үүрэг	27
Үндсэн хуулийн цэцийн дарга, Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ж.Амарсанаа	
Үндсэн хуулийн хяналт, ойлголт, чиг хандлага	31
Үндсэн хуулийн цэцийн орлогч дарга, Хууль зүйн доктор (Ph.D) Н.Жанцан	
Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал	36
Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ц.Сарантуяа	

Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим	44
<i>Үндсэн хуулийн цэцийн гишүүн, дэд профессор Д.Наранчимэг</i>	

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид	59
<i>Үндсэн хуулийн цэцийн гишүүн, профессор Б.Пирэвням</i>	

Сонгуулийн пропорциональ тогтолцоо ба Монгол Улсын Үндсэн хууль	66
<i>ХЗҮХ-ийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр (LL.M) А.Түвшинтулга</i>	

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Орон сууцны даатгалын эрх зүйн зохицуулалт: АНУ-ын Флорида, Луизана муж	78
<i>Хууль зүйн члдэсний хүрээлэнгийн судалгаа</i>	

ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Үл хөдлөх хөрөнгө, тулгамдаж буй асуудал	104
<i>МУИСийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Ц.Давхарбаяр</i>	

Форексийн бизнес түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал	110
<i>ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, магистр (LL.M) Э.Мөнхжаргал</i>	

Залиан мэхлэх гэмт хэрэг	118
<i>ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан Х.Өсөх</i>	

Хугацаагүй хорих ял ба түүнийг эдлүүлэхэд анхаарах зарим асуудал	128
<i>ШШГЕГ-ын хэлтсийн дарга, дэд хурандаа докторант Ц.Очгэрэл</i>	

Сөрөг нэхэмжлэл	135
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Д.Хуяг</i>	

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ	140
------------------------	------------

The Issue Is Dedicated to the 20th Anniversary of the Constitutional Tsets (Court) of Mongolia

Vol.38

June, 2012

NO.3

CONTENTS

PAGE

Greeting of the Chairman of the Constitutional Tsets (Court) of Mongolia 5

Origination of the Constitutional Tsets (Court) of Mongolia-20 Years 6

ARTICLES

Role of the Constitutional Court for Protecting Human Rights in Mongolia 27

*Amarsanaa.J. Professor, Sc.D. Academician,
the Chairman of the Constitutional Tsets (Court) of Mongolia*

Constitutional Supervision, Concept and Approach 31

*Jantsan.N. Ph.D.
the Vice-Chairman of the Constitutional Tsets (Court) of Mongolia*

Pressing Issues on Constitutional Procedural Law of Mongolia 36

*Saranluya.Ts. Professor, Sc.D.
A Member of the Constitutional Tsets (Court) of Mongolia*

The Independence of the Constitutional Court And Its Members 44

*Naranching.D. Associate Professor,
A Member of the Constitutional Tsets (Court) of Mongolia*

Participants to Review Process of Constitutional Courts 59

*Purevnyam.B. Professor
A Member of the Constitutional Tsets (Court) of Mongolia*

Proportional Electoral System and the Constitution of Mongolia 66

*Tuvshintulga.A. LL.M
Researcher of Humanitarian And Administrative Law Sector,
National Legal Institute*

RESEARCH REPORT

Appartment Building Insurance Regulations: Examples of Florida And Louisiana States of the USA	78
<i>Research Report by National Legal Institute</i>	

NOTES

Pressing Issues on Immovable Properties	104
<i>Davkharbayar.Ts, Ph.D candidate Senior Lecturer of School of Law, National University of Mongolia</i>	
Forex Regulations and Its Pressing Issues	110
<i>Munkhjargal.E, LL.M, Lecturer, School of Law, "Olgontenger" University</i>	
Crime on Appropriation of Property by Fraud	118
<i>Usukh.Kh, Researcher of Criminal Law And Criminology Sector, National Legal Institute</i>	
Some Issues on Life Imprisonment	128
<i>Ochgerel.Ts, Ph.D candidate, Head Of Department, General Authority of Enforcement of Court Decisions</i>	
Counter Claim	135
<i>Huyag.D, Ph.D candidate Senior Lecturer of School of Law, National University of Mongolia</i>	

NEWS AND EVENTS	140
------------------------	------------

МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан улсын түлгүүр хууль болсон Үндсэн хуулийг хамгаалах хариуцлагатай бөгөөд асар их нэр хүндтэй энэхүү албанд хүчин зүтгэсэн ахмад үеийн болон одоо ажиллаж буй эрхэм хүндэт гишүүд, ажилтан нар, иргэд Та бүхэндээ өөрийн зүтгээс болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн нэрийн өмнөөс баяр хүргэн мэндчилгээ дэвшүүлье.

Монгол оронд Үндсэн хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих үүрэгтэй Үндсэн хуулийн шүүхийн уламжлал байгаагүй. Анх 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх шүүх эрх мэдлийн байгууллага байгуулах эрх зүйн үндэс бүрэлдэж, Үндсэн хуулийн хяналтын механизмыг бий болгосон нь шинэ Үндсэн хуулийн нэг ололт байлаа.

Цэц үүсэн байгуулагдсанаас хойших 20 жилийн хугацаанд Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа Үндсэн хуулийг хэрхэн сахих биелүүлж байгаад хяналт тавих, өөрөөр хэлбэл, ардчлалын үнэт зүйлс, ялангуяа хүний эрх, эрх чөлөөг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан эрх мэдэлдээ дулдуйдан, дур зоргоороо аашлан Үндсэн хуулийг зөрчих, түүнийг сөвтгэхээс хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж, ардчилсан төрийн тогтолцоонд өөрийн зохих байр сууриа эзэлсэн төдийгүй, Цэцийн талаар хомсхон ойлголттой байсан олон түмэнд үүрэг зорилгоо зөв мэдрүүлж чадлаа.

Үндсэн хуулийг хамгаалах их үйлс бол зөвхөн Үндсэн хуулийн цэцийн ажил биш. Энэ бол нийт байгууллага болоод иргэд, Та бид бүхний үүрэг юм. Ийм учраас Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүнийг чандлан сахиулах чиг үүрэг бүхий Цэцийн 20 жилийн ойн баяр бол Монгол Улсын иргэд бид бүгдийн баяр билээ.

Ардчилал, эрх зүйт төрийн үнэт зүйлсийг сахин хамгаалах их үйлсэд улам их амжилт гаргахыг Та бүхэндээ хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН
ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА



Ж.АМАРСАНАА



Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн үүсэл,
хөгжил-20 жилд



Үндсэн хуулийн цэцийн
Тамгын газрын дарга Ч.Дашням

Үндсэн хуулийг бодитойгоор хэрэгжлэг, эрх зүйн дээд хүчин чадалтай, жинхэнэ “амьд” тулгуур хууль байлгах үүднээс түүний хяналтын механизмыг нь бүрэлдүүлж өгдөг явдал эрх зүйт төрийн тогтолцоог сонгосон улс орнуудад нэгэнт жишиг болон тогтсон билээ. Манай улс ч хүний эрхийг дээдэлсэн, ардчилсан, эрх зүйт төрийг байгуулах зорилтыг тунхагласан шинэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлахдаа энэхүү жишгийг баримталсан түүхтэй.

БНМАУ-ын Ардын Их Хурлаас 1992 оны 1 дүтээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц” гэсэн Тавдугаар бүлэг батлагдснаар Монгол төрийн түүхэнд анх удаа Үндсэн хуульд заан баталгаажуулсан, “Үндсэн хуулийн цэц” хэмээх тусгайлсан нэртэй Үндсэн хуулийн шүүх байгуулагдан ажиллах эрх зүйн үндэс бодит байдлаар бүрджээ.

Үндсэн хуулийн энэхүү заалтын үндсэн дээр Улсын Бага Хурал 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, Улсын Их Хурал 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус батлан мөрдүүлсэн бөгөөд Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд 1995, 1997, 1999, 2003, 2005 онд 5 удаа, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд 2005, 2009 онд 2 удаа

нэмэлт, өөрчлөлт оруулан Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож ирсэн байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн гурвыг Улсын Их Хурлаас, гурвыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс, гурвыг Улсын дээд шүүхээс санал болгосноор Улсын Их Хурал томилдог. Үндсэн хуулийн энэ заалтын дагуу Улсын Бага Хурал 1992 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Улсын Бага Хурлаас санал болгосон Гэндэнгийн Нямдоо, Цэндийн Цолмон, Дамбадаржаагийн Чинхаажав, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санал болгосон Жавхлангийн Бямбаа, Наваанпэрэнлэйн Жанцан, Галдангийн Совд, Улсын дээд шүүхээс санал болгосон Лэгцэгийн Баасан, Баасайн Дангаасүрэн нарыг Цэцийн гишүүнээр томилсноор Үндсэн хуулийн цэц байгуулагдсан түүхтэй. Улсын Их Хурал Улсын дээд шүүхээс санал болгосноор Жамцын Чойжанцанг 1992 оны 7 дугаар сарын 6-ны өдөр томилсноор Цэц бүрэн бүрэлдэхүүнээр ажиллах болсон байна.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр нийт 27 хүн томилогдон ажилласан байх бөгөөд тэдгээрийн 23 нь хууль зүйн, бусад нь улс төрийн өндөр мэргэшил бүхий хүмүүс байна. Цэц байгуулагдан ажилласан 20 жилийн талаас илүү хугацаанд Цэцийн бүрэлдэхүүний гуравны нэг нь эмэгтэй гишүүд ажиллаж ирлээ.

Энэ 20 жилд ажилласан Цэцийн гишүүдээс доктор 5, шинжлэх ухааны доктор 9, тэднээс 3 нь Монгол Улсын шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, мөн Монгол Улсын гавьяат хуульч 7, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн 1, профессор 15 байна.

Үндсэн хуульд зааснаар Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг боловч бүрэн эрхийн хугацаа дууссан болон орон гарсан гишүүний оронд нөхөн томилох хүний талаар санал гаргах эрх бүхий байгуулага, албан тушаалтан, мөн тэднийг томилох үүрэг хүлээсэн Улсын Их Хурлын "хуульд нийцсэн, шуурхай" ажиллагаанаас үүдэн Цэцийн гишүүн "хугацаа хэтрүүлэн" ажиллах явдал цөөнгүй (давхардсан тоогоор 11 гишүүн 2 сараас 1 жил 4 сараар) гарч байв. Цэцийн гишүүн хэдэн ч удаа улиран томилогдож болно. Энэ үндсэн дээр Цэцийн 7 гишүүн 1-3 удаа улиран томилогдсоны дотор Н.Жанцан 3 удаа улирч буюу 4 дэх удаагаа, Ж.Амарсанаа 2 удаа улирч буюу 3 дахь удаагаа Цэцийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Үндсэн хуулийн Цэцийн даргыг Цэцийн гишүүд дундаасаа нэр дэвшүүлэн нийт гишүүний олонхын саналаар, 3 жилийн хугацаатай сонгодог. Үндсэн хуулийн Цэцийн даргаар Г.Совд, Н.Жанцан, Ж.Бямбадорж нар тус бүр 1 удаа улирч буюу 6 жилийн хугацаагаар

ажилласан. Одоо Цэцийн даргаар Ж.Амарсанаа 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдрөөс сонгогдон ажиллаж байна. Мөн Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд 2005 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн цэцэд орлогч дарга ажиллах болсон бөгөөд уг албыг энэ цагаас хойш Цэцийн гишүүн Н.Жанцан хашиж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа билээ. Цэц үүсэн байгуулагдсанаас хойших 20 жилийн хугацаанд Үндсэн хуулиар хүлээлгэсэн, төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа Үндсэн хуулийг хэрхэн сахин биелүүлж байгаад хяналт тавих, өөрөөр хэлбэл, ардчлалын ололт, ялангуяа хүний эрх, эрх чөлөөг төр, засгийн холбогдох байгууллага, албан тушаалтнууд эрх мэдэлдээ дулдуйдан, дур зоргоор аашлан зөрчих, сэвтээхээс хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж, ардчилсан төрийн тогтолцоонд өөрийн зохих байр сууриа эзэлж, Цэцийн талаар хомсхон ойлголттой байсан олон түмэнд үүрэг зорилгоо зөв мэдрүүлж, хүлээн зөвшөөрөгдөж чадсан билээ. Цэцэд хандан гаргаж буй өргөдөл, мэдээлэл, түүний хянан шийдвэрлэж байгаа маргааны тоо жилээс жилд өсөн нэмэгдсээр байгаа нь үүний нотолгоо болно.

Сэлэнгэ аймгийн Ерөө хорооны иргэн И.Бадарчийн мэдээллээр Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцан 1992 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр 01 дүгээр тогтоол гарган маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэж 1992 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Цэцийн дарга Г.Совд даргалан гишүүн Г.Нямдоо, Н.Жанцан, Ж.Чойжанцан, Д.Чилхаажав нарын бүрэлдэхүүнтэй, мэдээлэл гаргасан иргэн И.Бадарч, Р.Даваажав, Ч.Базар, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Бямбадорж нарыг оролцуулан хийсэн хуралдаанаар “Орон нутгийн харьяалалтай зарим хот, хороодыг тухайн суманд нь нэгтгэн харьяалуулах тухай” Улсын Их Хурлын 1992 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 24 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан хэлэлцээд уг тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргаж үйл ажиллагааныхаа анхны шанг татаж байжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оны 7 дугаар сарын 13-ны өдөр анхны өргөдөл, мэдээлэл хүлээн авснаас хойш 2012 оны 5 сар дуустал хугацаанд иргэд, байгууллага, албан тушаалтнаас нийт 1600 орчим өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж, нийт 131

дүгнэлт гаргасны 71 нь Үндсэн хууль зөрчсөн хэмээн гарчээ. Мөн энэ хутагаанд нийт 45 маргааныг эцэслэн шийдвэрлэж, Үндсэн хуулийн цэцийн тогтоол гарсан байна.

Энэ хутагаанд Үндсэн хуулийн нийт 35 зүйлийн 71 заалт 157 удаа зөрчигдснийг тогтоон Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргасан байна. Үүнээс хүний эрх, эрх чөлөөний талаарх Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн заалт 29 удаа, Арван дөрөвдүгээр зүйлийн заалт 16 удаа, Нэгдүгээр зүйлийн заалт (Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн) 12 удаа, Хорин есдүгээр зүйлийн заалт (Улсын Их Хурлын гишүүн хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй болон Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалтай холбоотой) 11 удаа, Аравдугаар зүйлийн (Монгол Улсын олон улсын гэрээний тухай), Дөчин есдүгээр зүйлийн (шүүгчийн хараат бус байдлын тухай), Дэлдугаар зүйлийн (Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохих тухай) заалт тус бүр 7 удаа зөрчигдсөн тухай дүгнэлт гарсан тул тэдгээр нь Үндсэн хуулийн хамгийн ихээр зөрчигдөж буй зүйл, заалт байгаа болно.

Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэсэн маргаанаас үзэхэд албан татварын холбогдолтой хуулиуд Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан 16, хууль тогтоох онцгой бүрэн эрхтэй, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурлын эрх хэмжээ, үйл ажиллагааг зохицуулдаг Улсын Их Хурлын тухай, түүний чуулганы хуралдааны дэгийн тухай, УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан 14, УИХ-ын сонгуулийн тухай хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан 10, мөн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон харилцааг голлон зохицуулдаг Эрүүгийн байцаан шийтгэх хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргаан 9-ийг тус тус хянан шийдвэрлэсэн нь нэг төрлийн хуулиар гарсан хамгийн олон маргаан байна. Эдгээрээс албан татварын холбогдолтой маргааны 37.5 хувь, УИХ-ын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдолтой хуулийн талаарх маргааны 71.4 хувь, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн холбогдолтой маргааны 44.4 хувьд нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гарчээ. Ийнхүү хууль, эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийн зүйл, заалтаас Үндсэн хуультай зөрчилдөж байгааг нь тогтоож, хүчингүй болгосон, ардчилсан, эрх зүйт төрийн хийгээд улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн төлөвшилд ач холбогдлоор өндөр зарим шийдвэрээс дурдвал, өнөөдөр “амтай болгон” нь ярьж, шүүмжилж буй, Монгол Улсын Их Хурлаас

1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт", Улсын Их Хурлын гишүүдэд сонгуулийн тойргоор нь хуваарилан хөрөнгө оруулалтын төсөв баталсан, Улсын Их Хурлын дарга нь Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэгэнт батлагдсан хуульд агуулга, боллого, зарчмын болон найруулга, үг хэллэг, дараалал, бүтцийн чанартай олон тооны засвар, өөрчлөлтийг хийсэн нь тус тус Үндсэн хуулийг зөрчсөн болохыг тогтоосон шийдвэр зэргийг нэрлэж болно. Мөн 2005 онд шинэчлэн найруулсан Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн "ялгүй байх" гэсэн заалтыг Улсын Дээд шүүх "Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн "ялгүйд тооцох", "ялгүй болох" гэсэн ойлголтуудтай адилтгаж үзэх үндэслэлгүй, "огт ял шийтгүүлж байгаагүй" гэж ойлгон хэрэглэнэ" гэж буруу тайлбарлан хуулийн зохицуулалтыг Үндсэн хууль зөрчсөн агуулгатай болгосныг Үндсэн хуулийн цэц залруулан шийдвэрлэж байв.

Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон Үндсэн хуулийн заалт (Арван зургадугаар зүйл)-ыг зөрчсөн 71 зөрчлөөр нийт 58 маргаан хянан шийдвэрлэсний 26-д нь Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэр гаргажээ. Үүнээс заримыг дурдвал, эрүүлжүүлэх байранд хүн саатуулах журмыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн тогтоосон болон Улсын дээд шүүхийн давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцсон шүүгч мөн хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд оролцож болох тухай хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн тухай Цэцийн дүгнэлтүүд нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон асуудлыг зөвхөн хуулиар тогтоох, шүүхийн систем дэх ялгавартай байдлыг халахад чиглэгдсэн, алс хэтийн, онцгой чухал ач холбогдолтой шийдвэр болсныг 2002 онд Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын дарга, доктор С.Цэрэндорж олон улсын симпозиум дээр тавьсан илтгэлдээ онцлон тэмдэглэсэн байна.¹

Мөн эрх бүхий албан тушаалтан Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай 11 маргааныг Үндсэн хуулийн цэцийн хуралдаанаар хэлэлцэн дүгнэлт гаргасны 6 нь Улсын Их Хурлын дарга болон гишүүдтэй холбогдсон маргаан байгаа ба тэдгээрийн 4 нь Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гарчээ. Мөн Ерөнхий сайд Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан 2, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн тухай маргаан тус бүр нэгийг хянан шийдвэрлэсэн байна.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллээс гадна Улсын Их Хурал, Ерөнхийлөгч,

¹ С.Цэрэндорж "Үндсэн хуулийн шүүх хүний эрхийн асуудал", Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл). Уб., 2007 он. 241-242 дахь тал.

Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг.

Цэц өнөөдрийг хүртэл хугацаанд хүлээн авсан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн 99 хувийг иргэд, зөвхөн нэг хувийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргасан байна. Үүнээс үзэхэд манай иргэд Үндсэн хуулиа сахин хамгаалахад илүү идэвх санаачлага, хүчин чармайлт гаргаж байна. Харин хүсэлт гаргах эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудаас Улсын дээд шүүх 6, Ерөнхийлөгч 2, Улсын ерөнхий прокурор 1 хүсэлт гаргаж, Улсын Их Хурал болон Ерөнхий сайд хүсэлт огт гаргаагүй байна.

Үндсэн хуулийн цэц хүлээн авсан нийт өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн 10 орчим хувьд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн хуралдаанаар хэлэлцэж хянан шийдвэрлэсэн бөгөөд хянан шийдвэрлэсэн маргааны 92.1 хувийг эрх бүхий байгууллага, албан тушаалтны батлан гаргасан эрх зүйн акт Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай, 8.1 хувийг албан тушаалтан Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргаан эзэлж байна. Үүний дотор хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргаан 82.0 хувийг, Засгийн газрын шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргаан 7.0 хувийг, Ерөнхийлөгчийн Зарлиг болон Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргаан тус бүр 1.6 хувийг эзэлж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу дүгнэлтээ гармагц 24 цагийн дотор Улсын Их Хуралд хүргүүлдэг. Улсын Их Хурал чуулганы нэгдсэн хуралдаанаараа Цэцийн дүгнэлтийг хэлэлцээд түүнийг зөвшөөрөх эсэх тухай шийдвэр гаргадаг.

Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэсэн нийт маргааны 54.6 хувьд Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хэлэлцээд 37.0 хувийг нь хүлээн зөвшөөрч, 57.0 хувийг хүлээн зөвшөөрөхгүй тухай шийдвэр гаргасан байна. Тэдгээрийг Цэц их суудлын хуралдаанаараа хэлэлцэж эцэслэн шийдвэрлэж, Үндсэн хууль зөрчсөн хууль, холбогдох бусад шийдвэрийн зүйл, заалтыг хүчингүй болгожээ.

Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хугацаа алдаж хэлэлцэх, эсхүл огт хэлэлцэхгүй орхиж хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байснаас Үндсэн хуулийн суурь зарчим зөрчигдөхөд хүрч, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа бүрэн төгс явагдахгүй байдал заримдаа гарч байлаа. Энэ байдлыг таслан зогсоох зорилгоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, оруулах хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагчаар уламжлан парламентад өргөн мэдүүлснээр 2005 оны 6 дугаар сард уг хуульд "Үндсэн хууль зөрчсөн

гэж дүгнэлт гарснаар тухайн хууль, зарлиг, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ болон тэдгээрийн холбогдох зүйл заалтын үйлчилгээ нь Цэцийн эцсийн шийдвэр гаргах хүртэл түдгэлзэнэ. Түдгэлзүүлж эхлэх хугацааг Цэц дүгнэлтдээ тусгайлан зааж өгнө” гэсэн нэмэлт оруулсан. Хуулийн ийм зохицуулалттай болсон нь дээр дурдсан дутагдлыг арилгасан төдийгүй Үндсэн хууль зөрчсөн шийдвэр цаашид үргэлжлэн хэрэгжсээр байх боломжийг таслан зогсоох нөхцөл бололцоог бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой болсон юм. Энэ мэтээр Монгол Улсын Үндсэн хуулийг хамгаалах үйлс алхам алхмаар урагшилж байна.

Үндсэн хууль зөрчигдөж байгаа талаар Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах эрх Монгол Улсын иргэд төдийгүй Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалаагүй хүнд олгогдсон байдгаараа зарим орны Үндсэн хуулийн шүүхүүдээс ялгардаг.

Үндсэн хуулийн шүүх нь ерөнхий чиг үүргийнхээ хүрээнд хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлдгийн хувьд төрийн гурван эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хууль тогтоох бүрэн эрх бүхий байгууллагатай (парламент) илүү өргөн хүрээтэй, нягт харилцан ажиллах шаардлага үүсч байдаг. Мөн тэр хэмжээгээрээ ч тус хоёр байгууллагын хоорондын харилцаанд зөрчилдөөн үүсгэх магадлал харьцангуй их байдаг талтай. Энэ утгаараа уг асуудал нь судлаачид, эрдэмтэд, улс төрчдөөр зогсохгүй иргэдийн анхаарлын төвд байнга байдаг нэг гол сэдэв болдог.

Нөгөө талаар, хууль тогтоогчдын зүгээс Үндсэн хуулийн цэцэд хандах хандлагаас хамааран түүний эрх зүйн байдал нь эрх зүйт төрийн сонгомол түвшинд хүрч тогтоогдож чадахгүйгээр 20 жилийн нүүр үзэж байгаа нь харамсалтай байдаг. Доктор, профессор Ц.Сарантуяагийн тэмдэглэсэнчлэн үзэл санаа нь анх XIII зуунд үүсч Ж.Локк, Ш.Монтескье нар XVII-XVIII зуунаас шинжлэх ухааны эргэлтэд оруулж, өнөөдөр ардчилал хөгжсөн улс орнуудын төрийн тогтолцоонд нэгэнт тогтож хэвшээд байгаа засаглалын эрх мэдлийг хуваарилах зарчим² ёсоор төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх тэгш байдал хангагдсан байх ёстой билээ. Гэтэл Улсын Их Хурлын 2002 оны 73 дутаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэл”-д Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүдийн зэрэг зиндааг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад байгууллагын холбогдох албан тушаалтан буюу Улсын Их Хурлын дарга, гишүүд болон Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийнхээс нэг шатаар доогуур тогтоосон нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж

² Ц.Сарантуяа “Төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим ба Үндсэн хуулийн хяналт”, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (өгүүлэл, нутгийн эмхэтгэл), Ув., 2007 он, 80 дахь тал.

байгааг дурдахгүй өнгөрч боломгүй байна. Энэ нь засаглалын эрх мэдэл хуваарилах онол, зарчим хийгээд Монгол Улсын Үндсэн хуулийн заалт, шаардлагад нийцэхгүй, засаглал хоорондын тэнцвэртэй байдлыг алдагдуулж, тэдгээрийн харилцаанд зөрчил, ялгавартай, зохисгүй байдал үүсгэж, эрх зүйт төрлийн талаар олон улсад тогтож хэвшсэн дэг жаягтай зөрчилдөхөд хүргэж байгаа болно.

Үндсэн хуулийн цэцийн гадаад харилцаа

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц тулгын чулуугаа тулсан үеэс эхлэн бусад орны адил төстэй үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоон, харилцан хамтарч ирэв. Эдүгээ ХБНГУ, ОХУ, БНСУ, Австри, БНПУ, БНБУ, БНТУ, БНУУ-ын Үндсэн хуулийн шүүхүүдтэй ажил төрлийн байнгын холбоотой ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирлээ. Үндсэн хуулийн цэц Европын Холбооны Венецийн зөвлөлөөс 2009 онд ӨАБНУ-ын Кап Таун хотноо, 2011 он Бразилийн Рио де Жанейро хотноо зохион байгуулсан Үндсэн хуулийн шүүхүүдийн Дэлхий дахины Бага хурлын Их Хурлуудад оролцож улмаар 2011 оны бага хурлын анхны 30 гишүүний нэг болсон. АНУ-ын Ардчиллын төвөөс Вашингтон, Бухарест, Будапешт, Киев, Прага, Страсбург, Сан-Франциско хотноо зохион байгуулсан Олон Улсын Шүүгчдийн бага хурлууд, Жакарта, Манила, Бангкок, Улаанбаатар, Сөүл хотноо зохион байгуулсан Азийн орнуудын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн олон улсын арга хэмжээнүүдэд тогтмол оролцож ирсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц ХБНГУ-ын Ханнс Зайделын сан, Конрад Аденауэр сан зэрэг байгууллагатай хамтран ажиллаж олон улсын болон бүс нутгийн арга хэмжээг өөрийн эх орондоо амжилттай зохион байгуулжээ. Тухайлбал, 2002 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 10 жилийн ойд зориулан “Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийг сахин хамгаалах баталгаа” сэдвээр олон улсын онол, практикийн бага хурал, 2005 онд “Үндсэн хуулийн шүүх ба Улс төр” сэдвийн дор Азийн орнуудын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн 3 дугаар семинар, 2007 онд Үндсэн хуулийн цэц байгуулагдсаны 15 жилийн ойд зориулан “Монгол Улсын Үндсэн хуулийн хяналт: Төлөв байдал, цаашдын хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, 2009 онд “Үндсэн хуулийн хяналт ба Эрх мэдлийг хуваарилах нь” сэдвийн дор Азийн орнуудын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн



6 дугаар бага хурлыг тус тус зохион байгуулжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2005 онд Үндсэн хуулийн шүүх болон түүнтэй адилтгах байгууллагуудын Азийн бага хурал байгуулах санал дэвшүүлсэн юм. Чингээд манай Үндсэн хуулийн цэц Азийн нийгэмлэг байгуулах бэлтгэл хорооны ажилд идэвхтэй оролцон, 2011 оны 5 дугаар сард тус нийгэмлэгийн анхдугаар бага хурал болж, уг байгууллагыг үүсгэн байгуулагч бүрэн эрхт гишүүн болов.

Үндсэн хуулийн цэцийн санхүү

Монгол Улсын цэцийн тухай хуульд зааснаар Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож баталдаг.

Үндсэн хуулийн цэцийн урсгал зардлын төсөв 1993 онд 1,9 сая төгрөгөөр батлагдаж, 1997 онд анх 1,1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болж байсан бол 2012 оны урсгал зардлын төсөв 533.8 сая төгрөгөөр батлагдаж, 2011 оны жилийн эцсээр 1983,4 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болон бэхжиж, үйл ажиллагаагаа хараат бусаар явуулах санхүү, эдийн засгийн нөхцөл боломж тодорхой хэмжээгээр бүрдсэн гэж үзэх үндэслэлтэй болов.

Үндсэн хуулийн цэцийг санхүү, эдийн засгийн хувьд бэхжүүлэх талаар төр, засгийн зүгээс зохих анхаарал тавьж ирснийг тэмдэглэх нь зүйтэй билээ. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс 1998, 2005 онуудад 40,3 сая төгрөг гарган тоног төхөөрөмж, тавилга хэрэгслээр хангаж, 2001-2011 онд төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 1759.4 сая төгрөг олгосны дотор 2008-2009 онд Үндсэн хуулийн цэцийн барилгыг барьж ашиглалтад оруулахад зориулан 1542.8 сая төгрөг баталж өгсөн байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн албан хэрэг хөтлөлтийн болон архивын лавлагааны програм хангамжийг бүрдүүлэх, номын сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангахад зориулан ХБНГУ-ын Ханс Зайделын сан, Конрад Аденауэрын сан болон бусад зарим байгууллага, иргэдээс тодорхой хэмжээний хандив тусламж үзүүлсэн нь Үндсэн хуулийн цэцийг санхүү, эдийн засгийн хувьд бэхжихэд зохих хувь нэмэр оруулсныг тэмдэглэхгүй байхын аргагүй билээ. Энэхүү хандив тусламжийн гол нь судалгаа, шинжилгээ явуулах, номын сангийн сан хөмрөгийг нэмэгдүүлэх зэрэг оюуны үйл ажиллагааг хөгжүүлэх, дэмжихэд чиглэгдэж байсныг дурдах хэрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн үйл ажиллагааг

1996 оныг дуустал Улсын Их Хурлын Тамгын газрын санхүүгийн алба эрхлэн гүйцэтгэж байгаад 1997 оноос өөрийн санхүүгийн ажилтантай болсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай” хуульд Үндсэн хуулийн цэц ажлын албатай байхаар заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1992 оны 7 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсантай холбогдож 1992 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс Цэцийн нарийн бичгийн дарга, 1994 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс Цэцийн дотоод асуудал эрхэлсэн түшмэл, 1998 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс операторч тус тус томилогдон ажиллах болсноор дээрх хуулийн заалт хэрэгжиж, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар үүсч хөгжих эхлэл тавигдсан түүхтэй.

Тамгын газар 2010 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан бүтэц, орон тоогоор Тамгын газрын дарга, шинжилгээ судалгааны асуудал эрхэлсэн ахлах зөвлөх, ахлах зөвлөх-цэцийн хуралдааны нарийн бичгийн дарга, гадаад харилцааны асуудал эрхэлсэн референт, хүний нөөц, дотоод ажил эрхэлсэн референт, ахлах шинжээч-нягтлан бодогч, шинжээч-гишүүний туслах 4, түүнчлэн мэдээлэл, технологийн инженер, бичиг хэргийн эрхлэгч-операторч, аж ахуйн зохион байгуулагч, даргын нарийн бичгийн дарга, харуул, үйлчлэгч гэсэн үйлчилгээний албан хаагчдын орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тамгын газар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг хангах, Цэц, түүний гишүүдийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүй, судалгаа, шинжилгээ, мэдээлэл, лавлагааны асуудлаар дэмжлэг үзүүлэх, хэвийн ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй бөгөөд түүнийг дараах арга, хэлбэрээр хэрэгжүүлдэг:

- Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий мэргэжлийн мэдлэг, дадлага, туршлага бүхий хэсэг ажилладаг;

Тэрээр иргэн, холбогдох байгууллага, албан тушаалтнаас Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн талаар нотлох баримт цуглуулах, шалгалт хийхтэй холбогдуулан гишүүнээс өгсөн үүргийг биелүүлэх, холбогдох лавлагаа, мэдээлэл, судалгаагаар хангах зэрэг дэмжлэгийг гишүүдэд үзүүлж, Цэцийн хуралдааны бэлтгэлийг ханган

түүнийг хэвийн явуулахад чиглэсэн нөхцөл бололцоог бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

Иргэн, холбогдох байгууллага, албан тушаалтнаас Цэцэд хандан гаргасан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, хуваарилуулах, цэцийн шийдвэр болон бусад баримт бичгийг албажуулах, хэрэг, материалыг архивлан хадгалах, хэвлэл, мэдээллээр хангах, номын сангаар үйлчлэхээс гадна хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлж Үндсэн хуулийн цэцийн гишүүд, Тамгын газрын ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэж ажилладаг.

• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гадаад харилцааны асуудлыг эрхлэх;

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гадаад харилцаа, ёслолын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг эрхэлж, Үндсэн хуулийн цэцийн шугамаар гадаад орнуудын Үндсэн хуулийн шүүх, түүний ажлын алба болон олон улсын бусад байгууллагатай харилцан хамтран ажиллах, гадаад оронд айлчлах, гадаадаас ирэх зочин, төлөөлөгчдийг хүлээн авах ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулах, Цэцийн гадаад харилцааг хөгжүүлэхэд чиглэсэн ажил үүргийг эрхлэн гүйцэтгэдэг.

• Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлж, санхүү аж ахуйн үйлчилгээ үзүүлэх;

Цэц хөрөнгө, төсвийн хувьд хараат бус хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглүүлэн байгууллагын үйл ажиллагааны ойрын болон дунд хугацааны төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулах, эдийн засаг, хөрөнгийн чадавхийг дээшлүүлэхийн тулд төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг зохистой хэрэгжүүлэх, өмч хөрөнгийг олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, Цэцийн байрны хэвийн ажиллагааг хангаж, санхүү, аж ахуйн шаардлагатай бүх төрлийн үйлчилгээ үзүүлнэ.

Монгол Улсад хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн үүрэг

Үндсэн хуулийн цэцийн дарга,
Академич, хууль зүйн шинжлэх ухааны
доктор (Sc.D), профессор Ж.Амарсанаа



Үндсэн хуульд тусгагдсан хүний болон иргэний эрх, эрх чөлөө тэдгээрийн давуу байдлын зарчим нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлд хамаарч, тэдгээрт үүрэг болгож, хооронд нь холбож байдаг билээ. Хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, тэдгээрийг сахин биелүүлэх, хамгаалах нь төрийн үүрэг болно. Хүний болон иргэний эрх, эрх чөлөөг үгүйсгэсэн, эсхүл хохироосон хууль батлахгүй байх нь ардчилсан төрийн үүрэг билээ.

Эдгээр зарчмын заалтын хэрэгжилт нь Үндсэн хуулийн шүүхийг оролцуулан хүний болон иргэний эрх, эрх чөлөөг төрөөс хамгаалах өргөн сүлжээг тогтоох явдлаар хангагдана. Шүүх нь Үндсэн хуулийн хяналтын хүрээнд өөрийн үйл ажиллагааны зорилт, хэмжээ, аргын хувьд хүний эрхийг хамгаалах чухал чиг үүрэг бүхий байгууллага билээ. Энэхүү дүгнэлт нь Үндсэн хуулийн байгуулалтын үндсэн системд эрх, эрх чөлөө хэмээх институтийн давуу байдлыг хүлээн зөвшөөрснөөр тодорхойлогдож байна.

Барууны хуульчдын зарим бүтээлд Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, түүний ач холбогдлын тухайд Үндсэн хуулийн шүүхийн үндсэн чиг үүрэг болох эрх, эрх чөлөөг хамгаалах гол асуудал нь үгүйсгэгдэж харин “Үндсэн хуулийн манаач” хэмээх түүний чиг үүрэгт гол анхаарлаа хандуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Энэхүү үзэл бодлын гол нь

Үндсэн хуулийг хамгаалахын тулд эрх, эрх чөлөөг хязгаарлах боломжтой гэдэгт оршиж байгаа бөгөөд үндсэн эрх болон улс төрийн ашиг сонирхлын "харьцангуй байх" тухай байдлаар тайлбарлагдана. Зарим хуульч мөн эрх, эрх чөлөөг төрийн ашиг сонирхолтой эн тэнцүү зүйл хэмээн үздэг. Ийнхүү тэгшитгэх явдал буруу юм. Учир нь тэрээр хүний эрхийг улс төрийн зорилгод нийцүүлэн Үндсэн хуулиас гадуур хэрэглэх боломжийг төрд олгож байгаа билээ. Ийм учраас хүний эрхийн мөн чанарын тухай болон засаглалд тавих хяналтын нэг гол арга хэмээх түүний ач холбогдол, Үндсэн хуулийн хяналтын институтийн зорилгын тухай ойлголт нь ташаарах болно.

Үндсэн хуулийн шүүх хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад хууль тогтоох болон шүүхийн практикийн нэгдлийг хангаж байх ёстой билээ. Энэхүү хоёрдмол чиг үүрэг нь Үндсэн хуулийг хамгаалах болон хүний эрхийг хамгаалах явдал нь салшгүй гэдгийг нотолж байгаа болно. Энэ үзэл санаа нь Үндсэн хуульчилсан акт болох 1992 оны Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд тусгалаа олсон болно. Орчин үед Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхэд хүний эрх, эрх чөлөөний институтийг тодорхойлох ач холбогдол нь олон оронд хэвийн үзэгдэл болжээ.

Манай оронд ардчилсан эрх зүйт төрийн үндсийг төлөвшүүлэн тогтоох эхэн үе шатанд хүний болон иргэний эрх, эрх чөлөө Үндсэн хуулийн шүүхийн (Цэц) үйл ажиллагаанд тэргүүлэх ач холбогдолтой болох нь тодорхой юм. Тэдгээр нь хууль болон хэм хэмжээ тогтоосон бусад акт Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг шүүхээс тодорхойлох гол шалгуур нь болох юм.

Эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг Үндсэн хуулийн шүүхийн тулгуур чиг үүрэг хэмээн бид үзэхдээ Үндсэн хуулийн хувьд онцгой ач холбогдол бүхий зарчим, тухайлбал хүний эрх, эрх чөлөө нь үл шилжих, түүнд төрсөн үеэс нь бий болсон өөрөөр хэлбэл байгалиас заяагдсан гэдэгт тулгуурлана. Манай Үндсэн хуулийн хувьд шинэлэг зүйл болсон энэхүү хүний эрхийн тодорхойлолтын гүн гүнзгий агуулга нь түүний онцгой давуу байдлын статус болон түүнд тохирсон хамгаалалтын дээд түвшинг хүлээн зөвшөөрөхөд оршино.

Хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн голлох үүргийн тухай үзэл санаа нь 1990 онд Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд Үндсэн хуулийн хяналтын зөвлөл байгуулах талаар заасан үеэс уламжлагдан ирсэн байна. Түүхэн нөхцөл байдлаас үүдэн дээрх зөвлөлийг байгуулж амжилгүй, шинэ Үндсэн хуулийг 1992 онд баталсан билээ.

Үндсэн хуулийн хяналтын зөвлөл, холбоо хэлбэрийн системийн үйл ажиллагааны зарим дутагдал илт байсан тул хуучин социалист орнууд

дайны дараах Европт өргөн дэлгэрсэн загвар болон хэлбэрээр Үндсэн хуулийн хяналтын институтийг байгуулах үзэл санаа үүссэн. Энэхүү институтийн хөгжил нь Үндсэн хуулийн шүүхийг ардчилал, хууль ёсны болон хүний эрхийг зөрчих явдлаас хамгаалах найдвартай баталгааны хувьд бэхжүүлэх шаардлагатай холбоотой билээ. Ардчилсан орнуудын Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны олон жилийн туршлага нь эдгээр ололтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг явдлыг гэрчилж байна. Үүнээс үндэслэн тэдгээр нь эрх зүйт төрийн системийн салшгүй бүрэлдэхүүн хэмээн тооцогддог зохих заалтыг хэрэглээгүй явдал юм. Хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн шүүх нь мөн хүний эрх, эрх чөлөөний баталгаа болдог.

1992 онд батлагдсан Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд эрх, эрх чөлөөг хамгаалах тусгай хэрэгсэл болох иргэд гомдол гаргах журмыг тогтоожээ. Гомдол гаргах эрхийг иргэд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн эдлэх бөгөөд тэрээр өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн, эсхүл шүүх болон төрийн бусад байгууллага, албан тушаалтны шийдвэрээр хамгаалагдаагүй хэмээн үзэж гаргана. Гомдлын үндэслэл нь:

1. Үндсэн хуулийн агуулгын хүрээнд хэрэглэгдэх хэм хэмжээ тогтоосон актыг хэрэглээгүй;
2. Хэрэглэхгүй байсан актыг хэрэглэсэн;
3. Хэм хэмжээний актын Үндсэн хуульд нийцээгүй тайлбар;
4. Шууд хэрэглэх боломжтой байсан.

Үндсэн хуулийн шүүх нь өөрийн санаачилгаараа асуудлыг хянан хэлэлцэх эрхгүй, энэ нь түүний үйл ажиллагаа бодит, хараат бус байх явдлыг баталгаажуулж байна.

Шүүхийн (Цэцийн) үйл ажиллагааг улс төржүүлэхгүй байх үндэс нь улс төрийн нам, олон нийтийн байгууллага нь Үндсэн хуульд нийцэж буй эсэх тухай асуудлыг түүний эрх хэмжээний асуудлын хүрээнд оруулаагүй билээ. Энэхүү чухал заалт нь Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тусгалаа олж, түүний дагуу тэрээр зөвхөн эрх зүйн асуудлыг шийдвэрлэх болно. Дээр дурдсан зарчим нь олон орны Үндсэн хуулийн шүүхийн онцлог зарчим болдог. Улс төр болон эрх зүй хоёрыг бие биес нь салгах боломжгүй. Үндсэн хуульд төрийн үед эрх зүйгээс ангид улс төр байхгүй билээ. Улс төрийн асуудлыг хянан шийдвэрлэхийг хориглож байгаа нь юуны өмнө хууль тогтоох болон хууль хэрэглэх үйл ажиллагааны хүрээнд Үндсэн хуулийн шүүхээс хэрэгжүүлж буй хяналт нь Үндсэн хуулийн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэхээс хэтэрч

болохгүй гэсэн үг юм. Тийм ч учраас улс төрийн асуудлыг эрх зүйн асуудал болгон хувиргах боломж хязгаарлагдана. Мөн Үндсэн хуулийн шүүх нь ямар ч тохиолдолд засгийн төлөөх тэмцлийн үед болон улс төрийн тэмцлийн үед ч асуудал бүрийг хэлэлцэж, шийдвэр гаргахдаа шүүн таслах ажиллагааны хэлбэрээр хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээг баримтлан хамтын зарчмыг баримталдаг билээ. Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийг улс төрд оролцох явдлыг нь хориглох, улмаар түүний бие даасан, хараат бус байдлыг хангах, эрх зүйн маргааны хүрээн дэх бусдын нөлөөнд автаагүй “хөндлөнгийн арбитрын” нэр хүнд зэрэг нь хуулиар баталгаажсан байх учиртай. Хуулийн дагуу Цэцийн гишүүн нь улс төрийн нам, хөдөлгөөнд гишүүнээр оролцохгүй байх, улс төрийн сурталчилгаа хийхгүй, сонгуулийн компанит ажилд оролцохгүй байх нь Цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн шаардлага юм.

Хүний эрхийг хамгаалах бодит шаардлагын үүднээс Цэцийн эрх хэмжээг өргөтгөх нь зүйтэй юм. Тухайлбал, иргэн болон тэдгээрийн нэгдлээс эрх зөрчсөн тухай хувийн болон хамтын гомдлыг хянан шийдвэрлэх, бусад ердийн шүүхээс тухайн тодорхой хэрэг дээр хэрэглэж болох хууль нь Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянан шийдвэрлэх эрх байж болно.

Зарим орны туршлагаас үзвэл, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад олон орны Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны системд өргөн хэрэглэдэг хэлбэр бол тодорхой хяналт билээ. Энэ хэлбэр ёсоор ердийн болон төрөлжсөн шүүхийн асуулгын дагуу тухайн хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгадаг. Хяналтын энэ хэлбэр нь иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах боломжийг өргөтгөж байгаа учир шүүх буюу хууль хэрэглэх байгууллагын өргөн хүрээг энэ үйл ажиллагаанд татан оролцуулж байна.

Тодорхой хяналтын хэлбэрийг ашиглах бусад орны туршлага дээр тулгуурлаж, хүний эрхийг хамгаалахад түүний үр ашигтайг харгалзан Үндсэн хуульдаа Үндсэн хуулийн хяналтын системд шүүхийн асуулгын дагуу хуулийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах шинэ хэлбэрийг оруулсан байдаг байна. Жишээлбэл,

Оросын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 101 дүгээр зүйлд: “шүүх хэрэг хянан шийдвэрлэж байгаа үе шатандаа тухайн хэрэгт хэрэглэсэн, эсхүл хэрэглэх хууль нь ОХУ-ын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн шүүхэд хандаж тухайн актыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах талаар асуулга тавина” гэжээ. Асуулга тавьсан үр дагавар бол Үндсэн хуулийн шүүхэд асуулга тавих шийдвэр гарсан үеэс эхлэн тус шүүхээс шийдвэр гарах хүртэл тухайн

хэрэгтэй холбогдон хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүхээс гаргасан шийдвэрийг гүйцэтгэхийг түдгэлзүүлнэ. Түүний гол агуулга нь иргэний болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалах болон сахин биелүүлэх Үндсэн хуулийн зарчмыг хэрэгжүүлэх, мөн шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлэхэд Үндсэн хуульт ёсыг бэхжүүлэх, үүгээрээ шүүхийн ажиллагааны бүх оролцогчдод нөлөөлдөг гэж үздэг байна.

Тодорхой хяналтын хэлбэр нь шүүхээс хэргийг хянан шийдвэрлэхдээ хүний эрхийг хамгаалах талаас холбогдох хуулийн хамгийн оновчтой дүгнэлтийг хайж олоход чиглэнэ. Тодорхой хяналтын ажиллагааг хэрэглэх явцад барууны онол болон шүүхийн практикт дараах үзэл тогтжээ. Тухайн хэрэглэж байгаа хуулийг тайлбарлахад хэд хэдэн хувилбар гарч байгаа бол хүний эрх, эрх чөлөөний хамгаалалтыг бататгаж байгаа бөгөөд тэдгээрийг зөрчихгүй байх хувилбар нь давуу эрхтэй. Хэм хэмжээний заалт нь хоёрдмол агуулгатай байгаа бол хамгийн эерэг үр дагавар үзүүлэх тэр агуулгаар ойлгоно.

Манай оронд эрх зүйн бүх салбарт шинэтгэл хийж, хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт орж байгаа энэ нөхцөлд шүүхийн асуулгаар хийгдэх Үндсэн хуулийн хяналт нь их ач холбогдолтой билээ. Тухайн хэргийг хянан шийдвэрлэх явцдаа ердийн шүүх хэрэглэх гэж байгаа хууль нь Үндсэн хуульд нийцсэн байдалд хяналт тавих асуудлыг Цэцгийн хуульд оруулбал хүний эрхийг хамгаалах чухал хүчин зүйл болох юм.

Хэрэглэж байгаа хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа талаар асуулга тавих эрхийг хэрэгжүүлэх нь эрх зүй болон хуулийг ялгах асуудлыг аль ч шүүхийн өмнө тавьж байдаг. Эрх зүйт төрлийн үзэл баримтлалын хүрээнд ардчилсан ололтод өөрийн агуулгаараа нийцэж байх ёстой хуульд тулгуурлана. Хүний эрх нь эрх зүйн орчны үндэс болох ёстой, өөрөөр хэлбэл эерэг хууль тогтоомжийн бүх хүрээ хүний эрхийн талаасаа хэмжигдэж, "хүмүүнлэг шалгуур" авах ёстой. Үүнээс үзэхэд тэдгээр нь төрийн засаглах чиг үүргийн дээд хууль ёсны эх сурвалж болдог.

Үндсэн хуулийн хяналтын байгууллагын эрх хамгаалах үйл ажиллагааны нэг гол хандлага бол эрх, эрх чөлөөг хязгаарлах асуудал болон ийнхүү хязгаарлалтын хүрээ билээ. Тухайлбал Үндсэн хуулиар хууль тогтоогчид тодорхой хязгаар хүрээний дотор хэрэгжүүлэх нөхцөл, журам, хамгаалалтын баталгаа, хариуцлагын хэлбэрийг заасан хүний эрхийг зохицуулах үүрэгтэй холбогдох хууль болон хэм хэмжээний бусад акт батлан гаргах бүрэн эрх олгодог.

Эрх, эрх чөлөө үйлчлэх хүрээ хязгаарыг тогтоох чадал бол хууль зүйн системийн хамгийн хүндрэлтэй асуудлын нэг билээ. Үүнийг шийдвэрлэхдээ

хууль тогтоогч Үндсэн хуулийн зарчим, хэм хэмжээг баримтална. Хууль тогтоогчоос хийж байгаа хязгаарлалт нь Үндсэн хуулийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг байдаг. Үндсэн хуулийн хязгаарлалт нь хувь хүний хамгаалагдах боломж, эрх чөлөөний түвшинг тодорхойлох шалгуур гэж үзэх юм бол Үндсэн хуулийн шүүх дээр дурдсан хязгаарлалт нь эрх зүйт төр, ардчиллын зарчим, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд хэрхэн нийцэж байгааг хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүх болон хүний эрхийн асуудлаарх бүсийн болон олон улсын байгууллагын практикт эдгээр хязгаарлалт Үндсэн хуульд нийцэж байгааг тодорхойлох зарчим, үзэл баримтлалын үндэс тогтоогдсон байна. Тэдгээрийн нэг нь хуулиас ишлэл хийх явдал юм. Энэ зарчим ёсоор хүний эрх, эрх чөлөөний хэм хэмжээний зохицуулалт болон тэдгээрийн хязгаарлалт нь хуулиар тогтоогдож, эдгээр хуульд оруулж байгаа хязгаарлалтын хэмжээ боломж нь Үндсэн хуулийн ерөнхий заалтад нийцсэн байна. Өөр нэг чухал зарчим бол эрх, эрх чөлөөг хэтэрхий хязгаарлахыг хориглох, тэнцвэртэй байлгах явдал юм. Түүний агуулга нь Үндсэн хуулийн дэг журамд аюул учруулах явдал нь тийнхүү бодитой болсноос хууль тогтоогчийн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үүрэг нь бий болсон аюултай тэнцвэржиж байгааг илрүүлэх явдал юм.

Үндсэн хуулиар агуулгыг нь нарийсгасан, шууд тайлбарлаагүй тийм эрх, эрх чөлөө онцгой хүндрэл маргааныг учруулдаг. Энэ байдлаас гарах аргыг гадаадын хэд хэдэн орны Үндсэн хуулийн шүүх эрх, эрх чөлөөний агуулгын мөн чанарыг хадгалах зарчмаар илэрхийлж байна. Түүний агуулга нь хэтэрсэн хязгаарлалтын эсрэг эрх зүйн хамгаалалтын нэмэлт баталгаа болж байна. Энэ шаардлага эрх, эрх чөлөөний агуулгын мөн чанарыг хангахад зориулагдсан бөгөөд тэрээр эдгээр эрхийн “хоосрох” аюулын хаалт, парламентаас хүний эрх, эрх чөлөөний агуулгыг “гүйгсгэсэн” хязгаарлалтыг оруулж болзошгүй явдлаас хамгаалах зорилгоор олон хууль руу ишлэл татахаас хамгаална. Үүнээс үзэхэд хязгаарлалт нь аль болох бага байж, онцгой хязгаарлалт огт байхгүй байна.

Энэ үйл ажиллагааны онол, практик нь эдгээр төрлийн хязгаарлалт нь улс орон бүрийн оршин тогтнох онцлог нөхцөлөөс шалтгаалан улс бүр бие дааж тогтооно. Гэвч орчин үед олон улсын нийгэмлэг энэ асуудлыг улс орны дотоод эрх хэмжээний хүрээнээс гаргаж байна. Хүний эрхийн талаарх олон улсын үндсэн баримт бичиг ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай, боломжтой хүрээг тодорхойлж байна. Энэхүү хязгаарлалт нь ерөнхий хязгаарлалтын нөхцөл, зорилго, хүрээг тодорхойлсон байна. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүний эрхийн тухай олон улсын Пактад боломжийн хязгаарлалтын үндэслэл нөхцөлийг заажээ.

Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны дээр дурдсан зарчим нь хууль руу иш татах, агуулгын мөн чанарыг хадгалах, зохистой байдлын зарчим, хэтэрсэн хязгаарлалтыг хориглох зэрэг ардчилсан нийгэмд зайлшгүй бөгөөд боломжтой хязгаарлалтын тухай олон улсын эрх зүйн хэм хэмжээнд бүрэн нийцэж байна.

Хязгаарлалтын зарим асуудал олон улсын баримт бичигт илүү тодорхой зохицуулагдаж байна. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрх болон ажил хаях эрхийн тухай зааж зөвсөгт хүчний, цагдаагийн болон төрийн захиргааны бүрэлдэхүүнд ордог этгээдийн хувьд дээр дурдсан эрхийн хязгаарлалтыг хуулийн дагуу оруулахад энэ зүйл саад болохгүй юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад шилжин явах, оршин суух газраа чөлөөтэй илэрхийлэх зэрэг асуудлаарх боломжийн хязгаарлалтын жагсаалт агуулагдаж байна. Тэдгээрт хууль тогтоогдсон бөгөөд нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахуун бусад этгээдийн эрх, эрх чөлөөг хамгаалахад шаардлагатай хязгаарлалт хамаарна. Адилтгасан шалгуурыг өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хурал, цуглаан чөлөөтэй явуулах эрхийн хувьд тогтоосон. Эдгээр баримтлалын дагуу Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт хүний эрхийн хязгаарлалтын боломжтой заагийг тогтоосон байна.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад гол зүйл бол хязгаарлалтыг хортойгоор ашиглах явдлыг гаргуулахгүй байх асуудал юм. Мюллерсоны тэмдэглэж байгаагаар хувь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нь ямагт өөртөө аюулыг агуулдаг, хортойгоор ашиглахгүй юм гэхэд хамгаалж буй нийгмийн ашиг сонирхолтой харьцуулахааргүй хязгаарлалтын арга хэмжээг тогтоох явдал юм.

Ийнхүү хортойгоор ашиглах явдал гаргахгүй байх нэг арга зам нь харьцангуйн зарчим бөгөөд түүнээс урган гарах хэтэрсэн хязгаарлалтыг хориглох томьёолол юм. Хууль тогтоох, хууль хэрэглэх үйл ажиллагааны явц дахь хориглох үндэс нь Хүний эрхийн тухай олон улсын баримт бичиг юм. Үндсэн хуулийн дагуу тогтоогдох боломжтой хязгаарлалт нь өөрийн агуулга, хэмжээгээрээ оруулж буй хязгаарлалтын зорилгод нийцэж, эрх зүйн адил тэнцүү боломжийг хамгаалахад зориулагдана. Хэрэглэж буй хамгаалалтын хэрэгсэл нь шаардлагатай, оновчтой, зохистой байх ёстой. Үндсэн хуулийн хяналтын системийг үр ашигтай болгохын тулд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн үр дагавар болон түүнийг хэрэгжүүлэх механизм нь чухал ач холбогдолтой.

Шилжилтийн үед Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх асуудал онцгой хурцаар тавигдаж байна. Үндсэн хуульд ёс, Үндсэн хуулийг дээдлэх болон хуулийг сахин биелүүлэх, хүний боломж иргэний эрх, эрх чөлөөг хамгаалах явдлыг хангах шаардлагаас урган Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадлыг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтлана: Нэгдүгээрт, түүний шийдвэр заавал биелэгдэнэ. Хоёрдугаарт, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийн бөгөөд давж заалдахгүй. Гуравдугаарт, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гармагц буюу тэдгээрийг уншин сонсгосон үеэс эхлэн хүчин төгөлдөр болно. Үндсэн хуулийн шүүхээс гаргасан тогтоолд тусгайлан хутагаа заагаагүй (манай орны хувьд бол шууд биелүүлэх шинжтэй) бол тэдгээрийг нэн даруй биелүүлэх зарчим үйлчилдэг. Шийдвэр нь шууд үйлчилж бусад байгууллага, албан тушаалтны баталгаа шаардахгүй билээ.

Үндсэн хуулийн шүүх өөрийн тогтоолдоо актыг хүчин төгөлдөр бус гэж тооцсоны улмаас зохицуулалтгүй үндсэн харилцааг зохицуулахаар шинээр хууль гаргах, эсхүл үйлчилж байгаа хууль тогтоомжид шаардлагатай өөрчлөлт оруулахыг өөрийн тогтоолдоо хууль тогтоогчид зөвлөмж болгодог явдлаараа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр чухал үүрэг гүйцэтгэдэг. Үүнийг манай Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд дорвитой нэвтрүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Улмаар шүүх шинээр гарах хуулийн үндсэн заалт, агуулгын хүрээг тодорхой тогтоодог нь ч бидний сонирхлыг татаж байгаа билээ. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хэлбэрэлтгүй биелүүлэх явдлыг хангах нөхцөл бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд саад болсон тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагыг тодорхой тусгах явдал юм. Энэхүү хариуцлагыг хуулиар тогтоож, хариуцлага хүлээлгэх журам, төрлийг заах нь зүйтэй. Энэхүү хариуцлагыг бас Эрүүтийн болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн тусгайлан хэм хэмжээгээр зохицуулж болно. Бусад орны туршлагатай харьцуулахад манай орны хууль тогтоомж нийм төрлийн хариуцлагыг агуулаагүй билээ. Хууль тогтоомжид байгаа энэ зохицуулалтгүй асуудлыг арилгах хэрэгтэй. Учир нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг биелүүлэх ажил амьдрал дээр хүндрэл учирч байна. Үүнийг Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн талаар Үндсэн хуулийн цэцийн гаргасан (2000 он) дүтнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэхгүй удааж байснаар жишээлэн тайлбарлаж болно.

**Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг.
Хүний эрх, эрх чөлөө**

Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусинулахыг хатуу хориглоно; амьд явах эрхтэй.	16.1.	0	0
эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;	16.2.	2	2, 4
хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлцө;	16.3.	14	16.5
ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;	16.4.	6	7, 1
өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;	16.5.	5	5, 9
эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;	16.6.	3	3, 5
сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;	16.7.	0	0, 0
соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;	16.8.	0	0, 0


шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;	16.9.	6	7, 1
нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;	16.10.	5	5, 9
улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх няхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;	16.11.	2	2, 4
төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;	16.12.	4	4, 7
халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бүс, хэрцүү хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хутацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;	16.13.	9	10, 6

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн тусалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиглагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, үзлэл хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;	16.14.	26	30,6
шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;	16.15.	1	1, 2
итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;	16.16.	1	1, 2
төр, түүний байгуулагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгуулага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;	16.17.	0	0, 0
улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.	16.18.	1	1, 2
	Нийт	85	100,0

[illegible]

Заяг	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	Нийт
16.1.									0
16.2.					зөрчөөгүй 1	зөрчөөгүй 1			зөрчөөгүй- 2
16.3.		зөрчсөн 1, зөрчөөгүй 1	зөрчөөгүй 1			зөрчөөгүй 1	зөрчөөгүй 2	зөрчөөгүй 2	зөрчсөн- 1, зөрчөөгүй- 13
16.4.			зөрчөөгүй 1	зөрчөөгүй 1		зөрчөөгүй 1			зөрчсөн- 1, зөрчөөгүй- 5
16.5.								зөрчсөн 1, зөрчөөгүй 1	зөрчсөн- 3, зөрчөөгүй- 2
16.6.			зөрчөөгүй 1					зөрчсөн 1, зөрчөөгүй 1	зөрчсөн- 1, зөрчөөгүй- 2
16.7.									0
16.8.									0
16.9.		зөрчсөн 1			зөрчсөн 1, зөрчөөгүй 1	зөрчсөн 1			зөрчсөн- 3, зөрчөөгүй- 3
16.10.		зөрчсөн 1		зөрчөөгүй 1	зөрчөөгүй 1	зөрчсөн 1		зөрчөөгүй 1	зөрчсөн- 2, зөрчөөгүй- 5
16.11.							зөрчөөгүй 1		зөрчөөгүй- 2
16.12.	зөрчөөгүй 2		зөрчөөгүй 1						зөрчсөн- 1, зөрчөөгүй- 3
16.13.					зөрчөөгүй 1		зөрчөөгүй 1		зөрчсөн- 2, зөрчөөгүй- 7
16.14.	зөрчөөгүй 2	зөрчсөн 1, зөрчөөгүй 1	зөрчсөн 3, зөрчөөгүй 3	зөрчөөгүй 3	зөрчсөн 2, зөрчөөгүй 1				зөрчсөн- 12, зөрчөөгүй- 14
16.15.									зөрчсөн- 1
16.16.									зөрчсөн- 1
16.17.									0
16.18.					зөрчөөгүй 1				зөрчөөгүй- 1
									зөрчсөн- 28, зөрчөөгүй- 59

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн заалт
бүрийн эзлэх хувь



Үндсэн хуулийн хяналт, ойлголт, чиг хандлага

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн
орлогч дарга, хууль зүйн доктор (Ph.D),
профессор Н.Жанцан



1992 оны Монгол Улсын Үндсэн хууль бол бидний амьдарч буй энэ зууны гол ололт, амжилтын нэг мөн. Түүний үнэ цэнийг ойлгож хайрлан хамгаалах ёстой. Хэрвээ бид ингэж чадваас Үндсэн хуулиа дээдэлж улмаар төрөө дээдлэх болно. Энэ бол Үндсэн хуулийг хэрэгжүүлэх бүх субьектэд хамааралтай юм.

Үндсэн хуульд Монголын ард түмний хүсэн мөрөөдөж байсан бүх эрх, эрх чөлөө түүнийг хамгаалах баталгаа тусгалаа олсон байдаг. Түүнчлэн төрийн эрх мэдлийг хуваарилах дэлхийн жишиг, чиг хандлага тусгалаа олсон юм. Дэлхийн аль ч орны Үндсэн хуулийг нэг загварын эрх зүйн эх сурвалжийн хуулбар гэж үзэж болохгүй. Түүнд заавал улс орны үндэсний эрх ашиг, түүний онцлог, өвөрмөц болон уламжлалт шинж тусгалаа олсон байдаг. Ийм онцлогийг Монгол Улсын Үндсэн хуулиас олныг олж харж болно.

Үндсэн хууль бол бүрэн эрхт улсын эрх зүйн системийн үндэс болдог. Тэр орны Үндсэн хуулиас ардчилсан эрх чөлөө, төрийн эрх мэдлийн хуваарилалт, өмчийн хараат бус байдал бүгдийг харж болно. Мөн Үндсэн хууль найдвартай хэрэгжих баталгаа буюу Үндсэн хуулийн хяналтыг олж харж болно. Үндсэн хууль хэрэгжих баталгаанаас нь хамаарч “Амьд Үндсэн хууль” гэсэн ойлголт, хэллэг Үндсэн хууль судлалын салбарт гарсан байдаг.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн нэг түүхэн гавьяа бол Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болсон Үндсэн хуулийн

цэц буюу Үндсэн хуулийн шүүхийг бий болгож түүний бүрэн эрхийг хуульчилсан явдал мөн. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц хий хоосон орон зай дээр үүсээгүй. Юуны өмнө хүн төрөлхтний эрх зүйн соёлын ололтод тулгуурлаж үүссэн гэж үзэж болно. Үндсэн хуульд ёсны олон жилийн түүхтэй дэлхийн олон оронд Үндсэн хуулийн шүүх байгуулагдан ажилааж ирсэн бөгөөд ялангуяа Үндсэн хуулийн шүүх байгуулагдах их шуурга Европын орнуудыг хамарсан түүхэн цаг үед манай Үндсэн хууль боловсрогдсон явдал төрийн энэ чухал институтын хүлээн зившнөргдөх нэг үндэс болсон байх магадлалтай.

Дэлхий дахинд Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан өнгөрсөн үеийн түүх бол энэ институтын зайлшгүй хэрэгцээтэй болохыг батлан харуулсан түүх юм. Үндсэн хуулийн шүүхийг өөр бусад ямар нэг байгууллагаар төлөөлүүлж болохгүй учраас дэлхийн ихэнх оронд түүний бүрэн эрх адил төстэй хуульчилагдсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол ардчиллын бүтээл боловч түүнийг ардчилсан реформтой нас чашуу гэж хэлж болно. Хүн төрөлхтний хөгжилд даяаршил зарим бодит үр нөлөө үзүүлдэгийн нэг жишээ бол Үндсэн хуульд ёсонд хандах хандлага, хууль дээдлэх соёлыг түгээх эрхэм зорилго хэрэгжих үүднээс Үндсэн хуулийн хяналт дэлхий даяар хаягаа тэлж буйд оршино. Үүнийг Үндсэн хуулийн хяналтын байгууллага болох Үндсэн хуулийн шүүхээр жишиг болгон тайлбарлаж болох юм. Нөгөө талаар Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хууль хэрэгжих баталгаа болж буй агуулгаараа Монгол төрийн дархлааны суурь үндэс болдог.

Дэлхий дахинд Үндсэн хуулийн хяналтын шинэ эрэн эхэлж байна. Үүнийг дэлхийн ихэнх орны Үндсэн хуулийн шүүх 30 хүрэхгүй настай байгаатай холбон тайлбарлаж болох юм. Европын ардчилалын стандартад Үндсэн хуулийн шүүхийн роль маш өндөрт тавигдаж байгаа бөгөөд эдүүгээ Европын ихэнх орны төрийн тогтолцоонд хүчтэй Үндсэн хуулийн шүүх хүндтэй бөгөөд чухал байр суурь эзэлж байна.

Гэхдээ Европын орнуудын Үндсэн хуулийн шүүхийн хувь заяа тэр бүр дардан замаар яваагүй. Хүчтэй ерөнхийлөгчийн засаглалын үед эрх мэдэл дарангуйлалын шинжийг агуулсан нөхцөлд Үндсэн хуулийн хяналт хэрэгжих боломжоо алддаг тохиолдлууд гардаг байна. Тухайлбал, Казахстан Улсад Европын орнуудын жишгээр анх байгуулагдсан Үндсэн хуулийн шүүх хүчин чадал, эрх мэдлийн хувьд илтэд буурч Үндсэн хуулийн зөвлөл болон хувирсан бол Киргиз Улсын Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл хуваарилалтын зөрчилдөөний улмаас бүрэн хэмжээгээр татан буугдсан байна. Түүхэн тодорхой нөхцөлд ардчиллаас ухарсан ухралт засагдах нь үнэн боловч түүнийг хор уршгийг эцэст нь ард түмэн амсдаг

болохоор илэрхий алдаанаас сургамж авах нь чухал байдаг.

Түүнчлэн парламентын засаглалтай орнуудад ч хэмжээгүй эрх мэдэл хүсэх, хяналтаас ангид байх, Үндсэн хуулиас давсан эрх мэдэл авах хүсэл эрмэлзэл шийдвэр гаргагчдын түвшинд байсаар байдаг нь нууц биш юм.

Үндсэн хуулийн шүүх ялангуяа түүний шийдвэр эрх баригч бүхэнд таалагдах нь тийм ч элбэг биш боловч ардчилалын тулгуур эрх ашгийг хамгаалагч хэн бүхний эрх ашигт ч нийцэж байгаад түүний мөн чанар оршиж байгаа юм.

Үндсэн хуулийн зөрчил нь хууль, эрх зүйн хэм хэмжээ тогтоогчдын зүгээс санаатай, санамсар болгоомжгүй, Үндсэн хуулийг ойлгох ойлголтын зөрүүгээс зэрэг олон шалтгаантай боловч түүний эцсийн үр дүн нь Үндсэн хуулийн зөрчил байдаг болохоор алдааг нь зайлшгүй засагдах нөхцөлийг баталгаажуулах нь ардчиллын төгс шинж болдог.

Үндсэн хуулийн хяналт яригдах бүрт төрийн эрх мэдэл хуваарилалт байнга хөндөгддөг нь санамсаргүй зүйл огт биш. Эрх мэдэл хуваарилалтын эх сурвалж нь аль ч оронд Үндсэн хууль байдаг. Гэтэл Үндсэн хуулиар олгосон эрх мэдлийг өргөтгөх эсхүл бусдын эрх мэдлээс танах, хүрээ хэмжээнээс халих аль аль нь Үндсэн хуулийн хяналтад өртөх учиртай. Хэрвээ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрүүдийг анхааралтай судалбал Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдэл хуваарилалтын хүрээнээс хальсан, эрх мэдэл нэмж авсан цөөнгүй шийдвэр хүчингүй болсоныг олж харж болно. Жишээ нь, гүйцэтгэх засаглалын хөрөнгө мөнгө зарцуулах эрх мэдлийг Улсын Их Хурлын гишүүн эдлэх нь Үндсэн хуулиар олгогдсон эрх хэмжээнээс давж буй зүйл мөнөөс гадна хууль тогтоох эрх мэдлээ өөрсдөдөө ашигтайгаар урвуулж байгаа явдал гэж үзэх учиртай.

Нөгөө талаас, Улсын Их Хурлын гишүүд өөрсдийн сонгуулийн тойрогт хөрөнгө мөнгө хуваарилж түүнийгээ өөрсдөө зарцуулах нь сонгуульд тэгш, шударга өрсөлдөх зарчимд ч харшилж байгаа зүйл мөн. Иймд эрх мэдэл хэрэгжүүлэх хүрээ ч торгон ирмэгтэй байдагт эргэлзэх ёсгүй юм. Эрх мэдэл хуваарилах зарчим нь эрх мэдэл бүхий субъектүүдийн харилцан хамаарлыг бас давхар баталгаажуулдаг юм. Мөн түүнчлэн төрийн эрх мэдлийг Үндсэн хуулиар хуваарилан тогтоож өгөх нь мөн чанартаа дарангуйлалын засаглал бий болохоос сэргийлэх агуулгатай байдаг.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр Үндсэн хуулийг ойлгох ойлголтыг нэгэн зүгт тодорхойлж өгдөгнөрөө онцгой ач холбогдолтой. Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэрээс гадна Үндсэн

хууль эврчөөгүй гэсэн шийдвэр ч Үндсэн хуулийг ойлгох ойлголтод жишиг тогтоож өгдөг. Тийм ч учраас дэлхийн аливаа улс оронд Үндсэн хуулийн шүүхийн бүхий л шийдвэрт анхааралтай хандан эрх мэдлийн бүх хүрээнд судалж байдаг билээ.

Үндсэн хуулийн шүүхийн хүчин чадал нь түүний шийдвэрийн биелэлтээр хэмжигддэг. Эрх зүйн соёл өндөр хөгжсөн орнуудад Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр биелэхгүй байх тухай ойлголт байхгүй бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг Үндсэн хуультай эн чашуу хүчин чадалтай хэм хэмжээ гэж үздэг.

Монгол Улсын Үндсэн хуульд Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болох тухай заасан нь түүний дээд хүчин чадлыг илтгэн харуулж байгаа юм.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гаргах нь шүүгчдээс зөвхөн мэргэжлийн ур чадвар шаардаад зогсохгүй нэлээд тохиолдолд иргэний эр зоригийн шалгуур болдог. Тийм ч учраас Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн улс төр, эдийн засгийн баталгаа, хараат бус байдлыг нарийн чамбай хуульчилж өгөх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг хуульчилан тогтоосон боловч түүнийг хараахан төгс гэж үзэх боломжгүй юм. (энэ тухай жич өгүүлэх болно)

Үндсэн хуулийн хяналт бол Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн Үндсэн хууль амьд үйлчлэх эрх зүйн баталгаа юм. Ийм учраас Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх онцгой субъект болох Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ, чадавхыг Үндсэн хуулийн хүрээнд зөв ойлгож хэрэгжүүлэх явдал Монгол Улсын Үндэсний эрх ашгийн салшгүй хэсэг гэж үзэх ёстой. Үндсэн хуулийн цэцийн нэг үндсэн чиг үүрэг нь үндэсний эрх зүйн тогтолцоонд Үндсэн хууль ёсыг тогтооход орших бөгөөд энэ нь түүний шийдвэр, шийдвэрийн хэрэгжилтээс үлэмж хамааралтай юм. Хууль тогтоогчоос Үндсэн хуулийн цэц өөрийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн төлөө хөөцөлддөг механизмыг хуульчилан тогтоогоогүй бөгөөд энэ нь дэлхийн олонх орны хууль дээдлэх эрх зүйн соёлоос улбаатай гэж үзэж болно. Хэрвээ Үндсэн хуулийн хяналтыг хүлээн зөвшөөрч байгаа бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гармагцаа хэрэгжих нь эрх зүйн соёлын энгийн цагаан толгой бөгөөд ийм эрх зүйн соёлын төвшинг манай Үндсэн хууль хүлээн зөвшөөрсөн болохыг хууль хэрэгжүүлэгч бүхэн ухамсарлах учиртай.

Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо чухал рольтой болох тул түүнд ямагт хүндэтгэлтэй хандах ёстой. Үндсэн хуулийн цэцэд хандаж буй иргэний гомдлыг хэзээ ч тухайн хувь хүний

эрх ашиг гэж ойлгож болохгүй түүний цаана адил төстэй олон олон иргэдийн эрх ашиг байгаа гэж ойлгох нь илүү зохистой. Монгол Улсын Үндсэн хуулиар Үндсэн хуулийн хяналтын хүрээнд иргэдэд олгосон эрх хэмжээнд давуу тал байдаг. Энэ нь иргэн Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн асуудлаар зөвхөн өөрийн эрх ашиг хөндөгдсөн эрх хэмжээний хүрээнд биш нийгмийн эрх ашиг хөндөгдсөн гэж үзсэн аль ч асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хандах эрх хэмжээ нээлттэй байдагт оршино. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийг хамгаалахад иргэн бүхэн оролцох боломж нээлттэй бөгөөд мэдээж Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх эрх хэмжээний хүрээнд уг өргөдөл, мэдээлэл, гомдол гарсан байх учиртай.

Үндсэн хуулийн хяналт, Үндсэн хуулийн эрх хэмжээг боловсронгуй болгоход чиглэсэн хангалттай олон асуудал бидний өмнө байна. Юуны өмнө Үндсэн хуулийн хяналтыг тасралтгүй амьд байлгах, Үндсэн хуульт ёс, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг баталгаажуулах, түүнчлэн Үндсэн хуулийн эрх зүйн онолын түвшинг дээшлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Хэрвээ Үндсэн хуулиа дэлхийн түвшинд боловсрогдсон гэж үзвэл түүнийг хэрэгжүүлж буй, хамгаалж буй субъектүүдийн эрх хэмжээ, эрх зүйн соёл, мэдлэг боловсрол ч мөн тэр түвшинд байхыг өсөн урагшилж буй нийгмийн хэрэгцээ шаардаж байгаа юм.

Үндсэн хууль бол хөдөлшгүй буюу засагдашгүй эх сурвалж бас биш. Гэхдээ Үндсэн хууль бол нэг талаас нийгмийн тогтвортой байдлын баталгаа болдог тул түүний мөн чанарыг хагас дутуу ойлгоод хөнгөн хийсвэр хандах эсхүл аливаа эрх баригч бүлэглэл өөрсдийн явцуу эрх ашигт тохируулан өөрчлөх эрх байхгүй бөгөөд тийм боломжийг Үндсэн хууль өөрөө хаасан байдгийг зайлшгүй анхаарах нь чухал. Үндсэн хуульд Үндсэн хуулийн бус аргаар халдахаас хамгаалах нь Үндсэн хуулийн хяналтын нэг гол зорилго байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн процессын эрх зүйн тулгамдсан асуудал



Үндсэн хуулийн цэцийн гишүүн, хууль
зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D),
профессор Ц.Сарантуяа

Монгол Улс төрт ёсны хоёр мянга гаруй жилийн арвин түүхтэй ч 1921 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын дараахан 1924 онд анхны Үндсэн хуулиа баталж бүгд найрамдах засаг тогтоож ардчилсан төрийн анхны үр хөврөлийг суулгасан. Үүний дараагаар түүхэн богино хугацаанд буюу 1940 болон 1960 онуудад хоёр удаа Үндсэн хууль баталсан ч социалист системийн түүхэн замнал, номнол, улс төрийн бодлогын нөлөөгөөр гол мөн чанараа алдаж, хэлбэрдэл хамгийн дээд цэгтээ хүрсэн гашуун түүхийг үлдээсэн.¹

Оновчтой засаглал, хариуцлагатай төр, эрх чөлөө, шударга ёс, энэрэнгүй нийгмийг бүтээн босгохдоо сорилт, бэрхшээл, ололт, амжилтыг хослуулан байж 1992 онд монгол түмэн цоо шинэ хэв загварын Үндсэн хууль баталсан. Энэ хууль зах зээлийн нийгэм, ургальч үзэл, бодит эрх чөлөөг баталгаатай хангах зорилготой суурь хууль билээ.

Шинэ Үндсэн хууль бидэнд хүн төрөлхтний жам ёсны хөгжилтэй хөл нийлүүлэх боломж олгон, эрх зүйт нийгмийн үндсэн зарчмуудыг хуульчлахдаа тэдгээрийг хамгаалах арга хэрэгслийг давхар зохицуулж Үндсэн хуулийг тунхаглал биш, харин ч бодит амьдралд хэрэгждэг хууль болгон өөрчилснөөрөө гавьяатай.

Салбарын аль ч хууль зөрчигдөхөд шүүхэд хандан зөрчлийг арилгах боломжтой атал Үндсэн хууль зөрчигдсөн эсэхийг шүүн хэлэлцэх боломжгүй бол түүнийг бусад бүх хуулийн эх сурвалж гэж үзэх үү? Түүнийг хамгаалахгүй бол дээд хүчин чадалтай хууль байж чадах уу?

Үгүй гэдгийг түүх өгүүлж европ, америк, африк, ази тивд өөр өөрийн онцлогтойгоор Үндсэн хуулиа хамгаалдаг болсон. Тив дэлхийн дийлэнх улсад эцсийн шийдвэр гаргадаг байгууллага Үндсэн хуулийн манаанд зогсож Үндсэн хууль зөрчигдсөн эсэхэд албан ёсоор хариу өгч, үүгээрээ Үндсэн хуулийг албан ёсоор тайлбарладаг байна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хянах өөр байгууллага гэж байдаггүй, ийм ч учраас түүний дээр “хөх тэнгэр байдаг” хэмээн европчууд хэлдэг ба энэ хэллэг манай хуульчдын дунд ч нэгэнт танил болжээ.

Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалдаг байгууллага бий болж Үндсэн хууль зөрчигдсөн талаар эцсийн шийдвэр гарах болсон тэр цаг хугацаанаас эхлэн аливаа үндэсний эрх зүйн тогтолцоо Үндсэн хуулийн процессын эрх зүйгээр хүрээгээ тэдгэг зүй тогтолтой. Манай улсад Үндсэн хуулийн маргааныг эцэслэн шийдвэрлэх болсноос хойш 20 дахь жилтэйгээ золгож байна. Үндсэн хуулийн процесс de-facto болон de-jure үүсч бий болсноос хойш салбар эрх зүйн хувьд зохицуулалт арвинтай, шинжлэх ухааны хувьд судлагдахуун ихтэй болсон байна.

Үндсэн хууль нь ард түмэн ба төрийн хооронд байгуулсан гэрээ бөгөөд хоёр гол хэсгээс бүрдэнэ. Нэг дэх хэсэг нь үндсэн эрх, хоёр дахь нь төрийн байгуулал. Иргэн Үндсэн хуульд заасан эрхийг баталгаатай эдлэх эрхтэй болохыг, төрийн эрх мэдлийн байгууллага тэдгээр эрхийг иргэнд эдлүүлэх үүрэгтэй бөгөөд зөвхөн үндсэн хуульд заасан эрх хэмжээг эдлэх эрхтэй болохыг энэ гэрээ гэрчилнэ. Ийм зүй тогтолтой тул иргэн хүн Үндсэн хуулийг зөрчих боломж хэзээ ч байхгүй бөгөөд үндсэн хуулийн шүүхэд хариуцагчаар дуудагдахгүй.

Үндсэн хуулийг зөвхөн төр, түүний албан тушаалтан л зөрчих магадлалтай. Иймд Үндсэн хуулийн маргааныг шүүхийн журмаар шийдвэрлэх эрх, үүрэг бүхий Монгол Улсын Үндсэн хуулийн цэц эрүү болон иргэний эрх зүйн биш, харин нийтийн эрх зүйн маргаан шийдвэрлэх эрх, үүрэг бүхийн Монголын анхны шүүх болсон юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь:

- хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр;
- тогтоол, Засгийн газрын бусад шийдвэр;
- зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр;
- Сонгуулийн ерөнхий хорооны гурван төрлийн шийдвэр, мөн
- Монгол Улсын олон улсын гэрээ, түүнчлэн

харьяалан хэлэлцдэг. Үүнд, ард нийтийн санал асуулгын талаар болон Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагаас гаргасан шийдвэр хамаарна.

Эдгээрээс Засгийн газрын шийдвэрийг шалгуулахаар эрх бүхий субъектууд Үндсэн хуулийн цэцэд шууд ханддаг практик цөөнгүй. Ийм тохиолдолд Цэц үндэслэлтэй гэж үзвэл өргөдөл, мэдээллийг хүлээн авдаг.

Үндсэн хуулийн шүүхийн хяналт "хоёрдагч байх зарчим"⁵ гэж Үндсэн хуулийн процесст байдаг. Тухайлбал, гүйцэтгэх эрх мэдлийн тухайн байгууллагын шийдвэрийг харьяалан шийдвэрлэх шат дамжлага байгаа тохиолдолд эхлээд тэдгээрийг дамжсаны дараагаар Үндсэн хуулийн шүүхэд хандахыг энэхүү зарчим шаарддаг. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Засгийн газрын шийдвэрийн талаар эхлээд Засгийн газарт өөрт нь, дараагаар нь Улсын Их Хуралд хандахаар зохицуулсан байна. Харин үүний дараагаар Үндсэн хуулийн цэцэд ханддаг байх нь дээрх зарчимд илүүтэй нийцнэ. Дээрх шат дамжлагыг гүйцээсний дараагаар Цэцэд хандан Засгийн газрын тогтоолыг хянуулсан туршлага манай практикт гарч байсан гэдгийг энд дурдаж болох юм⁶.

Сонирхуулж хэлэхэд, Засгийн газрын шийдвэр нь захиргааны актын шинжтэй бол захиргааны хэргийн шүүхтэй улсад эхлээд тус шүүхэд хандсан байхыг шаарддаг (жишээ нь ХБНГУ-д) байна. Үүнийг Үндсэн хуулийн шүүхэд хандах нэг нөхцөл хэмээн үздэг аж. Засгийн газрын гаргасан шийдвэр захиргааны актын шинжгүй бол захиргааны хэргийн шүүхээр дамжилгүй шууд Үндсэн хуулийн шүүхэд хандах боломж нь нээлттэй байх юм. Харин манай улсын хувьд Үндсэн хуулийн цэцээс 2005 онд гарсан 2/02 тоот дүгнэлтээр Засгийн газрын бүхий л шийдвэрийг гагцхүү Цэцийн харьяалалд үлдээсэн байдаг.

Төрийн гүйцэтгэх эрх мэдэл нь дан ганц Засгийн газар, Ерөнхийлөгч болон Сонгуулийн ерөнхий хороог хамаараад зогсохгүй, түүнээс илүү өргөн ойголт. Энэ эрх мэдэлд хууль хэрэгжүүлэгч өөр олон байгууллага, албан тушаалтан хамаарах ба тэдгээрийн гаргасан шийдвэр ч энд дурдсан гурван субъектын адил Үндсэн хуульд нийцэх ёстой. Нөгөөтэйгүүр төрийн захиргааны дундаас доод шатны албан тушаалтны шийдвэр иргэн хүний эрхийг өдөр тутмын амьдралд зөрчих тохиолдол илүү элбэг байдаг гэж үздэг. Иймд эдгээр субъектын шийдвэр ч дээрх дарааллаар шалгагдаж эцэст нь Цэцэд очих нөхцөл бүрдвэл үндсэн хуульд ёс зорьсон утгаараа хэрэгжих боломж бүрдэнэ. Гэхдээ үүний тулд Үндсэн хуульд

⁵ Subsidiarität

⁶ Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолыг 2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн дүнд суулан хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэл.

нэмэлт оруулах шаардлага гарах тул энэ нь хэтийн ирээдүйд л хэрэгжин боломжтой асуудал. Тэр хүртэл нийгэмд эрх зүйг дээдлэх ёс илүү их төлөвшиж ихэнх зөрчлийг хяналтын өмнөх шат дамжлагуудаар арилгадаг нөхцөл бүрдэх нь дамжиггүй.

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ БА БУСАД ШҮҮХ

Хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын шийдвэрийг хянах ажиллагааг дээр дурдсанаар боловсронгуй болгосны дараагаар Үндсэн хуулийн цэц нь шүүх эрх мэдлийн бусад байгууллагатай хэрхэн яаж харилцах асуудлыг илүү боловсронгуй болгон зохицуулах шаардлага аяндаа гарна.

Үндсэн хууль болон эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид зааснаар Үндсэн хуулийн цэц болон бусад шүүх хоорондоо дараах гурван шинжмээр л холбогдно, үүнд:

- Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцийн гишүүнд гурван хүний нэр дэвшүүлнэ;
- Улсын дээд шүүх Үндсэн хуулийн цэцэд хандаж хүсэлт гаргана;
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна.

Үүнээс гадна Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд, аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Цэцэд гомдол гаргавал, хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлэх тухай заасан байдаг. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд заасан эрх хэмжээнд хамаарахгүй тусдаа зохицуулалт. Энэхүү илтгэлийн хүрээнд Цэц болон бусад шүүхийн харилцан хамаарлын талаарх бусад асуудлыг хөндөлгүйгээр гагцхүү дээрх асуудалд анхаарлаа хандуульга гэж хүслээ.

Үндсэн хуулийн шүүх нь нэгдүгээрт, Үндсэн хуулийн шинжтэй нийтийн эрх зүйн маргаан шийдвэрлэдэг байгууллага ба тус шүүхэд төр хандах нь энэ зүй тогтолд үл нийцнэ. Төр нь Үндсэн хуулийн эрх зүйд гомдол гаргагч тал биш, харин хариуцагч тал байдаг учиртай. Тийм ч учраас Цэц байгуулагдснаас хойш эдүгээ хүртэл шүүхийн харьяалал тогтоолгохоор төр гомдол гаргаж байгаагүй байна.

1992 оноос хойш эдүгээ хүртэл хэргийн харьяалал тогтоолгохоор Цэцэд нийт 10 гомдол ирүүлснээс⁷ нэг иргэн хоёр удаа, нэг иргэн дөрвөн удаа хандаж байсан тоо байна. Ирүүлсэн гомдлыг Цэц хэрхэн шийдвэрлэснийг нягтлан үзэхэд, зөвхөн нэг л тохиолдолд маргаан үүсгэн харьяалал тогтоосон ба үлдсэн бүх тохиолдолд эсхүл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзаж, эсхүл дунд суудлын хуралдаанаар хэрэгсэхгүй болгож байжээ.

Дээрх асуудлаар гарсан Цэцийн гишүүний тогтоол, бага болон дунд суудлын хуралдааны магадлалыг судлан үзэхэд:

- Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш байсан тул маргаан үүсэхээс татгалзсан;
- зөрчигдсөн эрхийг сэргээн тогтоолгох гомдол гаргахдаа иргэн холбогдох хуулийн заалтыг биелүүлээгүй;
- зохих шатны шүүхүүд нэхэмжлэлийг хянан хэлэлцэж шийдвэр гаргасан байхад аль ч шүүх авч хэлэлцэхгүй байна гэж үзэх үндэслэл алга байсан;
- ерөнхий харьяаллын анхан шатны шүүхэд гомдол гаргах боломжтой талаар шүүхээс хариу өгсөн байх тул шүүхийн харьяаллын талаар маргаан байхгүй;
- Цэцийн дунд суудлын хуралдаанаар гомдлоосоо татгалзсан тул хэрэгсэхгүй болгосон;
- хуулийн заалт зөрчигдсөн тухай өргөдөл, гомдлоо хууль тогтоомжид заасан журмын дагуу гаргаагүй;
- шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага хангаагүй тул маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан гэсэн үндэслэлээр Үндсэн хуулийн цэц маргааны харьяалал тогтоогоогүй буюу тогтоох шаардлага ч гарч байгаагүй гэдэг нь харагдаж байна.

Харин 1997 онд Цэц иргэн А-гийн гомдлоор маргаан үүсгэж асуудлыг нь Улсын дээд шүүхээр харьяалуулан шийдвэрлэх тухай магадлал гаргаж байсан ба үүнээс хойш 2002 онд шүүхийн тухай болон эрүү, иргэний процессын хуулиуд шинэчлэгдэж, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль анх удаа батлагдан гарснаар шүүхийн харьяаллын асуудал хийдэлгүй зохицуулагдаж эрх нь зөрчигдсөн хэн болгон шүүхэд мэдүүлэх эрхээ өргөн утгаар нь эдлэх боломжтой болсон.

Иймд шүүхийн харьяалал тогтоох асуудлыг Цэцийн эрх хэмжээнд цаашид байлгах үр дүн, хэрэгцээ, шаардлага бага бөгөөд сонгодог утгаараа ч энэ нь Үндсэн хуулийн шүүхийн харьяалах асуудалд хамаардаггүй байна.

⁷ Үндсэн хуулийн цэцээс гаргуусан лавлагаа.

Үндсэн хуулийн цэц болон шүүх эрх мэдлийн бусад байгууллага хоорондын харилцааг цаашид боловсронгуй болгох, Үндсэн хуулийн шүүхтэй бусад улсын адил энэхүү харилцааг сонгодог голдролд оруулах нь бидний туулах зайлшгүй зам бөгөөд нрээдүйн хөгжлийн зорилго юм.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд Цэц Үндсэн хуулийг нэг мөр хэрэглэх, шийдвэрлэж буй маргаандаа холбогдуулан түүний зүйл, заалтыг онолын өндөр түвшинд, практик шийдлүүдийг харгалзан төгс тайлбарлах явдал мөн бөгөөд энэ чиглэлд Цэц багагүй амжилт гаргаж байгаа, цаашид ч гаргах нь эргэлзээгүй билээ.

----- оОо -----

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байх зарчим



Үндсэн хуулийн цэцийн гишүүн, дэд профессор Д.Наранчимэг

Үндсэн хуулийг бид хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, төрийн эрх мэдлийг хуваарилах онолын үзэл санааны үүднээс төрийн байгууллагын тогтолцооны зохист харьцааг бий болгож, төр ба ард түмний хоорондын үндсэн суурь харилцааг зохицуулагч тулгуур хууль хэмээн тодорхойлдог. Үндсэн хууль нь төрийн эрх дархыг хууль ёсоор хязгаарлах замаар хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хэрэгсэл гэж үзвэл Үндсэн хуулийн хэм хэмжээ бүр нийгмийн харилцаанд бодитой үйлчлэн хэрэгжих улмаар үндэсний эрх зүйн тогтолцоонд хууль дээдлэх зарчмын бодит хэмжүүр болж эрх зүйт төрийг байгуулах үзэл санаанд эрх зүйн зохицуулалтын загвар болж байх нь ихээхэн чухал юм.

Дэлхийн улс орнууд Үндсэн хуулийн нийгэм, улс төр, эрх зүйн үнэт чанарыг харгалзан түүний хэм хэмжээг аливаа хууль бус нөлөөлөл, хүсэл зоригоос хамгаалах түүнчлэн Үндсэн хуулийн тогтвортой, бодитой үйлчлэх шинжийг хангах зорилгоор Үндсэн хуулийн хяналтын тусгай механизмыг бий болгосон бөгөөд энэхүү чиг үүргийг манай улсад Үндсэн хуулийн цэц амжилттай хэрэгжүүлсээр 20 гаруй жил болжээ.

Үндсэн хуулийн цэц нь хуульд тусгайлан заасан төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн үзэл санаа, хэм хэмжээг зөрчсөн эсэх талаарх маргааныг процессын хуульд заасан журмын дагуу, Үндсэн хуулийн хэм хэмжээг хэрэглэн шийдвэрлэдэг шүүх эрх мэдлийн байгууллага болохын хувьд төрийн эрх мэдлийн бусад

байгууллагаас бие даан оршиж, гишүүд нь үйл ажиллагаа явуулахдаа аливаа байгууллага, албан тушаалтан, бусад этгээдээс хараат бус байх асуудал чухал юм.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг баталгаажуулсан байдаг.

Харин Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд цэцийн "бие даасан", "хараат бус байдал" гэсэн ойлголтыг зөвхөн "хараат бус" байх гэсэн үгээр илэрхийлсэн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2-т "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна", мөн зүйлийн 3-т "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана", Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлд "Цэц нь хараат бус байх, Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, гишүүд эрх тэгш байх, асуудлыг шударга шийдвэрлэх, үйл ажиллагаа нь ил тод байх үндсэн зарчмыг баримтална", Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд "Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, бусад иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан, дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэнэ" хэмээн хуульчилжээ. Гэхдээ бид Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал нь хуулиар огт баталгаажуулж хэмээн андуу ташаа ойлгож болохгүй.

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал болон цэцийн гишүүний хараат бус байдал нь хоорондоо салшгүй холбоотой, харилцан нөхцөлдсөн ойлголтууд юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫН ТУХАЙД

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал хэмээх ойлголт нь тус байгууллагын төрийн байгууллагын тогтолцоонд эзлэх байр сууриар тодорхойлогдох бөгөөд Үндсэн хуулийн биелэлтэд шүүхийн журмаар дээд хяналт хэрэгжүүлдэг байгууллагын хувьд түүний бие даасан байдлыг хуулиар баталгаажуулах нь зайлшгүй юм.

Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын зайлшгүй байх шинж нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын үзэл санаатай шууд холбоотой. Учир нь Үндсэн хуулийн шүүхтэй улс орнуудад Үндсэн хуулийн шүүх нь төрийн эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь Үндсэн хуулийн хэм хэмжээг зөрчсөн эсэх талаарх маргааныг шийдвэрлээд зогсохгүй эрх мэдлийн байгууллага хоорондын маргааныг шийдвэрлэдэг¹ онцлогтой.

Австрийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Кристоф Грабенвартер “Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын үзэл санаатай объектив хамааралтай бөгөөд учир нь эрх мэдлийн хуваарилалтын хэрэгжилтэд Үндсэн хуулийн шүүх нь үр дүн бүхий хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй” хэмээн үзсэн² бол Бүгд Найрамдах Беларус Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч П.П.Миклашевич “Төрийн эрх мэдэл хуваарилалт нь улс орны улс төр, нийгэм, эдийн засгийн тогвортой байдлыг хангах үзэл санаа болохын хувьд шүүхийн бие даасан байдлыг хамгаалагч бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын үндэс суурь баталгаа болно” хэмээн үзсэн байна.³

Мөн ОХУ-ын эрдэмтэн Н.В.Витрук өөрийн бүтээлдээ “Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт нь төрийн эрх мэдлийн дээд байгууллагуудын төдийгүй шүүх эрх мэдлийн дээд байгууллагуудын тогтолцоонд Үндсэн хуулийн бие даасан, хараат бус байдлыг хангах шүүхийн зорилгыг агуулсан байдаг”⁴ гэж бичжээ.

Гадаад улс орнуудын Үндсэн хуулийн шүүхүүдийн нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь өөрийн нийгэмд эзлэх өндөр, дээд байр суурьт тохирсон улс төр, хууль зүй, эдийн засаг, зохион байгуулалт, аюулгүй байдлын баталгаагаар хангагдах ёстой ба эдгээр нь Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын гол шалгуур болох юм.

Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын гол шалгуурыг доорх байдлаар авч үзэж болно. Үүнд:

1. Үндсэн хуулийн цэц нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх болон төрийн бусад дээд байгууллагаас тусдаа, бие даасан, өөрийн гэсэн зохион

¹ В.К.Боброва, М.А.Митюков, А.А.Подивалов “Конституционное правосудие в странах СНГ и Балтии”, Москва, Зерцало, 1998г, С.46.

² Christoph Grabenwarter “Separation of powers and the Independence of Constitutional Courts and Equivalent Bodies”, keynote speech 16 Jan 2011, 2nd Congress of the World Conference on Constitutional Justice, Rio de Janeiro.

³ Petr.P.Miklashevich, “Separation of powers and Independence of Constitutional Court of Republic of Belarus”, 2011.

⁴ Н.В.Витрук “Конституционное правосудие, судебное конституционное право и процесс”, Москва, 1998, С.93.

байгуулалтын бүтэцтэй, эрх хэмжээтэй, чиг үүрэгтэй байдаг.

Үндсэн хуулийн цэц нь хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын 40 насанд хүрсэн нийт 9 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Монгол Улсын Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхээс санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилдог.

Ийнхүү Цэцийн гишүүдийг эрх мэдлийн байгууллагуудаас тэнцвэрт тоогоор санал болгож байгаа нь уг байгууллагын бие даасан байдлыг хангахад чиглэгддэг.

Харин зохион байгуулалтын хувьд Цэц нь дарга, орлогч дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд Цэцийн даргаар сонгогдох хүний нэрийг Цэцийн гишүүд дотроосоо дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, саналыг нууцаар хурааж нийт гишүүдийн олонхын санал авсан хүнийг 3 жилийн хугацаагаар сонгодог. Өөрөөр хэлбэл, Цэцийн даргыг аль нэг эрх мэдлийн байгууллагаас томилдоггүй бөгөөд тэрээр ардчилсан ёсны зарчмын дагуу гишүүдээс нууц санал хураалтаар сонгогддог нь бие даасан байдлын нэгэн илэрхийлэл болно.

Цэцийн бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээ, чиг үүрэг, үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль гэсэн бие даасан хуулиудаар зохицуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1-д "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж заасан нь Үндсэн хуулийн цэц Үндсэн хуулийн шинжтэй байгууллага бөгөөд төрийн дээд эрх мэдлийг хэрэгжүүлэхэд Үндсэн хуульд заасан өөрийн эрх хэмжээний хүрээнд эрх тэгш оролцдог¹ бие даасан байгууллага болохыг баталгаажуулсан байна.

2. Цэц нь төсөв, санхүүгийн хувьд бие даасан байж чиг үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдах ёстой. Өөрөөр хэлбэл, Цэцийн төсөв, санхүүгийн нөөц нь үйл ажиллагаагаа явуулахад хүрэлцэхүйц, хангалттай байх баталгааг бүрдүүлэх явдал юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-д "Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн

¹Ц.Сагангва "Үндсэн хуулийн цэцессн эрх зүй, суурийн голт, тулгамдсан асуудал", Ув., 2005 он, 59 дэх тал.

цалингийн хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтоож баталла” гэжээ. Хэдийгээр Цэцийн төсвийг Цэцийн дарга санал болгох, түүнийг нь Улсын Их Хурал батлахаар хуульчилсан нь Цэцийн бие даасан байдлыг хангах нэгэн баталгаа мэт боловч Улсын Их Хурал төсөв батлахдаа Цэцийн төсвийг танах, хасах явдал гаргадаг нь нууц биш юм. Судлаачдын үзсэнээр шүүх эрх мэдлийн байгууллагын бие даасан байдлын чухал баталгаа нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц төсөв, төсвийг чөлөөтэй захиран зарцуулах эрх бөгөөд улс орнууд өөрийн хуульд төсвийн талаарх харилцааг тусгайлан нарийвчлан зохицуулсан байдаг байна. Үндсэн хуулийн шүүхийн төсвийн талаарх харилцааг ОХУ, Литви, Беларусь, Герман зэрэг улс орон нэлээд нарийвчлан зохицуулсан байдаг бөгөөд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь зохион байгуулалт, санхүү болон материал техникийн харилцааны хувьд эрх мэдлийн бусад байгууллагаас хараат бус байх, Үндсэн хуулийн шүүх нь санхүүгийн хувьд Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд хангалттай хүрэлцэхүйц байх, төсвийн хөрөнгийг бие даан захиран зарцуулах эрх хэмжээг тусгасны зэрэгцээ эрх зүй, зохион байгуулалт, санхүү, мэдээлэл, материал-техник, боловсон хүчний болон бусад нөхцөлийг ямар нэгэн байдлаар хязгаарлахыг хориглосон байна. Дэлхийн зарим улс орны Үндсэн хуулийн шүүхүүд санхүүгийн нэмэлт эх үүсвэр болгон зарим төрлийн хураамж, төлбөр авдаг журмыг хуульчилсан байдаг. Тухайлбал, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд Улсын тэмдэгтийн хураамжийн тухай зохицуулсан байна. Мөн Гүрж, Австри, Герман, Португал, Испани, Швейцари, Малта зэрэг зарим улсад Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зардал болгон тэмдэгтийн хураамж авдаг байна.

3. Цэц нь чиг үүргээ хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг-бүхий ажлын алба буюу аппараттай байна. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1-д “Цэц нь ажлын албатай байна. Түүний орон тоог Улсын Их Хурлаас баталсан төсөвт багтаан Цэцийн ажлын албаны дарга тогтооно” гэсэн нь Цэцийн бие даасан байдлын зохион байгуулалтын баталгаа болно. Үндсэн хуулийн шүүхтэй улс орнуудад шүүхийн захиргаа буюу аппарат нь өөрийн гэсэн бүтэцтэй, зохион байгуулалтын дотоод нэгжүүдтэй байдаг. Үндсэн хуулийн шүүхүүдийн аппарат нь нарийн бичгийн даргын газар, тамгын газар, ажлын алба, аппарат зэргээр өөр өөр нэрлэгддэг ч Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд туслах, дэмжлэг үзүүлэх ерөнхий

чиг үүрэг нь нийтлэг байдаг ба мэдээлэл, лавлагаа, эрдэм шинжилгээ, судалгаа, зөвлөгөө, техникийн тусалцаа зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Зарим шүүхэд нарийн бичгийн даргын газрын зэрэгцээ архив, номын сан, эрдэм шинжилгээ, судалгааны болон зөвлөх төв, нэмэлт ажлын алба, байнгын комисс гэсэн зохион байгуулалтын бие даасан нэгжүүд ажиллаж байдаг. Тухайлбал, ОХУ, Украин зэрэг улсад бие даасан нэгжүүд ажиллаж Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байдаг байна.

4. Үндсэн хуулийн шүүх нь үйл ажиллагаагаа явуулах нөхцөл хангасан өөрийн байртай байх ёстой бөгөөд шүүхийн байр нь төрийн тусгай хамгаалалтад байдаг. Ихэнх улс орон Үндсэн хуулийн шүүхийн оршин байх газрыг Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд хуульчлан баталгаажуулсан байдаг бөгөөд шүүх нь шүүх хуралдаанаа болон үйл ажиллагаагаа байнга оршин байх газарт явуулдаг хэдий ч шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдаанаа өөр газар явуулж болохоор хуульд заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь өөрийн гэсэн байртай бөгөөд Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 182 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцийн байрыг төрийн тусгай хамгаалалтад хамааруулсан боловч Цэцийн байрны хамгаалалтыг нэг ээлжээр, өдрийн цагаар зохион байгуулахаар тогтоолд заасан байна. Мөн Үндсэн хуулийн шүүхийн байранд төрийн далбаа мандуулдаг, шүүх хуралдааны танхимд төрийн сүлд байрлуулдаг, шүүтчид нь шүүх хуралдааны үсэр шүүтчийн тусгай өмсгөл өмсдөг нийтлэг жишиг манай Үндсэн хуулийн цэцэд ч үйлчилдэг. Дээрх шинжүүд нь Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын бас нэгэн баталгаа болдог.

5. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан байдал. Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын эцсийн үр дүн нь тодорхой хэрэг, маргааныг Үндсэн хуулийн цэц хуралдаанаараа хэлэлцэн шийдвэр гаргах байдлаар илрэх бөгөөд энэ нь бусад зохион байгуулалтын бие даасан байдлаас тэргүүн зэргийн ач холбогдолтойд тооцогддог. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь Цэцийн бие даасан байдал нь Цэцийн гишүүний хараат бус байдлаас шууд хамаарах нь тодорхой байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүн иргэдийн гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авч анхны шалгалтыг хийхээс эхлүүлээд хуралдаанд бэлтгэх, хэрэг, маргааныг дунд, их суудлын хуралдаанаар хэлэлцэх, шийдвэр гаргах

зэрэг Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан, өөрийн мэргэшлийн мэдлэг, чадвар, эрх зүй, ёс зүйн хэм хэмжээг удирдлага болгон дотоод итгэл үнэмлэхээрээ асуудалд хандаж чадвал Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь бие даасан байдал хангагдана.

Хэдийгээр Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдал нь гишүүний хараат бус байдалтай шууд холбоотой боловч Үндсэн хуулийн цэц аливаа маргааныг хянан шийдвэрлэхдээ хамтын зарчмаар олонхын саналаар шийдвэрлэдэг ба гишүүн бүр тус тусдаа хараат бус байж гагцхүү Үндсэн хуульд захирагдан шийдвэрлэдэг учраас нэг гишүүний хувьд хараат бус байдал алдагдсан ч Цэцийн хуралдааны бүрэлдэхүүн хараат байдалд ордоггүй.

Аль ч улсын хувьд Үндсэн хуулийн шүүх нь бусад шүүхтэй харьцуулахад улс төрийн хүчнээс хараат бус, бие даасан байх асуудал нь тулгамдсан асуудал болж байдаг. Учир нь Үндсэн хуулийн шүүхээр ихэвчлэн улс төрийн ач холбогдол бүхий маргаан шийдвэрлэгдэж байдгаас гадна маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нэг тал нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн дээд байгууллагын төлөөлөгч байдаг. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн шүүх шийдвэрээ гаргахдаа улс төрийн байр суурь, сэдэлтээр бус гагцхүү эрх зүйн онол, үзэл баримтлал, суурь зарчмыг үндэслэлээ болгох шаардлагатай байдаг.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийнх бөгөөд тухайн шийдвэрийн хянадаг, хүчингүй болгодог эрх мэдэл бүхий өөр субьект байдаггүй.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн хүчин чадал нь түүний бие даасан байдлын баталгаа болж байдаг.

Дээр өгүүлснээр Үндсэн Хуулийн Цэцийн бие даасан байдлын нэг чухал баталгаа нь гишүүний хараат бус байдал юм. Одоо Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдлыг авч үзье.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ГИШҮҮНИЙ ХАРААТ БУС БАЙДЛЫН ТУХАЙД

Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал нь Цэцийн бие даасан байдлын баталгаагаар давхар хангагдаж харилцан нөхцөлдсөн тухай дээр өгүүлсэн.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал нь нийгэм, улс төр, зохион байгуулалт, эрх зүй, эдийн засаг, үйл ажиллагааны бусад баталгаагаар хангагдсан байх шаардлагатай.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдлын баталгааг бэхжүүлсэн хэм хэмжээг доорх ангилалаар авч үзэж болох юм.

1. Үндсэн хуулийн цэц байгуулагдах журам, төрийн эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд түүний бие даасан байдлыг бэхжүүлсэн хэм хэмжээ буюу зохион байгуулалт, нийгэм, улс төрийн баталгаа;

2. Цэцийн гишүүний эрх зүйн байдлыг бэхжүүлсэн хэм хэмжээ;

3. Цэцийн гишүүний материаллаг болон нийгмийн хангамжийг бэхжүүлсэн хэм хэмжээ буюу эдийн засгийн баталгаа;

4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох процессын баталгааг бэхжүүлсэн хэм хэмжээ.

Одоо дээрх ангилал тус бүрээр товч авч үзье. Үүнд:

1. Үндсэн хуулийн цэцийн бие даасан байдлын талаар дээр дэлгэрэнгүй өгүүлсэн. Цэцийн бие даасан байдал нь гишүүний хараат бус байдлыг хангах баталгаа болдог. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1-д “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилоно.”, тус зүйлийн 2-т “Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, Монгол Улсын дэчин нас хүрсэн иргэнийг томилоно.” гэж заасны дагуу гишүүд томилогддог.

Цэцийн гишүүнийг төрийн эрх мэдлийн дээд байгууллагуудаас санал болгож байгаа нь эрх мэдлийн тэнцвэрийг хангах, аль нэг эрх мэдлээс хараат байх явдлаас сэргийлэх агуулгатай ба харин гишүүд тэдгээр байгууллагын төлөөлөл гэсэн үг биш бөгөөд гишүүний үйл ажиллагаа ямар нэгэн байгууллага, албан тушаалтны хяналтад байдаггүй.

Монгол Улсад Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байхаар хуульчилсан бөгөөд нэг гишүүн хэдэн ч удаа дахин томилогдож болдог. Энэ нь нэг талаасаа Цэцийн гишүүний хараат бус байдалд нөлөөлж болзошгүй юм.

Үндсэн хуулийн шүүхтэй ихэнх улс орон Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг аль болох урт хугацаагаар, тухайлбал, 9-15 жилээр, эсхүл хугацаагүй томилдог ба Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр ажиллах насны дээд хязгаарыг ихэвчлэн 65-70 насаар хязгаарлан хуульчилсан байдаг. Ингэснээр шүүгч аль болох нэг удаагийн томилоого буюу нэг бүрэн эрхийн хугацаа дуусахад тэтгэвэрт гарахаар буюу хугацаагүй томилогдсон шүүгч насны дээд хязгаар хүртлээ ажиллах бололцоогоор хангаж, дахин томилогдох зохицуулалтаас аль болох татгалзсан байдал ажиглагдаж байна.

Энэ нь гишүүний хараат бус байдлыг хангах бас нэг баталгаа гэж хэлж болно.

Цэцийн гишүүн ямар нэгэн улс төрийн нам, эвсэлд харьяалагдахгүй. Энэ нь түүнийг улс төрийн хүчний аливаа нөлөөллөөс ангилд байлгах нэгэн баталгаа гэж үздэг.

2. Үндсэн хуулийн цэцийн гишүүний эрх зүйн байдлын хэм хэмжээ гэдэгт түүний халдашгүй байдал, гишүүний бүрэн эрхийн баталгааг бэхжүүлсэн хэм хэмжээ багтдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 4-д "Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүн хууль зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болно" гэсэн байна.

Цэцийн гишүүнийг Цэцийн зөвшөөрөлгүйгээр (түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчлахаас бусад тохиолдолд) баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, эрүүгийн хариуцлагад татах, эсхүл шүүхийн журмаар түүнд захиргааны шийтгэл оногдуулах, орон байр, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийх, бичиг баримт, эд зүйлийг хураан авахыг хуулиар хориглодог нь гишүүний халдашгүй байдлын баталгаа болно.

Цэцийн гишүүн гэмт хэрэгт холбогдсон бол түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Цэц хэлэлцэж шийдвэрлэхээр хуульчилсан.

Цэцийн гишүүн гэмт хэрэг үйлдсэнийг шүүх тогтоосон, эсхүл хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон бол түүнийг Цэцийн гишүүнээс нь эгүүлэн татах тухай Цэц шийдвэр гаргах ба Цэцийн энэхүү шийдвэр, анх илгээсэн байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал эгүүлэн татаж болдог.

Цэцийн гишүүн хувийн хүсэлтээ гаргасан, эрүүл мэндийн улмаас ажлаа үргэлжлүүлэн хийх боломжгүй болсон, эсхүл дээр заасан үндэслэлээр Улсын Их Хурал эгүүлэн татахаас бусад үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусахаас нь өмнө уг албан тушаалаас чөлөөлөх, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглодог.

Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, гишүүнийг эгүүлэн татахад Цэц онцгой эрхтэй байгаа нь тухайн байгууллагын бие даасан байдлыг илэрхийлээд зогсохгүй гишүүний халдашгүй байдал, бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгаа болдог онцлогтой.

Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрх 6 жилийн хугацаатай ч дараагийн гишүүн томилогдох хүртэл Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлж байдаг. Цэцийн гишүүнийг нөхөн томилохдоо орон гарсан

гишүүнийг урьд томилохоор санал болгосон эрх бүхий байгууллага, албан тушаалтан саналаа 14 хоногийн дотор гаргаж, Улсын Их Хурал 30 хоногийн дотор шийдвэрлэхээр хуульд заасан боловч өнөөдрийн амьдралаас харахад зарим гишүүний хуульд заасан бүрэн эрхийн хугацаа өнгөрсөн ч гэсэн дараагийн гишүүн томилогдох хүртэл буюу 1 сараас 1 жил 5 сар гаруй хугацаанд бүрэн эрхээ үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр ирсэн практик байна.

Энэ нь нэг талаасаа Цэцийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч нөгөө талаасаа Цэцийн гишүүнийг санал болгох, томилох эрх бүхий албан тушаалтан, байгууллагын үйл ажиллагааны доголдолтой талыг харуулж байгаа юм.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч давхар ажил, албан тушаал эрхлэхийг хуулиар хязгаарласан байдаг.

Үндсэн хуулийн шүүхтэй ихэнх улсад Үндсэн хуулийн шүүхийн шүүгч багшлах, эрдэм шинжилгээний болон бүтээлч ажлаас бусад ямар нэгэн улс төрийн албан тушаал, мөн давхар цалин хөлс авдаг аливаа ажил, албан тушаал хавсран ажиллахыг хориглосон байдаг. Беларусь Улсад багшлах, эрдэм шинжилгээний орон тооны албан тушаал хавсрахыг хориглосон байна. Харин ХБНГУ, Итали зэрэг улсад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр Холбооны буюу аль нэг дээд шатны өөр шүүхийн шүүгчид, хуулийн их сургуулийн орон тооны профессор томилогдон орон тооны бус шүүгчээр ажиллаж болдог байна.

Харин манай улсын хувьд Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 34 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт: “Үндсэн хуулийн цэцийн дарга, хоёр гишүүнийг (гурван талаас тус бүр нэг) орон тооны, зургаан гишүүнийг орон тооны бус байхаар тогтоосугай” гэсэн ба Улсын Бага Хурлын 1992 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг томилох тухай” 38 дугаар тогтоолд Цэцийн дарга, гурван гишүүн орон тооны, бусад таван гишүүн орон тооны бус байхаар заасны дагуу Цэцийн бүрэлдэхүүн орон тооны болон орон тооны бус гишүүдтэй ажиллаж байна.

Орон тооны бус Цэцийн гишүүд өөрийн үндсэн ажил болох орон тооны өөр ажил давхар хашдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 5-д “Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн шүүгч орж үл болно” гэж заасан. Харин Монгол Улсын Цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 5-д дээрхээс гадна “... Цэцийн гишүүн засаг, захиргаа,

нам-улс төрийн болон худалдааны үйл ажиллагаа эрхэлж, үйлдвэрчний эвлэлийн удирдах ажил хийж болохгүй” гэжээ.

Улсын Их Хурлаас 2012 онд баталсан “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс, урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно” гээд мөн зүйлийн 18.3-д “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, мөрдөх албаны албан тушаалтан салбарын хуульд тусгайлан зааснаас бусад ажил, албан тушаал эрхлэхийг хориглоно” гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн дагуу гишүүн хуулиар хориглосноос бусад ажил эрхэлж болохоор харин “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн дагуу хуулиар зөвшөөрснөөс бусад өөр ажил албан тушаал эрхлэхийг хориглосон зохицуулалт орсон байна.

Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Албан тушаалтан энэ хуулийн 18.6-д зааснаас бусад аж ахуйн үйл ажиллагаа гардан эрхлэх болон аж ахуйн нэгжийн удирдах бүтцэд ажиллахыг хориглоно” гэж заажээ.

Олон улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг жишгийн дагуу Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг улс төр, бизнесийн хүрээллийн нөлөөллөөс ангид байлгаж хараат бус байдлыг хангах баталгаа болгон давхар эрхэлж болох ажил, албан тушаалд хуулийн хязгаарлалт хийдэг.

3. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг хангахад эдийн засаг, нийгмийн баталгааг хангах асуудал улс орнуудад чухлаар тавигддаг бөгөөд энэ талаарх харилцааг тусгайлсан актаар зохицуулах хандлагатай болж байна. Тухайлбал, Гүрж Улс 1996 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн нийгмийн баталгааны тухай хуулийг баталсан бөгөөд уг хуулийн Нэгдүгээр зүйлд зааснаар Төр нь Үндсэн хуулийн шүүхийн гишүүний хараат бус байдлыг хангах зорилгоор түүний амьдрах болон ажиллах тааламжит нөхцөлийг бий болгох үүргийнхээ хүрээнд энэхүү актыг баталсан болохыг дурдаад дараах харилцааг зохицуулсан байна. Үүнд:

- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээг хуулиар тогтоох бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн дэд Ерөнхийлөгч болон нарийн бичгийн даргын сарын үндсэн цалин нь Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн цалингийн 90 хувиас багагүй, харин гишүүний цалин нь 85 хувиас багагүй байна. Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгчийн

сарын нэмэгдэл цалин нь түүний цалингийн 90 хувиас багагүй харин дэд Ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга, гишүүний нэмэгдэл цалин нь тэдгээрийн үндсэн цалингийн 50 хувиас багагүй байх бөгөөд тэдгээр нь өөрийн ажилласан жил, эрдмийн зэргийн нэмэгдлээр мөн хангагдах;

- Гишүүд нь жилд 45 хоногийн ээлжийн амралт эдлэх бөгөөд амралт авахаасаа өмнө хоёр сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэг авах;

- Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нь гадаад улсруу албан айлчлал хийх нөхцөлд цалингийн 50, 40, 35 хувьтай тэнцэх хэмжээний нэмэлт цалин авах;

- Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга, гишүүн нь тэтгэвэрт гарсан тохиолдолд авч байсан цалингийн 100 хувиар тэтгэвэр тогтоологдох;

- Гишүүн болон гишүүн байсан хүн нас барсан эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон тохиолдолд түүгээр тэжээн тэтгүүлж байсан түүний эхнэр, нөхөр болон 18 нас хүрээгүй хүүхдэд тэтгэврийн хэмжээгээр тэтгэлэг олгох. Хэрэв гишүүн болон гишүүн байсан этгээд нь албаны чиг үүрэгтэй холбоотойгоор бусдын халдлагад өртөн нас барсан тохиолдолд түүний эхнэр, нөхөр болон хүүхдэд авч байсан цалин эсхүл тэтгэврийн 10 жилтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг материаллаг бусад тусламж үзүүлснээс үл хамааран олгох;

- Түүнчлэн гишүүн нь хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан тохиолдолд түүний 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд 5 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгох зэргээр материалаг хангамжийг эдлүүлдэг ба гишүүний бүрэн эрхийн хугацаанд түүний цалин бусад материалаг хангамжийг бууруулахыг хориглосон байна.

“ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг хангах, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд төрийн болон нийгмийн баталгаа эдлүүлэх тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2000 оны 306 дугаар зарлигт (уг зарлигт 2006 онд зарим нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.) зааснаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарт зэрэг, цолны нэмэгдлээс гадна гадаад хэлний мэдлэгээ албаны үүргээ хэрэгжүүлэхдээ ашигласны төлөө сар бүрийн цалин дээр мөнгөн шагнал болгон нэмэгдэл олгох, ОХУ-ын нутаг дэвсгэрийн хүрээнд төмөр зам, усан болон агаарын тээврийн хэрэгсэл, таксинаас бусад хот хоорондын тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих, орон сууц, албаны унаа, харилцаа холбооны хэрэгслээр

хангагдах, орон сууцны төлбөрийн болон орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийг төрөөс хариуцах, Засгийн газрын тэргүүн түүний орлогч, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд тогтоосонтой адил нөхцөл, журмаар нийгэм-ахуй, эмнэлэг, амралт, сувилалын үйлчилгээний аливаа хөнгөлөлтийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нар, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд адил эдлүүлэх, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч буюу шүүгчээр ажиллаж байгаад чөлөөндөө гарсан хүн нас барсан тохиолдолд гэр бүлийн гишүүн тус бүрд өндөр насны тэтгэврийн хуулийн дагуу тогтоосон суурь тэтгэвэрийн хэмжээг 165 хувиар нэмэгдүүлсэн хэмжээтэй тэнцэх мөнгөн тэтгэлэгийг сар бүр олгохын зэрэгцээ гэр бүлд нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн 1 жилийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэлгийг 1 удаа олгох, бэлбэсэн эхнэр, нөхөр буюу насанд хүрээгүй хүүхэд нь орон сууцны ашиглалтын бүх зардлын 50 хувийн хөнгөлөлтийг үргэлжлүүлэн эдлэх эрхтэй байх зэрэг олон төрлийн эдийн засаг, нийгмийн баталгааг Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нар, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд эдлүүлэхээр зохицуулсан байна.

Манай улсын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон буюу хууль ёсны үндэслэлээр гишүүнээс чөлөөлөгдсөн бол өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар хангах, бага цалинтай ажил эрхлэх бол цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний тэтгэмж олгох, бүрэн эрхийн хугацаагаар ажиллаж насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоохоор хуульчилсан байна.

2012 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан "Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн Дөрөвдүгээр бүлэгт шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгааг нэлээд нарийвчлан зохицуулсан байна. Тухайлбал, Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байх, үндсэн цалингийн 50 хувь хүртэл хэмжээний нэмэгдэл авах, өндөр насны тэтгэвэрт гарсан шүүгчид сүүлийн нэг жилийн цалингийн дунджаар тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмж олгох, шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувилалын газарт, эсхүл төрсөн нутагтаа амрах тохиолдолд түүнийг очих, ирэх замын зардлыг төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгох, шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцах, шүүгч албан үүргээ гүйцэтгэж байхдаа нас барвал түүний асрамжид байсан хүүхдийг 18 нас хүртэл нь, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд шүүгчийн

авч байсан албан тушаалын цалингаас ногдох хэмжээгээр тэтгэмж сар бүр олгох зэргээр эдийн засгийн баталгааг бэхжүүлсэн байна.

Тэгвэл Үндсэн хуулийн цэцийн гишүүд ч гэсэн эдийн засгийн баталгаагаар найдвартай хангагдах нь түүний хараат бус байдлын баталгаа болох ёстой.

4. Үндсэн хуулийн цэцийн гишүүн хэрэг хянан шийдвэрлэх ажллагаанд оролцохдоо аливаа этгээдээс хараат бус байх нь шударга ёсыг тогтоох, Үндсэн хуулийг хамгаалах чиг үүргээ чин үнэнчээр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Өргөдөл, мэдээлэл хуваарилахаас эхлээд шийдвэр гаргах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажллагааны бүхий л үе шатанд Цэцийн гишүүн болон Цэцийн бүрэлдэхүүн хараат бус ажиллах нөхцөлөөр хангагдсан хууль зүйн баталгаа байх ёстой. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажллагааны тухай хуульд зааснаар өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцийн дарга гишүүнд хуваарилдаг. Ийнхүү хуваарилахдаа Цэцийн гишүүний мэргэшсэн чиглэл, ажлын ачааллыг харгалзаж тойргийн зарчмыг баримтлан хуваарилж байгаа хэдий ч субьектив хүчин зүйлийн нөлөөлөл орж болохыг үгүйсгэхгүй. Тиймээс өргөдөл, мэдээллийг бусад улс орны жишгээр аль болох тохиолдлын шинжээр, тойргын зарчмаар гишүүдэд ялгаварлалгүй хуваарилдаг байх нь хэн нэгний нөлөөлөл, ашиг сонирхолд автахгүй байх хараат бус байдлын бас нэг баталгаа болно.

Мөн өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачлагаар шийдвэрлэхээр хуульчилсан нь нэг талаасаа Цэцийн гишүүнд бие даан шийдвэрлэх эрх мэдэл олгож байгаа мэт боловч нөгөө талаасаа Үндсэн хуулийн маргааныг гишүүн дангаараа шийдвэрлэх, ойролцоо буюу нэг ижил төрлийн өргөдөл, мэдээллээр маргаан үүсгэх эсэх асуудлаар өөр өөр байр суурь илэрхийлэх, гишүүний үзэмжээс шалтгаалах мэтээр асуудалд субьектив хандах боломжийг бүрдүүлж болох юм.

Хэрэг хянан хэлэлцэх Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнд орсон Цэцийн гишүүд адил тэгш эрхтэй оролцох, шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орж өөрийн санал, байр сууриа чөлөөтэй илэрхийлж, тайлбарлах эрхтэй ба илтгэгч гишүүн эхэлж санал, дүгнэлтээ гаргаж, дараа нь насны эрэмбээр хамгийн ахмад настай гишүүнээсээ эхэлж санал, дүгнэлтээ хэлж, хуралдаан даргалагч эцэст нь саналаа хэлдэг. Санал, дүгнэлт хэлэх дарааллыг ийнхүү тогтоосон нь гишүүдийн эрхийн тэгш байдлыг алдагдуулсан гэж үзэх үндэс болохгүй.

Дунд суудлын хуралдаанаас гарах дүгнэлтийг гишүүдийн ердийн олонхын саналаар, харин маргааныг эцэслэн шийдвэрлэхээр дахин хянаж байгаа хуралдааны тогтоолыг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёрны саналаар гаргадаг.

Дээр өгүүлснээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гишүүдийн хараат бус байдал нь Цэцийн бие даасан байдлын баталгаа болдог.

Эцэст нь дүгнэхэд, Үндсэн хуулийн цэцийн бие даасан, гишүүний хараат бус байдлын баталгааг бүрэн дүүрэн хангах эрх зүйн орчныг бий болгохын тулд Үндсэн хуулийн шүүхтэй ихэнх улс орны жишгээр Үндсэн хуулийн цэцийн болон гишүүний эрх зүйн байдлын тухай бие даасан хууль гаргах буюу тийм зохицуулалтыг Цэцийн тухай хуульд тусгай хэсэг болгон тусгах зайлшгүй шаардлагатай бөгөөд ингэснээр Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

----- оОо -----

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид

Үндсэн хуулийн цэцийн гишүүн,
профессор Б.Пүрэвням



Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ гагцхүү Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаар хэрэгжүүлдэг тул түүнд оролцогчдын эрх зүйн байдлыг оновчтой тогтоож, хүлээх хариуцлагын асуудлыг боловсронгуй болгох, нарийвчлан судлах хэрэгцээ шаардлага манай улсын Үндсэн хуулийн хяналтын өмнө тулгамдсан зорилтын нэг болж байна. Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бодитой, бүрэн гүйцэт хянан үзэж, магадлан шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршдог.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлд, тухайн маргааны оролцогч хэн байх талаар тодорхой заасан байна. Үүнд, Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэх өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан иргэд, эрх бүхий албан тушаалтан, байгууллага, түүнчлэн Үндсэн хууль зөрчсөн гэж маргаан үүсгэсэн хууль, бусад шийдвэрийг гаргасан буюу үйл ажиллагаа явуулсан байгууллага, албан тушаалтан, зохих журмын дагуу тэдгээрийг төлөөлөхөөр томилогдсон эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч хамаарахаар заажээ. Түүнчлэн Цэцийн хуралдаанд оролцогчдын эрх,

үүргийг мөн хуулийн 18 дугаар зүйлд заахдаа маргагч тал болон оролцогч тал гэсэн хоёр өөр нэр томъёог ашигласныг хэрхэн ойлгохыг зайлшгүй тайлбалах шаардлага урган гарч байна. Тиймээс уг ойлголтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэхэд заавал байдаг идэвхтэй оролцогч буюу маргагч, маргалдагч талаас уг маргааны бусад оролцогчийг ялган зааглаж ойлговол зохино.

Маргагч талуудын хувьд Цэцэд хянан шалгаж байгаа маргааны материалтай танилцах, холбогдох бичиг баримтыг хуулбарлан авах, тэмдэглэл хийх, нотлох баримтыг гаргаж өгөх, нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд оролцох, хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бүх асуудлын талаар санал, дүгнэлтийг гаргах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд чөлөөтэй мэтгэлцэх, шаардлагатай гэж үзэж байгаа бол төгсгөлийн үг хэлэх, хүсэлт тавих эрхээр хангагддаг байна. Харин оролцогч бүх талын хувьд Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнээс татгалзан гаргах саналыг хуульд заасан үндэслэлийн дагуу тавих эрх эдэлнэ. Гэхдээ иргэд болон Үндсэн хуулийн цэцэд хандах эрх бүхий бусад этгээд Цэцэд нэхэмжлэл гаргадаггүй болохыг онцгой анхаарч, гагцхүү өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргадаг болохыг ялгаж ойлгох нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын анхаарвал зохих зарчмын асуудал мөн. Нэхэмжлэл нь түүнийг гаргаж байгаа иргэн, хуулийн этгээдийн субъектив эрхийг хамгаалж, тодорхой зүйлийг шаардахад чигэлсэн хууль зүйн хэрэгсэл байдаг бөгөөд нэхэмжлэл гаргасны үр дүнд гарах шүүхийн шийдвэр нь нийтэд шууд хамааралтай бус, гагцхүү тухайн нэхэмжлэл гаргасан этгээдэд хамаарах асуудлаар гарах нэг бүрчилсэн шинжтэй акт байдгаар тайлбарлагдана.

Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлд тодорхой заасан байдаг тул тус зүйлд заасан эрх хэмжээний хүрээнд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргах эрх бүхий этгээдүүдийн хувьд зөвхөн Цэцэд хандах эрх нь нээлттэй байдаг. Энэ нь манай улсын Үндсэн хуулийн хяналтын дэлхийн зарим улсаас ялгагдах өвөрмөц онцлог тул Үндсэн эрхийг зөрчсөн асуудлаар Цэц шийдвэр гаргадаггүй маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид Цэцэд хандахдаа онцгой анхаарвал зохино. Түүнчлэн Цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах эрхийг зарим орныхтой харьцуулвал харьцангуй өргөн боломж олгосон байна. Тухайлбал, Монгол Улсын иргэдээс гадна Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн уг эрхийг эдлэх талаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасан ч харьяалалгүй хүн өнгөрсөн хугацаанд Цэцэд хандсан тохиолдол гарч байгаагүй байна. Харин хуулийн дээрх заалтын дагуу ОХУ-ын хоёр

иргэн Цэцэд хандсан байх ба нэг иргэний нь өргөдлөөр маргаан үүсгэн шалгаж, Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар хэлэлцэж байжээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх заалтад шинжээч, гэрчийг, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 1-ийн 2 дахь хэсэгт өмгөөлөгч оролцох тухай, 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт хэлмэрч оролцуулах тухай тус тус заасан байх боловч хуралдааны дээрх оролцогчид, ялангуяа мэргэжлийн "өмгөөлөгч" ямар журмаар, хэрхэн оролцохыг нарийн зохицуулсан дэг одоогоор нэг мөр болоогүй байна.

Үндсэн хуулийн шүүх нь хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахад хууль тогтоох, шүүхийн практик хоорондын нэгдлийг хангаж байх учиртай билээ. Энэхүү чиг үүрэг нь Үндсэн хуулийг хамгаалах болон хүний эрхийг хамгаалах явдал хоорондоо салшгүйг нотолно. Үндсэн хуульд заасан "...хууль зүйн мэргэжлийн тусламцаа" авах эрхийг хангахад өмгөөлөгчийн мэргэжлийн үүрэг, хүлээх хариуцлага нэмэгдэж, хэрэгцээ шаардлага ч өссөөр байна. Иймд мэргэжлийн өмгөөлөгчийг Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжийг хуулиар олгосон нь маргагч, маргалдагч талуудын хэн аины хүсэлтээр хууль зүйн мэргэжлийн тусламцаа авах эрхийг хангаж, маргаан бүхий зүйлийн талаар эрх зүйн онолын өндөр түвшинд мэтгэлцэх, байр сууриа илэрхийлэх, судалгаа шинжилгээ, харьцуулсан болон олон улсын эрх зүйн онол, номлолын хүрээнд үнэлэгдэхүйц мэргэжлийн дүгнэлтийг хэлэлцэх утгаараа асар өндөр үүрэг, хариуцлага дагуулах учиртай юм. Нөгөө талаас шүүх бол "...Үндсэн хуулийн хяналтын хүрээнд өөрийн үйл ажиллагааны зорилт, хэмжээ, аргын хувьд хүний үндсэн эрхийг хамгаалах чухал чиг үүрэг бүхий байгууллага байдаг."¹ Иймд дээр дурдсан оролцогчид, ялангуяа мэргэжлийн өмгөөлөгч, төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн этгээдийн эрх үүрэг, оролцооны хэлбэрийг маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой бөгөөд боловсронгуй болгож, үр дагавар, хүлээх хариуцлагатай нь холбон нарийвчлан зохицуулах, төр, иргэний хооронд эрх зүйн өндөр соёл, ухамсарыг төлөвшүүлэх шаардлага Цэцийн өмнө зүй ёсоор тавигдаж байна.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг гаргахад олон нийтийн төлөөлөл буюу иргэдийн төлөөлөгчийг аль ч улс оронд оролцуулдаггүй шалтгааны талаар судлаач, доктор, профессор Ц.Сарантуяа өөрийн туйрвасан Үндсэн хуулийн процессийн эрх зүй номондоо тайлбарласан байна.²

¹ Ж.Амарсанаа "Үндсэн хуулийн шүүх хүний эрхийг хамгаалах баталгаа мөн", Монгол Улсын Үндсэн хуулийн цэц: өгүүлэл, нэлгээний амтгал, Ув., 2007 он.

² Ц.Сарантуяа "Үндсэн хуулийн процессийн эрх зүй: суурь ойлголт, тухамдсан асуудал", Ув., 2005 он.

Бусад процессийн эрх зүйтэй харьцуулахад иргэдийн төлөөлөгчийг оролцуулдаггүй гол шалтгааны талаар Үндсэн хуулийн шүүх төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, манайхаас бусад улс оронд байдаг хяналт болох шүүх эрх мэдлийн шийдвэрийг Үндсэн хуульд хэмжин хянадагтай холбоотой хэмээн дурджээ. Эрх зүйн онолын үүднээс авч үзвэл "иргэн" үндсэн эрхээ хамгаалуулахаар өргөдөл гаргасан бол тэрээр үндэсний шүүхийн бүх шат дамжлагыг ийнхүү Үндсэн хуулийн шүүхэд хандахаасаа өмнө гүйцээсэн байх шаардлагатай аж. Нөгөө талаас Үндсэн хуулийн шүүх нь тухайн улсынхаа Үндсэн хууль, түүний үзэл баримтлалыг иш үндэс болгон маргааныг гагцхүү эрх зүйн шинжлэх ухааны онол, номлолд тулгуурлан шийдвэрлэдэг утгаараа онолын шүүх гэж үздэг. гарсан шийдвэр нь бүх нийтэд хамааралтайгаас гадна дээр дурдсан цогц бусад шалтгаанаас үүдэн хуралдаанд олон нийтийн төлөөлөлийг оролцуулдаггүй журамтай хэмээн тайлбарлан бичжээ. Иймээс манай улс ч дэлхийн улс орнуудын энэхүү жишгээр олон нийтийн төлөөллийг Цэцийн хуралдаанд оролцуулдаггүй байна. Үүний нэг адил процессийн эрх зүйн оролцогчид зүй ёсоор хамаардаг ч иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн нэг болох гуравдагч этгээдийг Үндсэн хуулийн маргааны оролцогчид тусгаагүй явдал нь маргааны зүйл болсон актууд (Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1-д заасан хууль, холбогдох шийдвэрүүд) гуравдагч этгээдийн эрх ашигт бус, нийтэд хамаарах асуудлаар Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянадаг агуулгаар мөн тайлбарлагдана.

Цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчид хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд адил тэгш эрхээр хангагдсан байдаг. Гэвч энэ нь бодит байдалд нэг талаас өргөдөл, мэдээлэл гаргасан иргэн, нөгөө талаас төр, түүний албан тушаалтан байдаг тул оролцогч талуудын гарааны байдал Цэцээс үл хамаарах шалтгаанаар нэн ялгамжтай байгаа мэт ойлголт төрүүлдэг байна. Тодруулбал, иргэн өргөдлийнхөө үндэслэл, бусад зүйлд хамаарах нотлох баримтыг тэр бүр олж авах боломжоор хангагдаж чадаагүй, нөгөө талаас Цэцээр хэлэлцэх гэж буй маргаантай холбогдуулж иргэнд бичиг баримт гаргаж өгөх үүргийг хуулиар байгууллага, албан тушаалтанд хүлээлгээгүй зэрэг нь маргагч, маргалдагч талууд эрх тэгш оролцох боломжийг хязгаарладаг байна. Харин хэргийн нотлох баримтыг цуглуулах үүргийг талууд биш, Цэц гүйцэтгэх тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын тэгш эрхийг хангах боломж бүрдэх юм. Иймд Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар байгууллага, албан тушаалтан, иргэдийн аль нь ч Цэцийн гишүүний шаардсан баримт, бичгийг хугацаанд нь гаргаж

өгөх үүрэгтэй. Ийнхүү хуулиар хүлээсэн үүрэгтээ хүндэтгэлтэй хандах нь Үндсэн хуульд заасан төрийн нэгдмэл байх, Цэцийн шийдвэр заавал биелэгдэх тулгуур зарчмыг ухамсарлан төрийн өндөр институци хоорондын эрх зүйн соёлыг төлөвшүүлэх, нэг мөр болгоход онцгой үүрэгтэй. Тухайлбал, Цэцийн шийдвэр заавал биелэгдэх шинжтэй ч төрийн эрх мэдэл хооронд, ялангуяа хууль тогтоох болон Цэцийн хооронд тогтсон уламжлалт харилцааг судалж үзэхэд энэхүү үнэт зарчим алдагдаж, хууль, Үндсэн хууль зөрчсөн гэж гарсан дүгнэлтийн дийлэнхийг Улсын Их хурал хүлээж аваагүй нь Үндсэн хуулийн хяналт үнэгүйдэх, хууль дээдлэх ухамсар дээд түвшиндээ дорой болохыг илтгэн харуулж байна.

МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчид нь хуулиар өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох учиртай ч уг эрх, үүргээ сайтар судалж, өөрсдийн тавьсан шаардлагын үндэслэл, сөрөг шаардлагыг эсэргүүцэж байгаа үндэслэлээ батлах бичиг баримтыг бүрдүүлэх, нөхцөл байдлыг нотлох үүрэг болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцлагаа ухамсарлан идэвхтэй байр суурьнаас хандах нь Цэцээс гарах шийдвэрийг бодитой, тал бүрээс хянахад чухал юм. Маргагч болон оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тодорхой зааж өгсөн байна. Харин маргаан хянан шийдвэрлэхэд оролцогч хэн боловч Цэцийн хуралдааны бүрэлдэхүүнээс татгалзан гаргах эрхийг адил тэгш эдлэх тухай өмнө нэгэнт дурдсан билээ.

Цэцэд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал хянаж байгаа асуудлын хүрээнд Цэцийн хуралдаан завсарлахаас өмнө аль ч шатанд өөрийн тавьж буй шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс татгалзах эрхтэй талаар Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4-т заасан байдаг. Энэ тохиолдолд хэрэг маргааныг гагцхүү талуудын Цэцэд гаргасан шаардлагын хүрээнд хянан шийдвэрлэх үү? эсвэл иргэний болон захиргааны хэргийн шүүхтэй харьцуулахад маргагч талаас гаргасан өргөдлийн шаардлагаар Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр хязгаарлагдах уу? гэсэн зарчмын эсрэг, тэсрэг байр суурь, чиг хандлага судлаачдын хүрээнд анхаарал татсан асуудал болсоор байна.

Дэлхийн Улс орнуудад хоёр дахь чиг хандлагыг баримтлан Үндсэн хуулийн хяналтын хэлбэрийг тогтоосон туршлага зонхилж байна. Үндсэн хуулийн шүүхийн хяналтын объектод багтдаг хууль, эрх зүйн бусад акт, түүнчлэн албан тушаалтны үйл ажиллагаа Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудал нь зөвхөн маргагч, маргалдагч талуудын эрх ашигт хамаарах бус, нийтэд хамааралтайн хувьд Цэцэд хандаж байгаа этгээд мэдээлэл гаргах эрхийнхээ хүрээнд тавьсан асуудлыг Үндсэн хуулийн шүүгч хянахдаа зөрчлийн шинж агуулсан өөр бусад зүйл заалт байгаа эсэхийг өргөдөл, мэдээлэлд тавьсан шаардлагаар хязгаарлалгүй бүхэлд нь, өргөн хүрээнд шаардлагатай ажиллагааг санаачилгаараа хийх үүрэг хүлээдэг байна.

Иргэн хүн хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийн заалтыг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзэж Цэцэд хандахдаа Үндсэн хуулийн зөрчигдөж буй зүйл, заалтыг онож заагаагүй, эсхүл дутуу заасан, түүнчлэн маргааны зүйл нь үгүй болсон, маргагч талууд харилцан ойлголцож өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал өргөдлөөснө бүхэлд нь болон зарим хэсгээс сайн дураар татгалзсан бол маргааныг зогсоож, уг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг татгалзахаар хуульд зохицуулсан байдаг. Хуулийн энэхүү зохицуулалтыг нарийвчлан судалж, дэлхийн Улс орнуудын дээр дурдсан туршлагаас дэвшилтэд зүй тогтолд нийцүүлэн тусган авах, боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь Үндсэн хуулийн зөрчилтэй зүйл, заалт өмнө дурдсан шалтгаанаар хэвээр үлдэх, Үндсэн хуулийн хяналтаас гадуур орхигдох тохиолдол гарч болохыг үгүйсгэж болохгүй юм.

Мөн Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа маргагч талуудыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн этгээдийн эрх зүйн байдал, хүлээх хариуцлагыг судалж холбогдох хуульд оновчтой зөв зохицуулалт тогтоож өгөх асуудал анхаарал татаж байна. Ялангуяа, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүрэг болон хүлээх хариуцлагад онцгой анхааравал зохино. Цэцийн хуралдаанд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч маргаанд оролцож, байр сууриа илэрхийлж байгаа байдлаас ажиглахад төлөөлөх эрхийн агуулга, эрх хэмжээний хүрээ хязгаар ойлгомжгүй, маргаж буй зүйлийн талаарх байр суурь нь итгэмжлэл авсан этгээдийн хувийн байр суурь уу? үгүй юу? гэдэг нь ч ойлгогдохгүй, түүнээс гарах үр дагаварыг хариуцах хариуцлагыг огт бодолцохгүй итгэмжлэл олгож байна.

ОХУ зэрэг зарим улсад Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны нэг тал болох Хууль тогтоох байгууллага, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх гэх мэт төрийн байгууллагыг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тодорхой хүнийг томилдог жишиг

байна. Тэрхүү итгэмжлэгдсэн төлөөлөгч нь тодорхой хугацаанд байнга, тогтмол төлөөлөх эрхтэй ба ихэвчлэн Үндсэн хуулийн эрх зүй судлаач, мэргэшсэн хуульч хүнийг томилдог байна. Энэ жишгээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн байгууллага, албан тушаалтныг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олговол Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх онолын шүүх гэх агуулгад ойртоно гэсэн үг.

Эцэст нь тэмдэглэхэд, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч бүрийн эдлэх эрхийг бус, хүлээх үүргийг өргөн агуулгаар тогтоох замаар хариуцлагыг төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

----- оОо -----

хууль зүйн үндэсний хүүрээлэл
www.nli.gov.mn

Сонгуулийн пропорциональ тогтолцоо ба Монгол Улсын Үндсэн хууль



ХЗҮХ-гийн Захиргаа, хүмүүнлэгийн
эрх зүйн секторын эрдэм шинжилгээний
ажилтан, магистр (LL.M) А.Түвшинтулга

Түлхүүр үгс: Үндсэн хууль, сонгууль, сонгох, сонгогдох эрх, сонгуулийн тогтолцоо, пропорциональ (хувь тэнцүүлэх), олонх дийлэнхийн (мажоритар) тогтолцоо, сонгуулийн хууль.

Энэхүү өгцүдэлээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай шинэ хуулийн хуулийн цээл санаа, зохицуулалт, сонгуулийн тогтолцооны сонгосон хувилбар, түүний оновчтой эсэх байдал, Үндсэн хуулийн харилцан хамаарлын талаар хөндөхийг зорив.

1990 ОНЫ СОНГУУЛИЙН ҮР ДҮН, СОНГОСОН ТОГТОЛЦОО

Монгол Улс ардчилсан сонгуулийн системд шилжин, сонгуулиа явуулсаар даруй 22 жилийг ардаа орхижээ. Энэ хугацаанд УИХ-ын болон орон нутгийн ИТХ-ын таван удаагийн сонгууль болсон. Эдгээрээс Улсын Их Хурал болон тухайн үеийн Ардын Их Хурал, Улсын Бага хурлын сонгуулийн талаар товч авч дурдавэл:

1990 оны Ардын Их Хурал болон Улсын Бага Хурлын сонгууль нь Ардын Их Хурал (цаашид АИХ гэх)-ыг анх удаа олон нам, бүлгийн оролцсон олонхын (можаритар) зарчмаар, Улсын Бага Хурлыг (цаашид

УБХ гэх) АИХ-ын депутатууд төлөөлөн сонгогчид маягаар хувь тэнцүүлэх (пропорциональ) зарчмаар сонгох анхны туршилт болсон нь энэ сонгуулийн гол онцлог болов¹.

Улсын Их Хурал (цаашид УИХ гэх)-ын сонгуультай нэгэн зэрэг "Та аль намыг дэмждэг вэ?" гэсэн асуултаар ард нийтийн санал асуулга явуулав. Санал асуулгад УДШ-д шинээр бүртгэгдсэн намууд хамрагдаж сонгогчдын зохих хувийн үнэлэмж авчээ. Сонгогчдын 60 хувь нь МАХН-ыг, 24 хувь нь Монголын Ардчилсан (МоАН) намыг, 6 хувь нь Монголын Үндэсний дэвшлийн (МҮДН) намыг, 5 хувь нь МСДН-г дэмжсэн санал өгснөөр тэдгээр нь УБХ-д суудал эзлэх болжээ. Сонгогчдын 5 түүнээс дээш хувийн санал авсан намд Улсын Бага Хурал тэр хувь хэмжээндээ тохирсон тооны гишүүний нэр дэвшүүлэх эрх олгов. Иймд намын нэрээр сонгогчдын санал хураасны үр дүн нь Монголд улс төрийн олон нам оршин хөгжихийг ард түмэн хүлээн зөвшөөрч буйг илтгэн харуулахын хамт хууль тогтоох байгууллагын сонгуульд хувь тэнцүүлэн сонгох тогтолцоо нэвтрүүлэх урьдач нөхцөл бүрджээ. АИХ ба УБХ-ыг ардчилсан үндсэн дээр олон намын оролцоотойгоор олонхын болон хувь тэнцүүлэн сонгох аргын аль амыг хэрэглэн бүрдүүлсэн нь сонгуулийн ардчилсан шинэтгэлийн төдийгүй, Монголын улс төрийн харилцааны шинэтгэлийн анхны гол ахам болсон юм².

1992 ОНООС ХОЙШИХ СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ СОНГОЛТ

УИХ-ын хувьд Үндсэн хуулийн дагуу шинэчлэгдсэн Сонгуулийн хуулиар анхны сонгууль 1992 оны 6 дутаар сарын 29-нд болжээ. Түүнээс хойш УИХ-ын ээлжит сонгууль 1996, 2000, 2004, 2008 онд болов. Эдгээр 5 удаагийн сонгуулийг Үндсэн хуульд тодорхойлсон сонгуулийн эрх зүйн зарчмын дагуу явуулсан бөгөөд УИХ-ын гишүүдийг 1992 онд олон (буюу 2-4) мандаттай 26 тойргоос сонгосон бол 1996, 2000, 2004 онд тус бүр нэг мандаттай 76 тойргоос, 2008 онд 1992 оныхтой адил 2-4 мандаттай томсгосон 26 тойрогтойгоос³ тус тус сонгож парламентаа бүрдүүлж байжээ. Ийм байдлаар манай улс 1992 оноос хойш дан олонхийлэнхийн (цаашид ОД гэх) системийн хоёр хувилбарыг УИХ-ын сонгуульд хэрэглэж ирсэн юм.

¹ Б.Чимид, "Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу?", Үндсэн хуульд ёсны төлөөшил цувралын IV, Уб., 2011 он, 35 дэх тал.

² Монгол Улсын Парламент (1990-2000). УИХ-ын Тамгын газар. Уб., 2000 он, 14 дэх тал.

³ Б.Чимид, "Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу?", Үндсэн хуульд ёсны төлөөшил цувралын IV, Уб., 2011 он, 35-36 дэх тал.

⁴ "2008 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын мониторингийн тайлан", Сонгогчдын Боловсрол Төв, ННФ, 2008 он.

2011 ОНЫ ШИНЭ СОНГУУЛИЙН ХУУЛЬ ДАХЬ СОНГУУЛИЙН СИСТЕМИЙН СОНГОЛТ БА ҮНДСЭН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Сонгуулийн тогтолцоогоо⁴ өөрчилсөн ихэнх орон нэг бол харьцангуй олонхийн тогтолцоогоо хувь тэнцүүлсэн тогтолцооны элементээр баяжуулах (Параллель эсвэл Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо болгож) эсвэл хуучин тогтолцоогоо бүхэлд нь намын жагсаалтаар санал хураадаг ХТ тогтолцоо (ЖХТ)-гоор солих замаар хувь тэнцүүлэх тал руугаа илүү чиглүүлэх болсон байна. Хамгийн түгээмэл хийгдсэн шилжилт бол харьцангуй олонхийн тогтолцооноос холимог тогтолцоонд шилжих явдал байсан бөгөөд үүний эсрэг чиглэлд шилжилт хийсэн жишээ огт байхгүй байна.⁵ Дэлхий нийтийн эл жишгийн дагуу манай улс 5 удаагийн сонгууль явуулж ирсэн ОД сонгуулийн тогтолцооны хувилбараа өөрчлөх алхамыг хийсэн нь нэг талаар дэвшилттэй боловч сонгуулийн тогтолцооны сонгосон хувилбар болон бусад олон шүүмжлэлийг шинээр батлагдсан МУИХСТХ дагуулж байгаа билээ.

Манай улс 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай (цаашид МУИХСТХ гэх) хуулиар⁶ 2012 оны сонгуулийг сонгуулийн холимог (хосолсон) тогтолцооны хувилбар буюу МУИХСТХ-ийн 4.9-д “Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл (цаашид “нам, эвсэл” гэх)-ийн жагсаалтаас тус тус сонгоно.” гэсэн заалтын дагуу можаритар болон пропорциональ тогтолцооны хосолсон хэлбэрийн нэг хувилбарыг сонгож хуульчилсан билээ.

⁴ Сонгуулийн тогтолцоо гэдэг нь: Хамгийн энгийнээр хэлэхэд сонгуулийн тогтолцоо нь ачилаа сонгуульд иргэдийн өгсөн саналыг нам, нэр дэвшигчдийн авах чандатын тоонд шилжүүлэх арга замтай хэлнэ. Үүнийг тодорхойлоход гол хувьсагчид нь сонгуулийн тогтолцооны хувилбар, суудал хуваарилал томьёо (олонхын, хувь тэнцүүлсэн, холимог эсвэл өөр ямар тогтолцоо ашиглаж байгаа, суудлын хуваарилалтыг ямар математик томьёо ашиглан тооцоолох гэх мэт), саналын хуваасны бүтэц (сонгогч нам эсвэл нэр дэвшигчийн ашид санал өгч байна, дөхлөн нэг сонголт хийх үү эсвэл хэд хэдэн сонголт хийж боломжтой юу), сонгуулийн тойргийн цар хүрээ (тухайн тойрог хэдэн сонгогчтой байгаагаар бийн, тойргоос хууль тогтоох байгууллагад хэдэн төлөөлөгч сонгогдож байгаагаар илэрхийлэгдэнэ) юм.

⁵ “Сонгуулийн тогтолцооны бүтэц зохион байгуулалт: Ардчилал”, Сонгуулийн туслахдааны олон улсын хүрээлэнгийн шинэ гарын авлага, эрхэн хэвлүүлсэн: “Нээлттэй нийгэм форум”, Орчуулсан Г.Батбаяр, хянасан Э.Ернхтөө, Д.Энхцүг, Уб., 2010 он, 7 дахь тал. “BCI” хэвлэлийн газар.

⁶ Мөн тэнд, 33 дахь тал.

⁶ Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” мэдээллийн 2012 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

Сонгуулийн ямар тогтолцоог сонгох вэ? гэдэг нь аливаа ардчилсан улс орны улс төрийн институцийн хувьд хамгийн чухал шийдвэрийн нэг байдаг.

Сонгуулийн можаритар болон пропорциональ тогтолцооны давуу талыг ашиглах, сул талыг орхиход чиглэж аль ашиныг нь хосолсон тогтолцоог зарим улс оронд хэрэглэх нь бий.⁷

Энэ нь сонгуулийн хоёр тогтолцооны аль нэг тогтолцоогоор сонгууль явуулахад нийгмийн бүх гишүүдийн эрх ашиг, хүсэл эрмэлзлэлийг бүрэн дүүрэн илэрхийлж чаддаггүйтэй холбоотой юм. Шинээр батлагдсан МУИХСТХ баталсан цагаасаа эхлэн маргаан дагуулж ирсэн⁸ бөгөөд хууль тогтоогчоос Сонгуулийн тухай хуулийг батлахдаа ямар тогтолцоог сонгох нь түүний бүрэн эрхийн асуудал боловч сонгуулийн олонын (можаритар) болон хувь тэнцүүлэх (пропорциональ) тогтолцооны аль нэгийг нь үү, эсхүл аль алиных нь шинжийг агуулсан хадимог тогтолцоог сонгосон уу гэдгээс үл хамааран Үндсэн хуулийн сонгуулийн суурь зарчим, үзэл санаанууд зөрчилдөх ёсгүй гэж нэр бүхий иргэд үзэн Үндсэн хуулийн цэцэд хандаж МУИХСТХ-ийн зарим зүйл, заалтыг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болох шийдвэрийг гаргасан билээ⁹. Өөрөөр хэлбэл энэ нь сонгуулийн эрх зүйн зохицуулалт, сонгуулийн тогтолцооны асуудлыг Үндсэн хуулийн болон төрийн институцуудын өргөн хүрээтэй бүтэц тогтолцооноос салган авч үзэх аргагүй байдгийн илрэл юм. Сонгуультай холбоотой нэг амин чухал асуудал бол сонгуулийн тогтолцоог сонгох тухай шийдвэр байдаг.

Тэгвэл өөр бас маргаан дагуулж буй зүйл бол сонгуулийн пропорциональ тогтолцоог сонгох тухай асуудал бөгөөд энэ систем нь өөрөө Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзэх хэсэг байна.

Учир нь Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” хэмээн зааж Монгол Улсад “шууд сонгох” эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж өгсөн байна. Шууд сонгох эрх нь хоёр үндсэн агуулгатай бөгөөд, үүнд: Нэгдүгээрт, ямар нэг төлөөлөлгүйгээр саналаа өөрөө гаргах. Хоёрдугаарт, сонгогчийн санал сонгуулийн хувьд “эцсийн шийдвэрийг гаргах” бөгөөд сонгуулийн үр

⁷ Тухайлбал Япон Улс г.м

⁸ УИХ-ын сонгуулийн тухай 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуулийн холбогдох зүйл, заалт Үндсэн хуультай зөрчилдсөн эсэх асуудлаар 2012 оны 3 дугаар сарын байдлаар 17 иргэнээс мэдээлэл гаргасна. Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дунд суудлын хуралданы үер нарийн бичгийн дарга Н.Болортуулгачагийн Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Амарсанаагийн асуултад өгсөн хариуцаас.

⁹ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 2 дугаар дүгнээт.

дүнг шууд тодорхойлно. Энэ нь сонгогчдын санал болон сонгуулийн эцсийн үр дүн хоёрын дундуур өөр хэн нэгэн орж ямар нэг өөрчлөлт хийхгүй байх, сонгогчдын саналаас үл хамаарах нөхцөл сонгуулийн үр дүнд нөлөөлөхгүй байх тухай агуулгатай.

Гэтэл пропорциональ тогтолцоогоор намд өгсөн саналаар сонгогдох 28 гишүүнийг шууд сонгох зарчмыг алдагдуулахад хүргэж байна гэж үзэх хэсэг байна. Түүнчлэн Үндсэн хуульд УИХ-ын гишүүнийг сонгоно гэснээс намыг сонгоно гэж заагаагүй гэх мэтээр тайлбарлаж байна¹⁰.

Харин эл санааг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид өөрийн бүтээлдээ эрс няцааж дараах байдлаар тайлбарлажээ. (Чимид Б. Сонгуулийн тогтолцоонд ард, түмэн түүний Үндсэн хууль буруутай юу?! Уб., 2011. 39, 48-51 дэх талаас)

“Үндсэн хуулийн Харин нэгдүгээр зүйлд “УИХ-ын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно” гэж заасан байна.

Энэ бол сонгуулийн тогтолцооны тухай биш харин түүний үндэс болсон сонгуулийн эрх зүйн үндсэн зарчмыг тодорхойлсон заалт юм. Гэтэл үүнийг сонгуулийн тогтолцоо гэх олон эрэмбийн ойлголтын нэг хувилбар болох сонгогчдын саналыг дүгнэж, гишүүний (мандат) суудал хуваарилах арга болсон “можаритар”, “пропорциональ” тогтолцоотой хутган ойлгоод Үндсэн хуулийн дээрх заалтыг өөрчлөх, барих тухай өгүүлцгээх болов.

Шуудхан хэлэхэд ардчилсан сонгуулийн эрх зүйн тогтолцооны үндсэн зарчим нь улс орнуудын үндэсний болон олон улсын эрх зүйд тодорхойлсон бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчим гэдэг маргаангүй. Өөр үүсмэл зарчмуудтай хутгахгүйн тулд олон орон судалсан эрдэмтэд “Бүх нийтийн, тэгш, шууд бөгөөд саналаа нууцаар гаргах зарчмууд бол гадаад орнуудын сонгуулийн эрх зүйн нэн чухал зарчим мөн”-ийг олон талаар нотлон тайлбарласан байна¹¹. Иймэрхүү тодорхойлолт олон бий.

Энэхүү суурь болсон их ухагдахууны үүднээс үзвэл манай Үндсэн хуульд тодорхойлсон үндэслэлүүд чинь сонгуулийн тогтолцоо, сонгуулийн эрхийн үндсэн зарчим юм. Энэ бол улс төр, хууль зүйн эрдэмтдийн бүтээлд аль хэдий нь томьсолж, Монголд бол аль 20 дугаар зууны

¹⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны үеэр мэдээлэл гаргаж иргэн Н.Чадраабалын тайлбараас.

¹¹ Конституционные основы зарубежных стран. Под общей ред. Член КС РФ проф. РАН М.Б.Баглаж, др. юр/н; проф. Ю.И. Лейбо; др. юр/н; проф. А.М.Эштина. 2-е издание. М.: “Норма”. С. 237.

дундуур нэвтэрч хэвшсэн ойлголт болно.

Хамгийн гол нь үндсэн тогтолцоо, түгээмэл зарчмын хүрээнд дээрх 2 арга буюу дэд тогтолцоооны алиныг нь ч зохистойгоор хэрэглэж болно. Харин олонхын болон хувь тэнцүүлсэн тогтолцоооны аль нэгийг (тухайн үеийн улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалаад) дагнаж буюу эсвэл хольж хэрэглэхээр Үндсэн хуульд бичиж оруулбал Үндсэн зарчмаа үгүйсгэж ОУ-ын эрх зүйтэй зөрчилдөхөөс гадна тэр аргаа өөрчлөх, солих тоолонд Үндсэн хуулиа хөндөхөд хүргэнэ.

Дээр өгүүлсэн баримтуудад тулгуурлан Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид дараах дүгнэлтийг хийжээ. Үүнд сонгуулийн эрх зүйн тогтолцоооны зарчмыг тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг буруутгах үндэс, нөхцөл, үйл баримт байхгүй байна; Сонгуулийн эрх зүйн тогтолцоооны дээр нэрлэсэн зарчмууд нь сонгуулийн санал тооцох, суудал хуваарилах аргын 2 зарчмыг дангаар нь болон хослон (холимоогоор) хэрэглэхэд саад болохгүй хэмээн үзжээ¹².

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД СОНГУУЛИЙН ПРОПОРЦИОНАЛЬ СИСТЕМИЙН ЯМАР ХУВИЛБАР ТУССАН БЭ?

Дээр сонгуулийн тогтолцоооны аль ч хувилбар нь одоогийн Үндсэн хуультай зөрчилдөхүү үгүй юу гэдэг талаар дурдсан. Харин энд эл сэдвийн хүрээнд асуудлыг хөндөхийн өмнө хувь тэнцүүлэх (цаашид ХТ гэж) тогтолцоо, түүний эерэг сөрөг үр дагаврын талаар дурдах нь зүйтэй юм.

Пропорциональ буюу хувь тэнцүүлэх тогтолцоо гэж нэг тойрогт өрсөлдсөн нам, бүлэг, нэр дэвшигчдийн хооронд авсан саналын хувь хэмжээгээр нь гишүүний мандатыг буюу манайхны хэлдгээр суудал хуваарилах аргыг хэлдэг байна. Товчилбол тэдний авсан саналаар суудал хуваарилах гэсэн үг. Энэ нь намуудад, улс төрийн амьдрал дахь өөр өөрийн нөлөө, сонгогчдын дунд олсон нэр хүндээрээ сонгуульт байгууллагад төлөөлөх арай илүү боломжийг олгодог.

Парламентын гишүүний мандат буюу суудлыг намуудад тэдгээрийн авсан саналын хувь хэмжээгээр хуваарилах тогтолцоо юм. Энэ систем нь дотроо өөр өөрийн онцлог бүхий хэд хэдэн хувилбартай юм.

¹² Б.Чимид, "Сонгуулийн тогтолцоолд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу?" Үндсэн хуульд ёсны төлөвшил цувралын IV. У6., 2011 он, 50 дахь тал.

*Сонгуулийн хувь тэнцүүлэх системийн хувилбар*¹³

ХТ сонгуулийн систем нь дотроо олон хувилбартай байдаг. Тухайлбал, тойрог байгуулах, санал тоолох аргачлалаараа:

- нэг шилжих санал (цаашид НШС гэх);
- намын жагсаалтаар хураах ХТ (цаашид НЖХ гэх);
- нэр дэвшигчид тулсан ХТ (цаашид НДТ) гэх мэт хэлбэртэй.

Парламент хэт олон жижиг намаас бүрдэхэд хүргэдэг ХТ сонгуулийн сул талыг нөхөхийн тулд босго тавихаас гадна санал тоолоход хэрэглэх Хэйрийн квот, Друппин квот, Импернал квот гэхчилэн олон арга байдаг ХТ-ийн эдгээр хэлбэрийг, босгын хувь, квот тооцох аргачлалтай нь хослуулахад маш олон хувилбар гардаг.

НШС-ын систем нь нэлээд төвөгтэй боловч сонгогчийн саналыг гээдэггүй сайн талтай хэмээн үзэж, сүүлийн үед түгээмэл хэрэглэх болсон ажээ. Саналын хуудсанд намаас нэр дэвшигчдийн нэрс ба тойрогт ялсан нэр дэвшигчийн босго давсан саналыг босго давж чадаагүй бусдад нь тэгшитгэн хуваарилах замаар дараагийн ялагчийг тодруулах, мөн илүү гарсан саналыг дахин тэгшитгэн хуваах зэргээр шалгаруулах систем юм.

НЖХ хэлбэр нь нийтэд ойлгомжтой, энгийн хувилбар юм. НЖХ нь дотроо нэлээд хэдэн хувилбартай. Саналын хуудсанд зөвхөн намын нэрс байх ба нам сонгуулийн дараа авсан мандатынхаа тоогоор парламентад гишүүдээ томилдог нэг хувилбар бий. Энэ бол нэлээд эртний хувилбар юм. Үүний арай боловсронгуй хувилбар нь намууд парламентад сонгогдох гишүүдээ эхнээс дараалуулж жагсаагаад, эл жагсаалтаа урьдчилсан зарладаг хэлбэр юм. Сонгогч өөрийн үзэмжээр нэр дэвшигчид санал өгөх боломжгүй, хүссэн нэр дэвшигчээ дэмжин жагсаалтын дарааллыг өөрчлөх боломжгүй байдгаараа энэ систем сул талтай. Намын жагсаалт бүхий хувь тэнцүүлэх систем бол хамгийн энгийн систем юм. Энэ системийг Нидерланд зэрэг олон улсад хамгийн түгээмэл хэрэглэдэг ажээ. Намд хуваарилсан мандатыг жагсаалтад байгаа дарааллаараа нэр дэвшигчдэд хуваарилна. Жилшээ нь, жагсаалтад 50 нэр дэвшигчийг жагсаасан атал нам 30 мандат авбал эл жагсаалтад буй эхний 30 хүн парламентын гишүүн болно гэсэн үг.

Манай улс 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан МУИХСТХ-ийн пропорциональ тогтолцооны хувилбартаа ХТ-ийн энэ хувилбарыг хуульчилсан юм¹⁴. Ингэхдээ сонгогчид намд санал өгөх ба

¹³ "Монгол Улсад сонгуулийн хувь тэнцүүлэх системийн аль хувилбар илүү тохиромжтой вэ?" Судалгааны тайлангаас.

¹⁴ Увсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн (2011 он) 4.9, 5-ны хуулийн 27.1-д заасан нэрийн

нам авсан саналынхаа хувиар гишүүдээ эрэмбэлэн 28 гишүүний суудал хуваарилах юм.

ХТ-ийн системийн энэ хувилбар нь өөрийн гэсэн эерэг, сөрөг талтай байна¹⁵.

Эерэг тал

- Сонгуулийн дүн савладаггүй;
- Гишүүд тойрогийн сонирхлыг бус харин намын сонирхлыг илүү хамгаалдаг;
- Жижиг намын төлөвшилд сайнаар нөлөөлдөг;
- Парламент дахь улс төрийн хүчнүүд харилцан тэнцвэртэй бүрддэг;
- Сонгогчдын санал гээгддэггүй;
- Парламентын гишүүнийг эгүүлэн татах асуудалд намын нөлөө оролцоо ихэснэ.

Сөрөг тал

- Парламентын дотоодод нь сарнилдаг. Үүний жишээ бол Ваймарын Бүгд Найрамдах Улс хэмээн түүхэнд нэршсэн 1919-1933 онд Германд тогтнож байсан ардчилал бөгөөд парламентад олон жижиг нам орсноор гүйцэтгэх засаглалд тавих хяналт суларсан гэж үздэг. Энэ жишээ нь Ерөнхийлөгчийн засаглалын үед парламентыг хувь тэнцүүлэх системээр сонгох нь оновчгүй болохыг үзүүлсэн;
- ХТ систем нь хүн амын тухайн үеийн улс төрийн дүр зургийг "хуулан буулгах"-д чиглэдэг. Гэтэл энэ нь оновчтой төлөөллийг төдийлөн өгч чадахгүй;
- Орон нутгийн буюу үндэсний цөөнхийн нам байгуулагддаг;
- Нам нь дотооддоо авлигад идэгдэх магадлалтай.

НДТ нь НЖ-ийн сул талыг нөхөх хамгийн давшингүй оролдлого юм. Personalized PR буюу Нэр дэвшигчид тулгуурласан систем бол ХТ системийн сул талыг нөхөхөд чиглэсэн байдаг. Энэ системийг Швейцарь зэрэг оронд хэрэглэдэг байна. Намаас нэр дэвшигчийг дугаарлахгүй, харин сонгогч нэр дэвшигчдийг дугаарлагдгаараа НЖ-аас илүү давуулаг болсон байдаг. Саналын хуудсанд зөвхөн намын нэрс төдийгүй, намаас нэр дэвшигчдийн нэрс аливаа дугаар, дараалалгүй байх ба сонгогч өөрт жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойрогт, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.16-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл (цаашид "нам, эвсэл" гэх)-ийн жагсаалтаас тус тус сонгоно."

¹⁵ Монгол Улсад сонгуулийн хувь тэнцүүлэх системийн аль хувиар илүү тохиромжтой вэ? Судалгааны тайлангаас.

буй саналаараа нэр дэвшигчийг дугаарлаж, жагсаадаг байна. Энэ нь ХТ системд сонгогч нэр дэвшигчийн төлөө санал өгч болдогоороо онцлогтой хувилбар билээ.

ХТ-ны энэ хувилбар оновчтой гэж үзэн УИХ-ын гишүүн Лу.Болд санаачлан Монгол Улсын хөдөлмөрийн баатар, ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид нар боловсруулсан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлдөө¹⁶ “хүнээ шууд сонгох”-ыг хамгийн зөвд үзэн хувь тэнцүүлэн сонгох аргын шилдэг нь болох “үлэмж таатай нөхцөлийн зарчим” гэдэг “нам-хүн хоёрыг нэгэн зэрэг дугуйлах” хувилбараар тодорхойлсон. Тэр ёсоор сонгогч нь саналын хуудас аваад УИХ-ын гишүүнд нэр дэвшүүлсэн аль намыг дэмжиж байгаагаа тэмдэглэхийн (дугуйлахын) хамт тэр намын нэр дэвшигчдийн жагсаалтын дороос хэнийг дэмжихээ шилэн сонгож түүний нэрийн өмнөх дэс дугаарын тоог дугуйлах юм. Өөрөөр хэлбэл “нэг нам-нэг нэр дэвшигч” гэсэн арга зарчмыг эш үндэс болгосон нь булхайцах боломж бага бөгөөд илүү тэгш, шударга болно гэж тооцсон...¹⁷. Өөрөөр хэлбэр хуулийн төсөлдөө ХТ-ны эл хувилбарыг сонгож тусгасан ажээ.

Мэдээж, ХТ-ийн аль ч хувилбар манай орны намын төлөвшил, парламентын зөвшлийн соёл нэвтрүүлэхэд эерэг нөлөөтэй болох нь дамжиггүй юм.

Гэвч ХТ системийн сөрөг талыг сааруулах талаас нь ч бодолцон сонголт хийх нь зүйтэй юм.¹⁸

Иймээс сонголт хийх үндсэн шалгууртаа дараах зүйлийг харгалзан үзэх нь чухал ажээ. Үүнд:

- намын төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх. Үүнд намын төлөвшлийн гол шалгуур нь парламентын хүрээнд зөвшилцөлд хүрэх чадвар юм;
- сонгогчийн санал гээгдэхгүй байх;
- парламентад хэт олон жижиг нам орж ирэхээс сэргийлэх;
- олон нийтэд ойлгомжтой байх;
- сонгогч нэр дэвшигчийн хувийн мөн чанарыг харгалзах бололцоотой байх;
- санал тоолох аргачлал нь хялбар байх зэрэг шалгуурыг үндэс болгодог байна.

¹⁶ Улсын Их Хурлын гишүүн Лу.Болд гишүүн Б.Чимид нарын боловсруулсан УИХСТ хуулийн төсөлд тусгахдаа сонгуулийг томсгосон тойргоор, тойрогт ногдох мандатыг хувь тэнцүүлэн хувиарлах аргыг хэрэглэн эхлэн байгуулахаар төслийн “6.1.4 Монгол Улсын Их Хурлын сонгуулиар гишүүнд нэр дэвшүүлэх, сонгогчдын санал авах, саналын дүнг тооцож УИХ-ын гишүүний мандат (суудал) хуваарилах үйл ажиллагааг олон мандаттай тойрогт хувь тэнцүүлэн сонгох аргаар эхлэн явуулна.” гэж заажээ.

¹⁷ Б.Чимид, “Сонгуулийн гэгтгэцэнд яд түмэн, түүний Үндсэн хуучь буруутай юу?!” Үндсэн хууль ёсны төлөвшил цувралын IV, Уб., 2011 он, 51 дэх тал.

¹⁸ Монгол Улсад сонгуулийн хувь тэнцүүлэх системийн аль хувилбар нүүр тохиромжтой вэ? судалгааны тайлангаас

Дээр өгүүлсэн шалгуурыг үндэс болговол манай орны нөхцөлд нэр дэвшигчид тулгуурласан хувь тэнцүүлэх системийг 5 хувийн босготой авч хэрэглэх нь зүйтэй байна. НЖ-ийн хэлбэр нь намын төлөвшилд төдий сайнаар нөлөөлөхгүй байж магадгүй. НЖ ХТ системийг хэрэглэсэн оронд сонгуулийн нэрсийн жагсаалтад дээгүүр байранд дугаарлуулахын төлөө эрчимтэй өрсөлдөөн болдог. НДТ систем нь олонх, дийлэнхийн НМТ-ын системээс шилжих энэ үед сонгогчдод илүү ойлгомжтой юм. Харин НШС-ын хэлбэр нь ойлгож, зөв хэрэглэхэд хэтэрхий түвэгтэй, магадгүй санал тоолох явцад маргаантай асуудал олон гарах магадлалтай билээ.

Түүнээс гадна, НДТ хэлбэр нь сонгогч нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг харгалзах бололцоо олгодог. Манай улсад санал тоолохдоо квот тогтоох Хэйрийн аргачлалыг хэрэглэж болох юм. Сонгуулийн дүнд хэт олон нам парламентад орж, парламент сарнихаас сэргийлэх үндсэн механизмын нэг бол босго тавих явдал юм. Дэлхий нийт ерөнхийдөө 3-5 хувийн босго тавьсан байдаг.

Харин санал болгож буй хувилбарт 5 хувийн босго¹⁹ тавих нь зүйтэй хэмээн үзжээ²⁰. Шинэчлэн батлагдсан МУИХСТХ-д сонгуулийн нэгдсэн дүн гаргах, суудал хуваарилах аргачлалд энэ 5 хувийн босгыг намуудын улсын хэмжээнд авсан саналын хувьд босго болгон заасан нь бий гэхдээ дээр дурдсанаар ХТ-ны НДТ буюу “үлэмж таатай нөхцөлийн зарчим” гэдэг хувилбарыг сонгодог утгаар нь хэрэглээгүй зөвхөн ХТ-ны өөр нэг хувилбар болох намын жагсаалтаар хураах ХТ сонгосон болохыг дээр дурдсан билээ.

ДҮГНЭЛТ

Ардчилсан улс орнуудад иргэдийн төрийн үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрх буюу иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд можаритар (ОД), пропорциональ (ХТ), холимог гэсэн 3 үндсэн хэлбэрээр явуулдаг бөгөөд эдгээр нь дотроо олон хувилбаруудтай байдаг. Монгол Улсын хувьд зарим улс орны нэгэн адил холимог системийг хэрэглэх оролдлого хийж байгаа нь дэвшилттэй бөгөөд сайн талтай юм. Харин

¹⁹ МУИХСТХ-ийн 49.1.1-д “нам, эвсэл тус бүрийн авсан нийт саналын тоог гаргаж, бүх нам, эвсмийн авсан нийт саналын тавасг доошгүй хувийн санал авсан нам, эвсмийг авсан саналын хувиар нь дараалалд оруулан жагсаалт (цаашид “Б” жагсаалт” гэх)-ыг гаргах”; 49.1.2-д “энэ хуулийн 49.1.1-д заасан танаа хувийн босгыг даваагүй нам, эвсмийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваан “Б” жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцох”;

²⁰ Монгол Улсад сонгуулийн хувь тэнцүүлэх системийн аль хувилбар нүү тохиромжтой вэ? Судалгааны тайлангаас.

гагцхүү сонгуулийн ямар тогтолцооны аль хувилбарыг үүн дотроо аль сайн хувилбарыг сонгосон уу гэдэг нь хамгийн чухал асуудал юм.

Сонгууль бол угтаа шууд ардчилалын гол хэлбэр юм²¹. Иймээс сонгуулийн аль ч тогтолцоог хэрэглэсэн сонгогчдын шууд оролцоог хангах үндсэн зарчим, Үндсэн хуулийн суурь зарчим, үзэл санаа зөрчигдөх ёсгүй билээ.

Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн баримт бичиг болох ХЭТТ, ИБУТЭТОУП, АҮЯБХУТОУК, ЭҮТЭТК, ЭАБХУТК зэрэг нь сонгуулийн эрх зүйн сурвалж бөгөөд эдгээрт сонгуулийн шууд байх зарчмыг тодорхой тусгасан. Энэ ч үүднээс улс орнуудын Үндсэн хуульд сонгууль шууд байх зарчмыг хуульчлан баталгаажуулдаг болохоос сонгуулийн тогтолцооны хувилбарыг Үндсэн хуулиар тодорхойлсон нь үгүй байна. Манай улсын Үндсэн хууль ч ийм зарчмыг баримталжээ. Тиймээс сонгуулийн тогтолцооны хувилбарт тулгуурлаж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах нь Үндсэн хуулийн хямарлыг үүсгэхэд ч хүрч болзошгүй төдийгүй магадгүй 4 жилээр Үндсэн хуульд өөрчлөлт оруулан сонгуулийн тогтолцоогоо өөрчлөх нөхцөл байдал үүсч болохыг ч үгүйсгэх аргагүй юм.

Нөгөөтэйгүүр дэлхийн олон улсад сонгууль явуулах тогтолцооны арга нь пропорциональ тогтолцоотой байлаа ч Үндсэн хуульдаа “шууд” сонгох зарчмыг тусгаж өгсөн орнууд багагүй байдаг билээ²². Иймээс Үндсэн хуулийн суурь зарчим түүний агуулгыг нарийн сайн судлан үзэх, сонгуулийн тогтолцооны мөн чанар, сонгуулийн эрхийн гол үзэл санаа зэргийг нарийн зааглан онолын суурь ойлголтыг харгалзан үзэж энэхүү нийтлэлээр хөндсөн асуудалд хандах нь хамгаас чухал юм.

----- оОо -----

²¹ Б.Чимид, “Сонгуульд суралцахуй тогтолцоо, үйл явц эрх зүй”, Ув., 2008 он, 54 дэх тал.

²² Хамсралт хүснэгтээс харна уу.

Хавсралт²³

№	Улсын нэр Парламентын нэр	Үндсэн хуулийн зүйл, заалт	Сонгуулийн систем
1.	БОЛГАР Ардын хурал	10 дутаар зүйл. Сонгууль үндэсний болон орон нутгийн санал асуулгыг бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр нууц санал хураалтаар явуулна.	Цэвэр пропорциональ тогтолцоотой
2.	СЛОВАК Үндэсний Зөвлөл	74 дүгээр зүйл. Депутатуудыг бүх нийтийн, тэгш байдал, шууд сонгох эрхийн хүрээнд явагдах сонгуульд саналаа нууцаар хурааж сонгоно.	
3.	СЛОВЕНИ Үндэсний хурал	80 дутаар зүйл. Улсын хурал нь Словенний иргэн 90 депутатаас бүрдэнэ. Депутатуудыг бүх нийтийн, тэгш, шууд сонгох эрхийн хүрээнд явагдах сонгуульд саналаа нууцаар хурааж сонгоно.	
4.	ЛАТВИ Сейм	6 дутаар зүйл. Сеймийг бүх нийтийн тэгш, шууд сонгуулийн пропорциональ тогтолцоогоор сонгоно.	
5.	ЧЕХ Төлөөлөгчдийн Хурал	18 дутаар зүйл. 1.Төлөөлөгчдийн хурлын сонгууль бүх нийтийн, тэгш байдлын эрхийн хүрээнд төлөөллийн хувь тэнцүүлэх зарчмын дагуу нууц санал хураалтаар шууд сонгуулиар явагдана. 2.Сенатын сонгууль бүх нийтийн, тэгш байдлын эрхийн хүрээнд мажоритар тогтолцооны зарчмын дагуу шууд сонгуулиар нууц санал хураалтаар явагдана.	
6.	СИРИ Ардын зөвлөл	50 дутаар зүйл. Хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуулийн дагуу Ардын зөвлөл хэрэгжүүлнэ. Ардын зөвлөлийн Депутатыг сонгуулийн тухай хуулийн дагуу хууцаар санал гаргах замаар нийтээр, шууд болон тэгш сонгуулийн эрхэд үндэслэн сонгоно.	

²³ Энэхүү хавсралт дахь судалгааг Б.Чимид, "Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?" Уб., 2010 он. номноос хэсгичлэн авав.

Орон сууцны даатгалын эрх зүйн зохицуулалт: АНУ-ын Флорида, Луизана муж

*Хууль зүйн чндэсний хирээлэнгийн судалгаа**

ОРШИЛ

Даатгалын эрх зүй тэр дундаа орон сууцны даатгалын эрх зүйн асуудал Монгол Улсын төдийгүй дэлхийн хөгжингүй улсуудын хувьд ч шинэлэг ойлголт. Жишээ нь, АНУ-д гэхэд орон сууцны даатгалын зохицуулалтын асуудал 1940-д оны сүүлээр л хууль тогтоогчдын анхаарлын төвд орж ирсэн байна. Ийнхүү богино ч гэлээ үр өгөөж баян түүх бүхий орон сууцны даатгалын зохицуулалтыг Монголын хөрсөн дээр зөв буулгах шаардлага урган гараад байна.

Хүн амын талаас илүү хувь нь хот суурин газар төвлөрч аминий болон нийтийн орон сууц гэх мэт барилгажилтын аян хүчээ авч буй өнөө үед тэдгээр барилгын чанар, байгалийн элдэв үзэгдэлд тэсэн гарах чадвар зэрэг асуудал асуулатын болоод анхаарлын тэмдэг дагуулсаар байгаа билээ. Үүний зэрэгцээ нүүдлийн соёл иргэншлээ хэвээр хадгалсаар байгаа хөдөө орон нутгийн иргэдийн байнга нүүдэллэхэд зориулсан гэр, өвөлжөөний хашаа, худаг гэх мэт онцлог амьдарлын хэв маягт тохирсон зохицуулалт шаардлагатай байна. Ийнхүү нийгэмд тохиолдоод буй асуудлыг шийдвэрлэхэд нэмэр болгох үүднээс бид “Орон сууцны даатгалын зохицуулалт: АНУ-ын Флорида, Луизана муж” сэдэвт судалгааг хийлээ.

Энэхүү судалгааны тайлан нь гурван үндсэн бүлгээс бүрдэх бөгөөд эхний бүлэгт судалгаатай танилцагчдад орон сууцны даатгалын эрх зүйн талаар суурь ойлголт өгөх үүднээс орон сууцны даатгалын ерөнхий ойлголт, эрх зүйн объект, субъект, даатгалын эрсдэл, төрөл, хэлбэр гэх мэт сэдвийг хөндлөө. Харин тайлангийн хоёрдугаар бүлэгт орон сууцны даатгалын зохицуулалт өндөр хөгжсөн АНУ, тэр дундаа цаг агаарын таагүй нөхцөлд өртөх магадлал өндөртэй бүсэд байршдаг Флорида, Луизана мужуудыг сонгон авч судалсан билээ. Тайлангийн гуравдугаар бүлэгт судалгааны дүгнэлт, цаашдын судалгаа болон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудалд судлаачдын зүгээс өгөх саналыг оруулав.

* Судалгааг удирдсан ХЭҮХ-ийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрхлэгч, хууль зүйн доктор (Ph.D) Б.Тэмүүлэн, тус секторын эрдэм шинжилгээний ажилтан магистр (LL.M) Ц.Олжаа, магистр (LL.M) Б.Оюунбилэг.

I. ОРОН СУУЦНЫ ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙН ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

1.1. Орон сууцны даатгалын ойлголт

Орон сууцны даатгал нь орон сууц эзэмшигчийн даатгал болоод гэм хорын даатгал гэсэн нэршлээр хэрэглэгддэг бөгөөд хувийн орон сууцыг даатгах зориулалттай эд хөрөнгийн даатгалын нэг хэлбэр¹ юм. “Орон сууц” гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг ойлгох² ба зарим улсад машин, чингэлэг гэх мэт хүн хонож байнга амьдардаг зүйлийг ч багтаан үздэг.

Энэхүү даатгалд хувь хүний даатгалд хамаарах эд хогшил, орон сууцны, ашиглалтын болоод мөн тухайн даатгагдаж буй орон сууцанд холбогдох хариуцлагын даатгал хамаардаг. Өөрөөр хэлбэл, эд хөрөнгийн болоод хариуцлагын гэсэн хоёр төрлийн даатгалын шинж чанарыг орон сууцны даатгал агуулж нэг даатгалын хураамж төлөгдөнө. Энд мөн түрээсийн байр эзэмшигчдэд зориулсан даатгалын хэлбэр хамаардаг бөгөөд субъект нь тухайн байрыг өмчлөгч бус, оршин суугч байна.

Орон сууцыг нөхөн төлөхөд гарах зардал, тухайн байрыг дагалдан ямар эд зүйлсийг даатгах зэргийг даатгалын баталгаанд нэг бүрчлэн тусгаж оруулна. Иймээс энэ төрлийн даатгалын гэрээ нь нэлээд том хэмжээний гэрээ байх ба юуг нөхөн төлөх, юуг нөхөн төлөхгүй байх ямар нөхцөлд нөхөн төлөх гэх мэтчилэн зохицуулалтыг бүрэн тодорхой оруулах шаардлагатай. Орон сууцны даатгал нь хугацаат гэрээ буюу тодорхой хугацаатайгаар байгуулагдаж хүчин төгөлдөр байдаг гэрээний төрөл юм. Даатгуулагч даатгалын хураамжийг тогтоосон тодорхой хугацаанд төлдөг. Тухайн эд хогшлийн эрсдэлд өртөх магадлалыг тооцоолсны үндсэн дээр даатгалын хураамжийн хэмжээг тогтооно.

Орон сууцны даатгалыг нэрлэх нэршил тухайн даатгалд хамаарах зүйлээс хамаараад янз бүр байдаг. Жишээ нь:

- орон сууцны даатгал³,
- орон сууц эзэмшигчийн даатгал⁴,
- барилга байгууламжийн даатгал⁵,
- нийтийн орон сууц эзэмшигчийн даатгал⁶,
- түрээслэгчийн даатгал⁷... гэх мэт.

¹ <http://en.wikipedia.org/wiki/Homeowners_insurance>. (Хамгийн сүүлд 2012.02.28)

² Орон сууцны тухай Монгол Улсын хууль, (1999). 3 дугаар зүйл, 1 дэх хэсэг.

³ http://en.wikipedia.org/wiki/Home_insurance

⁴ <http://www.geico.com/getaquote/homeowners/>

⁵ www.abi.org.uk

⁶ <http://www.geico.com/information/aboutinsurance/condo/>

⁷ <http://www.rentersinsurance.net/>

Харин даатгалын гэрээгээр ямар орон сууцыг хэрхэн даатгахыг нарийвчлан тогтоодог буюу тохиролцдог байна.

Ингээд орон сууцны даатгалын субъект болоод объект, эрсдлийн талаар дараах хэсэгт авч үзье.

1.2 Орон сууцны даатгалын субъект

Даатгалын эрх зүйн харилцаанд даатгагч, давхар даатгагч, даатгуулагч, даатгалын мэргэжлийн оролцогчид гэх мэт эрх зүйн этгээд оролцдог. Эдгээр этгээдүүд нь даатгалын эрх зүйн гол субъект бөгөөд даатгалын асуудал хариусан төрийн захиргааны байгууллага, актуарч, гуравдагч этгээд зэрэг нь шууд бус субъект болно⁸.

Даатгагч

Даатгалын тухай Монгол Улсын хуульд зааснаар Даатгагч гэдэг нь "...энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийг..." ойлгоно гэж заасан байдаг. Даатгагч нь даатгалын үйл ажиллагаа явуулан, даатгуулагчдаас олсон даатгалын хураамжийн орлогоор даатгалын сан (pool) үүсгэн, хураамжийн орлогоороо учирч болзошгүй хохирлыг нөхөн төлөх зориулалт бүхий даатгалын нөөц сан байгуулан, түүнээсээ хохирол учирсан даатгуулагч нарт нөхөн төлбөрийг олгох үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийг хэлнэ.

Даатгагч нь ашгийн төлөө хуулийн этгээд буюу компани, нөхөрлөл, ашгийн төлөө бус холбоо, сан байж болох ба тэдгээрийн үзүүлэх даатгалын үйлчилгээний төрлийг хуулиар нарийвчлан зохицуулж өгсөн байна. Мөн шаардлагатай бол төрийн өмчит компани ч энэ төрлийн үйлчилгээг үзүүлэх боломжтой.

Даатгуулагч

Даатгуулагч гэдэг нь өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо даатгуулан, хураамж төлж буй этгээдийг ойлгох бөгөөд этгээд гэдэгт хувь хүн, хуулийн этгээдийн⁹ аль аль нь хамаарах юм

Орон сууцны даатгалын тухайд даатгуулагч нь орон сууц өмчлөгч, түрээслэгч, нийтийн зориулалттай талбайг эзэмшигч сууц өмчлөгчдийн холбоо байна. "Орон сууц өмчлөгч" гэж тухайн орон сууцыг захиран зарцуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд, төрийн эрх бүхий байгууллагыг¹⁰ ойлгоно.

⁸ Б.Гүнбилэг, Б.Жавхлан, "Даатгалын эрх зүй", Уб., 2011 он.

⁹ "Даатгалын тухай хууль (2004 он)", 4.1.3 дэх хэсэг.

¹⁰ Орон сууцны тухай хууль (1999 он), 3.1.4 дэх хэсэг.

1.3 Орон сууцны даатгалын объект

Аливаа ашиг сонирхлыг эрсдлээс хамгаалахын тулд даатгаж болох ашиг сонирхлын тухай нэн түрүүнд авч үздэг. Монгол Улсын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.2 дахь хэсэгт зааснаар "Даатгалын зүйл нь эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бүс ашиг сонирхол байна" гэсэн байдаг. Тэгвэл орон сууцны даатгалын тухайд хамаарах зүйлд хамгийн түрүүнд орон сууц, түүнтэй холбогдох эд хөрөнгө, орон сууцанд оршин суугч иргэдийн амь нас, эрүүл мэнд болоод ашиг сонирхол хамаарна.

Орон сууцны тухай хуульд "орон сууц"¹¹ гэж хүн суурьшин амьдрах зориулалттай нийтийн болон амины орон сууцны байшин, сууц, гэрийг ойлгоно хэмээн тодорхойлсон байдаг. Эндээс харахад орон сууцны даатгалын хамаарах гол зүйл болох орон сууц гэдэгт нийтийн зориулалттай угсармал орон сууц, хувийн эзэмшлийн байшин, байр, гэр, цаашлаад зуны байр, өвөлжөө, хаваржаа гэх мэт суурин буюу хөдөлгөөнгүй сууц хамаарахын зэрэгцээ, хөдөлгөөнтэй боловч хүн байнга амьдардаг чингэлэг, амьдрахад зориулсан машин гэх мэт бүхий л хүн амьдрах зориулалтын байруудыг ойлгож болно. Хүн амьдардаг машины хувьд улс бүр өөр өөрөөр зохицуулах ба зарим улсын хувьд энэ төрлийн сууцныг ердийн машин гэж үзэж авто машины даатгалын төрөлд хамааруулах нь бий.

1.4 Орон сууцны даатгалын эрсдэл

Монгол Улсын хууль, журмын хүрээнд орон сууцны даатгалын эрсдэл гэж тусгайлан зааж зохицуулсан зүйл байхгүй бөгөөд энэхүү эрсдлийн төрлийг орон сууцны даатгалын бүтээгдэхүүн гаргаж буй даатгалын компаниуд дотоод дүрэм, журмаараа зохицуулдаг байна. Харин гадаадын зарим улс тэр дундаа АНУ-ын хувьд орон сууцны даатгалын эрсдлийг хуульд тусгайлан тоочиж оруулсан байх ба тэр дундаа үерийн эрсдлийн даатгалын хувьд холбооны хэмжээнд нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлдэг аж. Орон сууцны даатгалын эрсдэлд дор дурдсан зүйлүүдийг оруулдаг. Үүнд:

1. Үерийн;
2. Галын;
3. Байгалийн бусад хүчин зүйлийн;
4. Газар хөдлөлтийн;
5. Агаарын хөлөг, бусад агаарын болон сансрын тоног тнхөөрөмж, тэдгээрийн хэсэг дээрээс унах;

¹¹ Орон сууцны тухай хууль, (1999 он), 3.1.1 дэх хэсэг.

6. Хулгайн;
7. Ус алдалт гэх мэт хөрш айлаас үүдэлтэй бусад хохирол;
8. Бусад.

Эдгээрээс гадна өөрийн орон сууцтай холбоотойгоор бусдын эрүүл мэнд, амь насанд учрах хохирлын төлбөрийн даатгал бас байна. Мөн өөрийн орон сууцанд учирсан хохирлын улмаас түүнийг нөхөн сэргээх, засварлах хооронд гарах зардлыг ч даатгуулж болно. Жишээ нь, өөр байр түрээсэлсний төлбөр орно.

Галын эрсдэл гэдэгт орчны цэцэрлэгжүүлэлт, автогараж болон ой хээрийн түймэр, тэсрэлт, дэлбэрэлтээс эх үүсвэртэй, аянга цахилгаан, газар хөдлөлт, хүчтэй шуурганы шалтгаантай, цахилгаан утасны гэмтлээс үүдэлтэй, тамхи, шүдэнз зэрэг ахуйн үүдэлтэй гэх мэт гал хамаардаг бол байгалийн эрсдэлд аянга, үер, мөндөр, хүчтэй шороон болон цасан шуурга хамаарна гэх мэтээр тухайн даатгалын бүтээгдэхүүнд ямар эрсдэл хамаарах тохиолдолд хэрхэн ямар үнэлгээгээр нөхөн төлөх талаар даатгагч болоод даатгуулагчид гэрээндээ тохиролцон оруулах боломжтой байдаг байна. Орон сууцны даатгалын ерөнхий ойлголтуудын тухайд авч үзвэл ийм байна. Дараагийн бүлгээр бид орон сууцны даатгалын эрх зүйн зохицуулалтын асуудал буюу орон сууцны даатгалын зохицуулалт өндөр хөгжсөн АНУ, тэр дундаа цаг агаарын таагүй нөхцөлд өртөх магадлал өндөртэй бүсэд байршдаг Флорида, Луизана мужуудын хууль эрх зүйгээр хэрхэн зохицуулсан байдаг талаар авч үзнэ.

II. ГАДААД УЛСУУДЫН ОРОН СУУЦНЫ ДААТГАЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. АНУ дахь орон сууцны даатгал¹²

2.1.1. Орон сууцны даатгалын тухай ойлголт

Анхны орон сууц өмчлөгчдийн даатгалын гэрээ АНУ-д 1950 оны 9 дүгээр сард хийгдсэн бөгөөд үүнтэй адил гэрээ тухайн үед Их Британи болоод Америкийн Нэгдсэн Улсын зарим хэсэгт хийгдэж байжээ. 1940-өөд оны сүүлээр Америкийн Нэгдсэн Улс даатгалын хуулиа шинэчилсэн бөгөөд энэхүү шинэчлэлийн явцад орон сууц эзэмшигчийн даатгалыг хууль ёсны болгосон хэд хэдэн эрх зүйн баримт бичгийг гаргасан байна.

1950-иад оны эхээр орон сууцанд тохиолдож болох зарим нэгэн аюул

¹² National Association of Insurance Commissioners, (2010) "A Consumer's Guide to HOME INSURANCE."

ослыг даатгах даатгалын төрлүүд байсан. Орон сууц эзэмшигч нь галын аюул, хулгай, хувийн эд хөрөнгө болоод бусад эрсдлээс хамгаалсан даатгалыг тус тусад нь худалдаж авах шаардлагатай байжээ. 1950-иад онд эдгээрийг тус тусад нь биш нэг даатгалын гэрээнд буюу нэг даатгалын баталгаанд хамруулан худалдаж авах боломжтой болгосон байна. Гэсэн ч энэ нь бүх даатгалын компаниудад адил байгаагүй бөгөөд даатгалын компаниуд өөр өөрийнхөөрөө хэрэглэж байв.

Орон сууцны даатгалыг нэгдсэн стандартад оруулах асуудал чухал болохын хэрээр Даатгалын үйлчилгээний алба (ISO-Insurance Services Office) 1971 онд байгуулагдсан. Тухайн байгууллагаас гаргасан орон сууцны даатгалын үндсэн долоон стандардчлагдсан хэлбэр байдаг байна. Эдгээр нь:

• **HO1- Орон сууц эзэмшигчийн даатгалын үндсэн хэлбэр**

Орон сууц эзэмшигчийн даатгалын үндсэн хэлбэр нь доорх 11 эрсдлийн үед нөхөн төлбөр олгохоор зохицуулсан даатгалын хэлбэр юм. Үүнд, гал болоод цахилгаан цахих, шуурга болоод мөндөр, бүсдын санаатай эвдлэн сүйтгэх ажиллагаа, өөрөө явагч хэрэгслээс учирсан хохирол, хулгай, бослого, үймээн самуун болоод тайван бус байдал, шил хагарах, утаа, галт уул дэлбэрэх болоод хувь хүний хариуцлагын гэх мэт эрсдлүүд ордог байна.

• **HO2- Орон сууц эзэмшигчийн даатгалын өргөн хэлбэр**

Дээрх зохицуулалтаас арай нлүү нарийн зохицуулалттай хэлбэр бөгөөд HO1-д орсон 11 эрсдлүүд дээр нэмэгдээд нийт 17-н эрсдэл хамаардаг байна.

• **HO3- Орон сууц эзэмшигчийн даатгалын тусгай хэлбэр**

Энэхүү хэлбэр нь голчлон нэг айлын сууцанд хамааралтай байдаг. Энэхүү даатгалын хэлбэр нь "бүх эрсдлийг" хамарах боловч үер болоод газар хөдлөлтөөс үүдэх эрсдлийг хамаардаггүй байна.

• **HO4- Түрээслэгчийн даатгал**

Энэхүү даатгалаар HO2 болоод HO3-тай адил эрсдлийг даатгахаар зохицуулсан байдаг бөгөөд мөн бусдад эд хөрөнгийн болоод бие махбодид хохирол учруулсан тохиолдолд хүлээх хариуцлагын даатгал мөн хамаардаг байна.

• **HO5- Орон сууц эзэмшигчийн тэргүүн даатгал**

HO3-тай адил зохицуулалттай бөгөөд энэхүү даатгалын хэлбэрээр эрсдлийг тусгайлан заагаагүй байдаг.

• **HO6- Хамтын эзэмшлийн орон сууцны даатгал**

Энэхүү даатгалын хэлбэр нь хамтран орон сууц эзэмшигч эздэд зориулсан даатгалын хэлбэр юм.

- **НО8- Хуучин байрны даатгал**

Энэхүү даатгалын хэлбэр нь засвар хийх өртөг нь зах зээлийн ханшаас давсан эд хөрөнгөд (байранд) хийгддэг даатгал юм.

Орон сууцны даатгал хийлгэх 2 үндсэн шалтгаан байдаг. Юуны өмнө орон сууцны даатгалыг өөрийн эд хөрөнгөө хамгаалах зорилгоор хийнэ. Нөгөөтэйгүүр, мөргөйжийн зээл авахын тулд мөн хийдэг. Мөргөйжийн зээл олгодог байгууллагууд зээл олгох үндсэн нөхцөлийн нэгд тухайн үл хөдлөх хөрөнгийг даатгуулсан байх шаардлагыг заавал тавьдаг.

2.1.2 Орон сууцны даатгалын эрх зүйн объект

Орон сууцны даатгалын үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд ихэнхдээ багцалсан байдлаар бүтээгдэхүүн санал болгодог байна. Энэ төрлийн даатгалын үндсэн төрлүүд нь:

- **Орон сууцны даатгал.** Даатгуулагчийн оршин суугаа орон сууц болон түүнтэй салшгүй холбоотой байгууламжид учирсан хохирлын даатгал. Үүнд тухайн сууцанд бэхлэгдсэн сантехник, цахилгааны утас, халаагуур болон байнгын байдлаар угсрагдсан агааржуулагчийн систем зэрэг хамрана.

- **Бусад байгууламжийн даатгал.** Хашаа, саравч, сууцнаас салгаж барьсан гараж, зуслангийн байшин гэх мэт байгууламжид учирч болох хохирлын даатгал.

- **Хувийн өмч.** Тавилга, цахилгаан бараа, хувцас гэх мэт хувийн эд хөрөнгийн даатгал. Энэ төрлийн даатгалд тухайн хувийн өмч даатгуулагчийн орон сууцанд байхгүй байхдаа үрэгдсэн, гэмтсэн тохиолдол ч хамрагдана.

- **Орон сууцаа ашиглах боломжгүй болсны даатгал.** Даатгуулагчийн орон байрыг засаж байх хооронд гарах амьжиргааны зардлыг нөхөн төлөх даатгал.

- **Хувийн хариуцлагын даатгал.** Даатгуулагчийн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх даатгал.

- **Эмнэлгийн төлбөрийн даатгал.** Даатгуулагчийн орон сууцанд байхдаа бэртэж гэмтсэн эсвэл түүний гэрийн тэжээвэр амьтан бусдад хохирол учруулсан тохиолдолд гарах эрүүл мэндийг нөхөн сэргээх зардлын даатгал.

Гэхдээ дээр дурдсан даатгалууд нь зөвхөн даатгалын гэрээнд тохирсон тодорхой аюул осол учирсан тохиолдолд л нөхөн төлбөр олгогддог. Өөрөөр хэлбэл даатгуулагч гал, усны аюулын улмаас дээрх тохиолдлууд үүсвэл даатгал авна гэж гэрээ байгуулсан бол газар хөдлөлтийн улмаас

даатгуулсан эд хөрөнгө уствал нөхөн төлбөр авахгүй. Даатгагч даатгуулагч хоёр харилцан тохиролцож ямар ч аюул осол тохиолдсон нөхөн төлбөр авахаар даатгалын гэрээг байгуулж болох бол мөн зөвхөн нэг төрлийн аюул осолыг ч онцгойлон даатгаж болно.

2.1.3 Орон сууцны даатгалын хэлбэр

- **Орон сууцны галын даатгал.** Энэ хэлбэрийн даатгал зөвхөн орон сууцыг даатгана. Үүнд даатгуулагчийн эд хөрөнгө, хувийн харцуцлага, эмнэлгийн зардал хамаарагдахгүй бөгөөд цөөн тооны аюул ослын эрсдлийг нь даатгана.

- **Орон сууцны даатгалын үндсэн хэлбэр.** Орон сууцыг хүснэгт 1-д дурдсан эрсдэл учирсан тохиолдолд даатгана.

- **Өөрчлөх даатгалын хэлбэр.** Энэ төрлийн даатгалыг тухайн орон сууц хэт хуучин бөгөөд түүнийг шинээр дахин барих нь зах зээлийн үнээс өндөр тохиолдолд хийнэ. Энэ төрлийн даатгал нь даатгалын үндсэн хэлбэрийн адил эрсдлийг хамруулна.

- **Орон сууцны даатгалын өргөн хэлбэр.** Даатгуулагчийн өмчийг хүснэгт 1-д дурдсан бүх аюул ослын эрсдлээс даатгана.

- **Орон сууцны даатгалын онцгой хэлбэр.** Энэ хэлбэрийн даатгал нь "эдгээрээс бусад" гэж заан тодорхойлсноос бусад бүх аюул осолыг хамруулна. Ихэнхдээ энэ төрлийн даатгалаас үер, газар хөдлөлтийн аюулыг хасдаг байна.

- **Орон сууцны даатгалын түрээслэгчийн хэлбэр.** Энэ хэлбэрийн даатгалд бараг бүх төрлийн эрсдлийг хамруулдаг.

- **Хамтын орон сууцны хэсгийг өмчлөгчийн даатгал.** Энэ хэлбэрийн даатгал нь даатгуулагчийн хувийн өмч, орон сууцны хана, шал, тааз зэргийг ямар ч төрлийн аюул ослын эрсдлээс даатгана.

Эдгээр даатгалын хэлбэрээс гадна таунхауст амьдардаг иргэд тусгайлсан орон сууцны даатгал эсвэл нэгдсэн даатгалын алинд нь ч хамрагдаж болно. Хэрвээ даатгуулагч хөдөлгөөнт-орон сууц өмчилдөг бол тээврийн хэрэгслийн даатгалд хамрагдах боломжтой. Харин хөдөө газар эзэмшин ногоо тариа тарих эсвэл мал маллаж амьдардаг иргэд фермерийн даатгалд даатгуулах боломжтой.

Хүснэгт 1. Орон сууцны даатгалын хэлбэр ба даатгалын эрсдэл

Даатгалын эрсдэл	Даатгалын хэлбэр					
	Орон сууцны галын даатгал	Орон сууцны даатгалын үндсэн хэлбэр ба өөрчлөх даатгалын хэлбэр	Орон сууцны даатгалын өргөн хэлбэр	Орон сууцны даатгалын онцгой хэлбэр	Орон сууцны даатгалын түрээслэгчийн хэлбэр	Хамтын орон сууцны хэсгийг өмчлэгчийн даатгал
	() Орон сууц () Агуулагдсан эд зүйлс					
Гал, утаа, шуурга, цахилгаан, дэлбэрэлт, тээврийн хэрэгсэл, иргэдийн үймээн	+	+	+	+	+	+
Хулгай, эвдэн сүйтгэл		+	+	+	+	+
Цасны хүндрэл, шамарга			+	+	+	+
Хөлдөх, ус алдах, халаагуур, агааржуулагч, галаас хамгаалах систем эсвэл гэр ахуйн хэрэгсэлийн гэнэтийн эвдрэл			+	+	+	+
Үер, газар хөдлөлт, дайн эсвэл цөмийн осол болон тусгайлан хамаарахгүй гэж тодорхойлсоноос бусад аюул осол				+		

Орон сууцны даатгал ихэвчлэн үерийн эрсдлийг даатгадаггүй. Хаана амьдарч байгаагаасаа шалтгаалаад иргэд улсын үерийн эсрэг хөтөлбөрт хамрагдах эсвэл хувийн даатгалын компаниудтай тохиролцон даатгалд хамрагдах боломжтой.

2.1.4. Орон сууцны даатгалын үнэлгээ

Орон сууцны даатгалын үнэлгээг даатгагч даатгуулагч хоёр харилцан тохиролцож тогтоох ба эд хогшил, хувийн хариуцлага гэх мэт бусад хэлбэрийн даатгалын зүйлийн хувьд ихэвчлэн орон сууцны даатгалын үнийн дүнгийн хувиар тооцон гаргадаг. Жишээ нь, орон сууцны даатгалын үнэлгээг 150 000\$ гэж тогтоосон бол даатгуулагчийн эд хогшлын даатгал түүний 50 хувьтай тэнцүү буюу 75 000\$ байна гэж бодож гаргана.

Мөн даатгуулагч даатгалын зүйлийг түүнийг дахин нөхөн сэргээх үнэ эсвэл бодит мөнгөн дүнгээр даатгаж болно. Жишээ нь, даатгалын зүйлийг нөхөн сэргээх үнээр даатгавал хохирол учирсан зүйлийг хуучин хэвэнд нь буцааж оруулахад шаардагдах зардлыг даатгагч хариуцан төлнө. Харин тухайн зүйлийн мөнгөн дүнг түүний элэгдэл хорогдол, ашигласан жилийг харгалзан тогтоох тул хохирол учирсан тохиолдолд зөвхөн тэр дүнг даатгагч нөхөн төлөх тул зарим тохиолдолд энэ нь хангалтгүй байх боломжтой.

Даатгуулагч эрсдэл учирсны дараа даатгагчаас даатгалын төлбөрийг олгоогүй байхад хохирлын тодорхой хувийг өөрөөсөө эхний ээлжинд гарган төлж болох бөгөөд ийнхүү төлснийхөө дараа даатгагчаас мөнгөө суутган авах боломжтой. Өөрөө түрүүлэн төлж байгаа энэ үнийн дүн нь өндөр байх тусмаа даатгалын шимтгэл багасана харин бага бол даатгалын шимтгэл өндөр байдаг.

Дээр дурдсан даатгалын төрөл хэлбэрүүдээс гадна даатгагч даатгуулагч хоёр тохиролцсоны үндсэн дээр бусад нэмэгдэл даатгалын гэрээг байгуулж болно. Жишээ нь, орон сууцны гэрчилгээний даатгал (гэрчилгээ үрэгдсэн юмуу бусад эрхийн доголдол гарсны улмаас санхүүгийн хохирол амсах эрсдэл), орон сууцны баталгаа (орон сууцны аль нэг хэсэгт механик эвдрэл гэмтэл гарах) гэх мэт.

Орон сууц даатгуулагчийн гаргасан нэхэмжлэл, шаардлагыг нэгдсэн сүлжээнд бүртгэх ба тэрхүү мэдээллийг даатгалын компаниуд ашиглах эрхтэй байдаг.

Даатгалын гэрээ байгуулагдсанаас хойш ихэвчлэн 12 сарын дараагаас даатгуулагч болон даатгагч даатгалыг зогсоох эрхтэй байдаг. Хэрвээ даатгуулагч анхлан даатгуулж байгаа тохиолдолд даатгагч гэрээ байгуулснаас хойш ихэвчлэн 60 хоногийн дотор даатгагч гэрээг цуцлах

эрх эдэлдэг. Энэ хугацаа өнгөрсөнөөс хойш даатгагч зөвхөн төлөх ёстой төлбөрөө төлөөгүй тохиолдолд л даатгуулагчтай байгуулсан гээрээгээ цуцлах эрхтэй. Энд дурдагсан хугацааг муж улс бүр ялгамжтайгаар тогтоож өгсөн байдаг. Даатгагч гэрээг цуцалсан тохиолдолд даатгуулагчийн төлсөн төлбөрийг буцаан олгож болно.

2.2 Флорида муж

2.2.1 Флорида мужийн орон сууцны даатгалын сөрөнхий зохицуулалт

Флорида муж нь АНУ-ын мужууд дундаа өргөн уудмаараа 22-т орох бөгөөд хүн амын тоо болоод хүн амын нягтралын хэмжээгээрээ АНУ-ын 50 мужаас эхний 8-д багтдаг байна.¹³

Орон сууцны даатгалын эх сурвалж

Флорида мужийн төрийн эрх мэдэл, үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг хуваарилсан, тодорхойлсон болоод ард түмний эрх чөлөөг бататган тунхагласан үндсэн гол хууль нь Үндсэн хууль байх бөгөөд төрийн эрх мэдэл нь шүүх, гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдэлд хуваарилагддаг байна.¹⁴

Флорида мужийн хууль тогтоомж нь хууль тогтоох байгууллагаас гаргаж тус мужын захирагч баталснаар эрх зүйн хувьд хүчин төгөлдөр болдог. Хууль тогтоомж нь Флоридагийн хууль (Florida Statute) хэмээн багцлагдсан бүхий л харилцааг зохицуулсан багц хууль байдаг.¹⁵

Тус мужийн даатгалын харилцаа, тэр дундаа орон сууцны даатгалын харилцааг дээрх багц хуулийн бүрдэл хэсэг болох Даатгалын хууль, Үл хөдлөх болоод хувийн эд хөрөнгийн тухай хуулийн холбогдох хэсгүүдээр зохицуулдаг байна.¹⁶

Флоридагийн багц хуулийн Даатгалын хуулийн 624.02-д зааснаар "Даатгал" гэдэг нь нэг этгээд нөгөө этгээдийн тодорхой хэмжээний эрсдлийг нөхөн төлөхөөр тохиролцсон гэрээг хэлдэг байна.¹⁷ Энэхүү даатгалын гэрээг дараах субъектүүд хоорондоо байгуулдаг байна.

Орон сууцны даатгалын субъект

Флоридагийн багц хуулийн Даатгалын хуулийн 624.03-д зааснаар "Даатгагч" гэдэг нь даатгалын болоод аннуйт даатгалын гэрээ байгуулан нөхөн төлөгч, батлан даагч болохоор гэрээлсэн этгээдийг ойлгоно гээд

¹³ < <http://en.wikipedia.org/wiki/Florida>> (хамгийн сүүл л 2012 оны 2 сарын 20-нд зочилсон)

¹⁴ <http://en.wikipedia.org/wiki/Florida>> (энэ хуудаснаас хэрж болно)

¹⁵ <http://en.wikipedia.org/wiki/Florida>> (энэ хуудаснаас хэрж болно)

¹⁶ Florida Statutes- <<http://www.leg.state.fl.us>> (энэ хуудаснаас үзэж болно)

¹⁷ Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part I

тус хуулийн 624.031-д зааснаар “Хувийн даатгал” (Self-insurance) гэдэг нь ямарваа нэгэн хувь хүн, нөхөрлөл, холбоо, компани, хоршоо, төрийн болоод төрийн бус байгууллага, бусад зохион байгуулалтад орсон бүлэг хүмүүс өөрсдийн ажилтан болоод хамаарах бусад этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөхөөр тохиролцон гэрээ хийх үйл ажиллагаа байна гэж тус тус заасан байдгаас үзвэл даатгалын үйл ажиллагаа явуулах компани нь зөвхөн ашгийн төлөө байхаас гадна ашгийн төлөө бус гишүүдээ үйлчилдэг байгууллага байж болох зохицуулалт орсон байгаа нь харагдаж байна.¹⁸

Мөн хуульд зааснаар Даатгалын газар¹⁹ буюу Флорида мужын даатгалын газар гэж байдаг ба эндээс даатгагчдад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгодог байна.

Даатгалын хэлбэр, төрөл

Мөн хуулийн 624.6011-д зааснаар даатгал нь дараах төрөлтэй:²⁰

- (1) Амьдралын даатгал;
- (2) Эрүүл мэндийн даатгал;
- (3) Эд хөрөнгийн даатгал;
- (4) Ослын даатгал;
- (5) Батлан даалт;
- (6) Далайн даатгал;
- (7) Нэрлэсэн даатгал гэх мэт байдаг байна.

Орон сууцны даатгал нь ихэвчлэн эд хөрөнгийн болоод харнуцлагын даатгалыг хамарсан байх шаардагатай байдаг тухай бид дээр дурдсан. Тэгвэл дээрх даатгалууд нь дотроо бас хэлбэртэй байдаг ба тэдгээр хэлбэрүүдээс орон сууцны даатгалд хамаарах хэлбэрүүдийг түүвэрлэн авч үзвэл:

624.604-т “Эд хөрөнгийн даатгал” гэдэг нь газар дээр, усанд болоод агаар дээр байгаа үл хөдлөх болоод хөдлөх хувь хүний эд хөрөнгө болоод холбогдох ашиг сонирхлыг даатгах даатгалын хэлбэр байдаг. Эд хөрөнгийн даатгал нь мөн орон сууцны даатгалын гэрээнд ослын улмаас учирч болох бэртэл гэмтлийн болоод амь насны даатгалын хэлбэрийг оруулж болдог. Гэхдээ энэ нь эд хөрөнгийн даатгалын хамрагдаж буй дагалдах зүйл болохын хувьд даатгалын тухай хуульд заасан амьдралын болоод эрүүл мэндийн даатгалын адил нөхцөлийг хамаарахгүй гэж заасан

¹⁸ Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part I

¹⁹ Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part I, Chapter 624.05

²⁰ Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part V

байдаг.²¹

Мөн даатгалын хэлбэрийн ослын даатгал хэсэгт зааснаар²²:

(b) Хариуцлагын даатгал- энэ нь даатгуулагчийн ямар нэгэн хүнд учруулсан гэмтэл, бэртэл, цааншалаад үхэлд хүргэсэн үед хүлээх эрх зүйн хариуцлагыг шилжүүлэн авч эмчилгээний, эмнэлэгийн болоод мэс заслын төлбөрийг гаргаж өгөх даатгалын хэрбэр байдаг байна;

(d) Хулгай болоод орон сууцны хулгай. Энэ нь хулгай болоод дээрэм, залилан мэхлэх, жижиг хулгай, зандалчлах, улсын орлого болгох зэргээс учирч болох эрсдлийг даатгах үйл ажиллагаа байдаг;

(g) Орон сууцны халаагч машины даатгал- энэ нь бойер болоод даралтат шугам усны хоолой зэрэгтэй холбоотойгоор учирч болох эрсдлийг даатгадаг даатгалын хэлбэр байна;

(h) Гал унтраах тоног төхөөрөмжтэй холбогдох ус алдалтын даатгал- энэ нь гал унтраах тоног төхөөрөмж болох хондой, шахуурга, болоод бусад зүйлтэй холбоотойгоор учирч болох гэмтэл, эрсдлээс хамгаалсан даатгалын хэлбэр байна;

(m) Цахилгаан шат- энэ нь цахилгаан шаттай холбоотойгоор үүсч болох эрсдлээс хамгаалсан даатгалын хэлбэр байна. Ихэвчлэн хариуцлагын даатгалтай нэг бүрдэл болон хэрэглэгддэг байна. Энэ мэт орон сууцны хувьд хэрэглэгдэж болох бие даасан даатгалын хэлбэрүүдийг хуулиар зохицуулж өгсөн байдаг.

2.2.2 Флорида мужийн нийтийн орон сууцны даатгал

Даатгалын хуулийн 624.4071-д "Орон сууцны даатгалын дагнасан компани" ²³(Special purpose homeowner insurance company)-ийн зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Энд тус мужид оршин суугчдыг орон сууцны даатгалын бүтээгдэхүүнээр хангах даатгалын компанид Даатгалын газраас зөвшөөрөл олгох бөгөөд энэхүү компанийн зорилго нь найдвартай орон сууцны даатгалын бүтээгдэхүүнээр хангахад оршино гээд энэхүү хуульд зааснаар орон сууцны дагнасан даатгалын компани нь эх компанитай байх ёстой бөгөөд эх болоод дагнасан компани аль аль нь шаардлага хангасан байх ёстой байдаг байна. Эдгээр шаардлага гэдэгт:

(a) Эх компани нь хамгийн багадаа АНУ-ын нэг мужид хүлээн зөвшөөрөгдсөн даатгагч байх ёстой бөгөөд 50 сая доллар болоод түүнээс дээш хэмжээний хөрөнгө, төлбөрийн баланстай байх;

(b) Эх компани нь орон сууцны дагнасан даатгалын компанийн 51-

²¹ Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part V

²² Florida Statutes-Title XXXVII- Insurance, Part V

²³ Florida Statutes-Title XXXVII, Chapter 624

ээс дээш хувийн хувьцаа болоод хяналтын багцнийг эзэмшдэг байх;

(с) Тус мужид үйл ажиллагаа явуулах эрх аваагүй боловч шаардлагыг хангасан даатгагч нь тус мужид үйл ажиллагаа явуулах орон сууцны дагнасан даатгалын компанийн эрх авахаар өргөдөл гаргаж болно;

(д) Орон сууцны дагнасан даатгалын компани нь:

1. 10 сая доллар болоод түүнээс дээш хэмжээний төлбөрийн баланстэй байх;

2. Флоридагийн баталгаат даатгалын холбооны болоод Флоридагийн хар салхины гамшгийн сангийн гишүүн байж тэдгээрт татвар төлдөг байх;

3. Орон сууцанд хамрагдаж болох бүхий л эрсдлийг хамарсан даатгалын бүтээгдэхүүнтэй байх гэх мэт. Ерөнхийдөө орон сууцны дагнасан даатгалын компанийн даатгалын бүтээгдэхүүнүүд Даатгалын үйлчилгээний алба (ISO)-ны орон сууцны даатгалын стандарттай адил байх бөгөөд Даатгалын газарт танилцуулагдаж баталгаажсан байх ёстой байдаг байна;

(6) Орон сууцны дагнасан даатгалын компани нь Даатгалын газарт жилд 2 удаа тайлагнах ёстой бөгөөд давхар даатгалын гэрээний хуулбарыг мөн хамт хүргүүлэх ёстой байдаг байна;

(7) Орон сууцны дагнасан даатгалын компани нь үнэн зөв санхүүгийн тайлангаа мөн Даатгалын газарт жил тутам хүргүүлэх ёстой байдаг. Бүхий л орон сууцны дагнасан даатгалын компани нь 6 дугаар сарын 1-ний дотор аудитаар шалгагдсан санхүүгийн тайлангаа илгээх ёстой гэж тус хуульд заасан байдаг.

Мөн хуулийн 626.845-д даатгалын үйл ажиллагаа явуулах эрхийн гэрчилгээг шуцах нь хэсэгт энэхүү хуулийн дагуу олгогдсон бүхий л гэрчилгээ нь төрийн өмч байх бөгөөд Даатгалын газраас тухайн гэрчилгээг түдгэлзүүлсэн, хураан авсан, шинэчлэхийг татгалзсан болоод тухайн гэрчилгээний хугацаа дууссан зэрэг тохиолдолд гэрчилгээ хүчингүй байна²⁴ гэж заажээ.

Мөн хуулийн 627 дахь хэсгийн "Даатгалын үнэлгээ ба гэрээ хэсгийн" 627.7011-д "Орон сууц өмчлөгчдийн даатгалын гэрээний санал болоод нөхөн төлөх төлбөрийн үнэлгээний хэмжээ болоод хууль эрх зүйн зохицуулалт хэсэгт зааснаар орон сууц эзэмшигчийн даатгалын гэрээ байгуулагч даатгагч этгээдийн Орон сууцтай холбоотойгоор учирч болох хохирлыг барагдуурахаар тохиролцож даатгалын гэрээ байгуулж баталгааны хураамж нь тухайн харилцааг зохицуулж буй холбогдох хууль

²⁴ Florida Statutes-Title XXXVII, Chapter 626.845

болоод зохицуулалтын дагуу төлбөл зохих хэмжээнээс хэтрэхээргүй байх ёстой хэмээн зохицуулсан байдаг.

Тус хуулийн 635 дугаар зүйлд зааснаар “Үл хөдлөх хөрөнгийн эзэлийн баталгааны даатгал” гэсэн даатгалын хэлбэр байдаг. Энэхүү зүйлийн 635.011-д зааснаар:

(1) Үл хөдлөх хөрөнгийн эзэлийн баталгааны даатгал гэдэг нь эзэлдүүлэгчийг дараах эрсдлүүдээс хамгаалах гэнэтийн ослын даатгалын нэг хэлбэр болно:

(а) Өр болоод өрийн хүү бусад нэмэгдэл мөнгөн хөрөнгийг үйлдвэрийн болоод орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан өрийн бичиг, бусад нотлох баримтаар баталгаажуулан өгөхөөр тохиролцсон боловч өгөөгүйгээгээс шалтгаалан учирсан санхүүгийн хохирол,

(б) Үйлдвэрийн болоод худалдааны зориулалттай үл хөдлөх тухайн эд хөрөнгийг түрээслэх гэрээний үндсэн дээр эзэмшиж байгаа боловч түрээс болоод бусад тохиролцсон мөнгөн хөрөнгийг өгөөгүйгээс учирсан санхүүгийн хохирол гэх мэт.

Флоридагийн багц хуулийн XL дүгээр хэсгийн “Үл хөдлөх ба хувийн эд хөрөнгө” хэсгийн 720 дугаар зүйлээр “Орон сууц эзэмшигчдийн холбоо”²⁵-ын харилцааг зохицуулсан зохицуулалт байдаг.

Энэхүү зүйлд зохицуулснаар тодорхой хэсэг газарт хамаарах орон сууц болоод талбайг өмчлөгчдийн холбоо буюу тухайн тодорхой хэсэг нийтийн өмчлөл дэх газрыг өмчлөгчдийн эрх ашгийг төлөөлөх эрх олгох бичиг баримтаар баталгаажсан буюу эрх олгогдсон өмчлөгчдийн “холбоо”-нд тухайн холбооны гишүүн өмчлөгч бүр тодорхой хэмжээний мөнгийг тодорхой хугацаанд өгдөг байх ёстой байхаар зохицуулсан байдаг. Энд холбооны эрх үүрэг хийгээд хариуцах зүйлсийн талаар ерөнхий зохицуулалт тусгагдсан байна. Жишээ нь, Нийтийн бүс гэдэгт тухайн өмчлөгчдийн холбооны болоод түүний гишүүдийн эзэмшлийн болоод түрээсийн гэрээгээр түрээслэн авсан эзэмшилд байгаа тухайн хэсэг дэх бүхий л үл хөдлөх хөрөнгө ордог байна. “Community” гэдэг нь тухайн үл хөдлөх эд хөрөнгө байршинж байгаа мужид “declaration of contract” үл хөдлөх хөрөнгө байна. “declaration of contract” гэдэг нь тухайн холбоо эрх эзүйн хувьд тухайн газрыг төлөөлөх тухай бичгэн гэрээ байна гэх мэт.

Мөн хуулийн 718.111(11)т “Нийтийн орон сууцны тухай” зохицуулалт орсон байдаг.

Энд зохицуулснаар нийтийн орон сууцны бүхий л үйл ажиллагаа холбоогоор дамжин хэрэгжинэ гэж заасан байдаг. Энэхүү холбоо нь

²⁵ Florida Statutes-Title XL, Chapter 720-301

Флоридагийн багц хуулийн "Бизнесийн байгууллагын тухайн" хуулийн 607 дахь хэсэгт заасан ашгийн төлөө болоод 617 дахь хэсэгт заасан ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр байгуулагддаг байна.²⁶ Нэгж орон сууцны эзэмшигч, өмчлөгчид тухайн холбооны хувьцаа эзэмшигч болоод гишүүн байдаг байна.

Тухайн орон сууцны холбоо нь өөрийн эрхийн хүрээнд орон сууцтай холбоотой гэрээ байгуулах, нэхэмжлэл гаргах, харилцагчаар татагдах зэрэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Мөн холбоо нь тухайн байрны тохижуулалт болоод засвар, үйлчилгээ зэрэгтэй холбогдсон бүхий л үйл ажиллагааг зохицуулах, удирдах үүрэгтэй байдаг. Гэхдээ энэ нь нэгж байрны эзэмшигчийн өмчийн эзэн болохынхоо хувьд эдлэх ямар нэгэн эрхийг хязгаарлахгүй.

Энэхүү хуульд зааснаар холбоо нь өдрийн цагаар нэгж айлуудад гэрээнд тусгагдсаны дагуу нийтэд хамаарах эд хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, солих, хохирлоос сэргийлэх шалтгаанаар нэвтрэх эрхтэй байдаг байна.

Флоридагийн хуулиар нийтийн орон сууц эзэмшигчдийн холбоо нийтийн орон сууцны холбооны эд хөрөнгө болоод нэгж айлын эд хөрөнгийн хохиролд харилцаа хүлээдэг байна. Тухайн орон сууцны нэгж айл болгоны эзэмшигчид тухайн холбооны гишүүн болоод хувьцаа эзэмшигч байдаг. Холбооны албан хаагч болоод захирал орон сууцны нэгж орон сууц эзэмшигчидтэй шууд харилцаатай байна²⁷.

Флоридагийн хуулиар нийтийн орон сууц эзэмшигчдийн холбоо нийтийн орон сууцны холбооны эд хөрөнгө болоод нэгж айлын эд хөрөнгийн хохиролд харилцаа хүлээдэг байна. Тухайн орон сууцны нэгж айл болгоны эзэмшигчид холбооны гишүүн болоод хувьцаа эзэмшигч байдаг. Холбооны албан хаагч болоод захирал орон сууцны нэгж орон сууц эзэмшигчидтэй шууд харилцаатай байна²⁸.

Мөн хуулийн нийтийн орон сууцны зохицуулалтын хэсгийн 11 дүгээр хэсэгт тусгайлан даатгалын зохицуулалт орж ирсэн байдаг. Энд Флорида мужийн иргэдийн эрүүл мэнд, амар тайван, аюулгүй байдлыг хангахын тулд мөн нийтийн орон сууц болоод түүний нэгжийн эзэмшигчдийг тохиромжтой даатгалд хамааруулахад чиглэгддэг байна. Энэхүү зүйлийн зорилго нь хууль тогтоогчдийн зүгээс энэ зүйлд тусгагдсан орон сууцны холбоодыг бага болоод тогтвортой даатгалын хураамжид хамруулахад оршдог байна.

(а) Шаардлага хангасан эд хөрөнгийн даатгал гэдэг нь эд хөрөнгийн

²⁶ Florida Statutes-Title XL Chapter 718 "Real and personal property"-718.111.

²⁷ Florida Statute 718.111.

²⁸ Florida Statute 718.111.

үнэлгээ хийлгэсний үндсэн дээр хийгдсэн даатгалын гэрээ байдаг байна. Нийтийн орон сууцны үнэлгээг 36 сар тутам хийлгэж байх шаардлагатай гэж заасан байдаг.

Орон сууцны холбоо болоод холбоолын нэгдэл нь багц хуулийн даатгалын хэсэгт заагдсаны дагуу хувийн даатгалын сан²⁹ байгуулан шаардлага хангасан эд хөрөнгийн даатгалын үйл ажиллагаа явуулж болохоор зохицуулсан байдаг.

Даатгалын үнэлгээ

Даатгалын эрсдлийн хэмжээг тогтооход холбоо нь дараах хөнгөлөлтийг тооцож болдог. Үүнд:

1. Хөнгөлөлт нь тухайн эд хөрөнгө оршин байгаа бүсийн үйлдвэрийн стандарт болоод адил хэмжээний барилгын чанар өгөгдлүүдтэй нийцсэн байх ёстой байдаг байна;

2. Хөнгөлөлт нь боломжит сан, нөөцийн данс болоод даатгалыг хийх үед урьдчилан тодорхойлсон үнэлгээ зэргээс үндэслэсэн байж болно;

3. Холбооны удирдах зөвлөл нь тухайн хөнгөлөлтийн хэмжээг дээр дурдсан боломжит сан болоод урьдчилан тодорхойлсон үнэлгээ зэрэг дээр үндэслэн тогтооно.

Орон сууцны даатгалд хамрагдах эрсдэл

Нэгж орон сууц эзэмшигчдийн удирддаг холбоо нь холбоо болоод түүний хөрөнгө, нийтийн хөрөнгө, нийтийн орон сууцны хөрөнгө зэрэг энэхүү хэсэгт заасны дагуу хамгаалагдвал зохих зүйлсийг хамгаалж чадах шаардлага хангасан даатгалын бүтээгдэхүүнийг хэрэглэх ёстой байдаг.

2009 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болоод түүнээс хойш шинэчилсэн даатгалын гэрээ нь нийтийн орон сууцыг хамгаалах зорилгын хүрээнд дараах зүйлийг заавал хамрах ёстой байдаг:

1. Нийтийн орон сууцны бүхий л анх суурилуулсан болоод адил чанартайгаар анхны төлөвлөсний дагуу сольсон эд зүйлс;

2. нийтийн орон сууцны эд зүйлс болоод холбооны эд хөрөнгөд хийгдсэн зарим нэг өөрчлөлт;

3. энэхүү даатгалын хамрах зүйлст нэгж орон сууцны доторх бүхий л эд хөрөнгө тухайлбал, шал, хана, тааз, цахилгаан хэрэгсэл, ус халаагч, ус шүүгч, өрөө тасалгаа, цонх гэх мэт зөвхөн тухайн айлд хамаарах тухайн айлд л хэрэглэгддэг зүйлс хамаарахгүй бөгөөд тухайн зүйлсэд холбогдох даатгалын асуудал нь зөвхөн тухайн айлын хариуцах асуудал байна. Харин нэгж орон сууцны эзэмшигчид нь мөн тухайн нийтийн

²⁹ Florida Statutes>Title XXXVII, Chapter 624

орон сууцны өөрийн хариуцах ёстой хэсэг дээр хариуцлага хүлээх бөгөөд хэрэв холбооноос тухайн хэсгийг засч сайжруулсан тохиолдолд тухайн нэгжийн эзэмшигч тухайн зардлыг нөхөн төлөх ёстой байдаг байна.³⁰

Флоридагийн хуулийн 718.111(11)(j)-д зааснаар орон сууцны бүхий л эд хөрөнгө орон сууцны холбоонд 718.111(11)(f)-д заасны дагуу эд хөрөнгийн хохирлын эсрэг даатгагдсан байхыг шаарддаг бөгөөд эвдэрсэн бол засах, нөхөн сэргээх, солих үүргийг холбоо хүлээдэг. Гэхдээ 718.111(11)(k)-д заахдаа: “Холбоо нь саналын эрхтэй гишүүдийн олонхын саналаар (j) хэсэгт заасан засах болоод нөхөн олгох зардлыг хуваарилах нөхцөлөөс “татгалзаж” болно гээд энэхүү санал нь холбооны саналын эрхтэй гишүүдийн саналаар батлагдана.

Холбоо нь даатгалын хуулийн зарим хэсгээс “татгалзаж” болох боловч даатгалын хариуцлагаасаа татгалзах эрхгүй. Холбооны ихэнх гишүүн орон сууцны нэгж өрхийн эд хөрөнгөд учирсан хохиролыг засах, нөхөн төлөх зардлыг нийтийн зардалд оруулж тооцохоос “татгалзсан” тохиолдолд condominium declaration-ийн дагуу зохицуулна. Хэрэв тухайн хохирол нь орон сууцны нэг айлд учирсан тохиолдолд дээрх “татгалзал”-ын дагуу тухайн нэгж орон сууц эзэмшигчийн хүлээх хариуцлага болдог байна.

Нэгж орон сууц эзэмшигчдийн удирддаг холбоо нь даатгалын хураамжын хэмжээ, даатгалд хамрагдвал зохих зүйлс, хөнгөлөлт гэх мэт зүйлснийг гишүүдийн олонхын саналаар шийддэг бөгөөд үйл ажиллагаагаа ямар хэлбэрээр явуулахаа мөн адил шийддэг байна.

Холбоо нь холбооны мөнгөн санг хянаж зарцуулж буй холбооны бүхий л хүмүүсийн ил тод шударга байдлыг хангах үүрэгтэй байдаг байна. Эдгээр хүмүүс гэдэгт тухайн холбооны нэрийн өмнөөс эрх үүрэг хэрэгжүүлэх эрх бүхий хувь хүмүүс болох холбооны ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга болоод холбооны санхүүг хариуцдаг хүн байна. Тэдний үйл ажиллагаатай холбогдох зардлыг холбоо хариуцна гэсэн орон сууцны даатгалтай холбогдох үндсэн зохицуулалтууд орсон байдаг.

2.3. Луизана муж

2.3.1. Луизана мужийн орон сууцны даатгалын ерөнхий зохицуулалт. Луизана мужид орон сууцны даатгалын харилцааг мужийн Даатгалын тухай хууль³¹ болон Нийтийн орон сууцны тухай актаар³² тус тус зохицуулдаг байна. Тус мужийн Даатгалын тухай хуульд орон сууцны даатгал нь даатгалын нэг хэлбэр мөн болохыг зааж өгсөн бөгөөд тус

³⁰ Florida Statutes-Title XXXVII, Chapter 624- (g)-2

³¹ Louisiana Insurance Code (1958), <<http://www.legis.state.la.us>> (хуудаснаас явах боломжтой)

³² Louisiana Condominium Act (1979), <<http://www.legis.state.la.us>> (хуудаснаас явах боломжтой)

төрлийн даатгалыг галын бусад төрлийн эрсдлийг хамтатган хариуцлага, хохирол болон бусад төрлийн даатгалын нэг болон хэд хэдэн төрлийг хамтатган нэг багцад оруулж, даатгалын үнийг тухайн орон сууцыг нөхөн олгох үнээр тодорхойлсон, нэг эсвэл хоёр гэр бүл амьдардаг орон сууцыг даатгах даатгал гэж тодорхойлсон байна³³.

Даатгагчийн олон төрөл хэлбэрийг хуульд тусгаж өгсөн байх ба орон сууцны даатгалыг дотоодын даатгалын³⁴ компани эсвэл харилцан даатгах чиг үүрэг бүхий даатгалын байгууллага³⁵ гүйцэтгэх боломжтой.³⁶ Дотоодын даатгагч гэдэг нь тухайн даатгагч компанийн үүсгэн байгуулагч дор хаяж АНУ-ын таван иргэн, тэр дундаа олонх нь Луизана мужийн иргэн байх шаардлагыг хангасан байна. Дотоодын даатгагч нь хувьцаат компани³⁷ эсвэл хамтарсан даатгалын байгууллага³⁸ байж болно. Харилцан даатгах чиг үүрэг бүхий даатгалын байгууллага гэдэг нь тухайн байгууллагын гишүүд (хувь хүн, компани, нөхөрлөл, төр гэх мэт) бие биеийхээ эрсдлийг даатгах байдлаар нэгдэн үүсгэсэн байгууллага юм.³⁹

Луизана мужийн Даатгалын тухай хуульд даатгуулагчийн эдлэх нийтлэг эрхийг тусгайлан зааж өгсөн байна.⁴⁰ Үүнд:

- харьцуулан үнэлж өөрт тохирохыг нь сонгохуйц өрсөлдөөнт үнэлгээний орчинтой байх;
- даатгуулагчдад зориулан түтээж байгаа зар сурталчилгаа бодит, үнэн зөв мэдээллийг агуулсан байх;
- санхүүгийн хувьд тогтвортой даатгагчаар үйлчлүүлэх;
- даатгуулагч шударга бус, хууран мэхэлсэн үйлдэлд өртөхгүй шударгаар хандуулах;
- даатгуулагчийн асуултад нэн даруй хариулдаг, үнэнч даатгагчаас үйлчилгээ авах;
- даатгалын гэрээний урд талын нүүрэнд шаарлагатай мэдээллийг багтаасан байх;
- даатгалын төрийн байгууллагын тэнцвэртэй, эерэг зохицуулалтад хамрагдах;
- даатгагчийн гэрчилгээг шалгах. Даатгуулагч төлбөрөө зохих ёсоор төлөөгүйгээс бусад тохиолдолд даатгагчийн саналаар даатгалын гэрээг цуцалж байгаа эсвэл дуусгавар болж байгааг гэрээг цаашид сунгахгүй

³³ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 47-р зүйл, 15-р хэсэг.

³⁴ Domestic insurer(орч).

³⁵ Reciprocal insurer (орч).

³⁶ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 81-р зүйл, 111-р зүйл, 161-р зүйл.

³⁷ Domestic stock insurer(орч).

³⁸ Domestic mutual insurer(орч).

³⁹ Дэлгэрэнгүй тодорхойлолтын <http://www.ehow.com/about_5144294_reciprocal-insurance-company.html> (хуудаснаас авч болно. Хамгийн сүүлд 2012 оны 3 дугаар сар 13).

⁴⁰ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 41-р зүйл.

талаарх мэдээг тийнхүү дуусгавар болох хугацаанаас дор хаяж 30 хоногийн өмнө хүлээн авах;

- даатгуулагч даатгалын гэрээг цуцалж байгаа болон хугацаа сунгахгүй талаарх даатгагчийн шалтгааныг бичгийн хэлбэрээр бүрэн авах;

- даатгуулсан эрсдэл учирсан тохиолдолд шаардлагатай нотлох баримтыг гаргаж өгснөөс хойш 30 хоногийн дотор зохих төлбөрөө авах;

- даатгагчийн талаар гомдол гаргах, гаргасан гомдлоо төрний байгууллагаар заавал хянан шийдвэрлүүлэх;

- даатгалын гэрээг дахин сунгах явцад гэрээнд орж байгаа өөрчлөлтийн талаар бичгээр мэдээлэл авах;

- даатгалын гэрээг цуцлах, төлбөрт гаргуулаагүй даатгалын хураамжаа буцаан авах;

- эд хөрөнгийн хохирлын нэхэмжлэлтэй холбоотойгоор нууцад хамаарахгүй аливаа мэдээлэл, үнэлгээг даатгуулагчаас гаргуулан авах.

Мөн даатгалын асуудал эрхэлсэн төрний байгууллагаас шаардсан аливаа мэдээллийг хуурамчаар үйлдсэн, худал мэдүүлсэн бол 5 хүртэл жил хорих эсвэл 5 000 хүртэл доллараар торгуулах ялтай.⁴¹

Хуулийн дагуу даатгагч даатгуулагчтай гэрээ байгуулах үедээ тодорхой мэдээллийг заавал өгөх үүрэг хүлээдэг. Үүнд, даатгуулагчийн худалдан авч байгаа даатгалын хүрээ, тухайн даатгалын гэрээнд үерийн даатгал багтаж байгаа эсэх, хэрвээ багтаагүй бол энэ төрлийн даатгалд хамрагдах боломж, мөнгөн дүнгийн үнэлгээ болон эд зүйлийг нөхөн олгох үнэлгээний ялгаа, тодорхойлолт, даатгагчид хохирол учирсан талаар мэдээлэл өгөх арга зам, заавал баримтлах хугацаа, хугацаа хэтэрсэн тохиолдолд гарч болох үр дагавар, даатгалын төлбөрийг бууруулж болох арга зам зэрэг мэдээлэл багтана. Энд дурдсан мэдээллийг даатгуулагчид өгөхдөө орон сууцны даатгалын өмнө нүүрэнд хамгийн багадаа 14-ийн фонтоор тодруулан бичсэн байна.⁴²

Ямар нэгэн шалтгаангүйгээр (даатгагч төлбөрөө цаг хугацаанд нь төлөөгүй, хууран мэхэлсэн, худал материал бүрдүүлсэн гэх мэт шалтгаангүйгээр) даатгагч гэрээг цуцалсан эсвэл гэрээг сунгаагүй бол даатгуулагчийн хувийн мэдээлэлд энэ талаарх мэдээллийг оруулахгүй бөгөөд түүнийг дараа дараагийн даатгалын гэрээ байгуулахад даатгалын үнэ өсөх шалтгаан болгож болохгүй.⁴³ Даатгагч даатгалын гэрээг цуцлах эсвэл үргэлжлүүлэн сунгахгүй болсон бол энэ талаарх мэдээллийг даатгуулагчид бичгээр албан ёсны шуудангаар тийнхүү хугацаа дуусахаас

⁴¹ Лунзана мужийн Даатгалын тухай хуулийн 44-р зүйл.

⁴² Лунзана мужийн Даатгалын тухай хуулийн 1331-р зүйл, В хэсэг.

⁴³ Лунзана мужийн Даатгалын тухай хуулийн 1333-р зүйл.

30 хоногийн өмнө очихоор хугацаанд явуулах үүрэгтэй. Хэрвээ даатгуулагч уг мэдээг 30-аас цөөн хоног үлдсэн байхад хүлээж авсан бол гэрээ 30 хоногийн шаардлага хангагдах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрийн даатгалын нэг нэгдэл багтдаг өөр даатгагч адил төрлийн даатгалыг санал болгосон эсвэл даатгуулагч өөрөө дахин сунгахгүй талаар тодорхой мэдэгдсэн бол даатгагч мэдэгдэл өгөх үүрэг хүлээхгүй.⁴⁴

Мөн Луизанагийн Даатгалын тухай хуулийн орон сууцны даатгалын хэсэгт Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн ханын материал бүхий барилгын даатгалын асуудлыг тусгайлан зааж өгсөн байдаг. Учир нь тухайн материалын чанар маш муу бөгөөд хүний эрүүл мэндэд хортой гэсэнд дүгнэлт гарсан байна. Уг дүгнэлтийг гарахаас өмнө баригдсан барилгын хувьд даатгалын асуудлыг шийдвэрлэж өгөх шаардлагатай гэж хууль тогтоогчид үзжээ. Барилгын ханыг 2009 оны 12 дугаар сарын 31-нээс өмнө дээр дурдсан материалаар хийсэн байх нь даатгалын гэрээ цуцлах эсвэл гэрээг дахин сунгахгүй байх үндэслэл болохгүй гэж хуульд зааж өгсөн байна.⁴⁵

Даатгагч даатгуулагчийн даатгалын төрөл бүрээр төлсөн мөнгөний дүнг тусгасан тодорхойлолт буюу лавлагааг гаргаж өгөөгүй тохиолдолд ямар ч маргааны төлбөрийг эцэслэгдсэн гэж үзэхгүй. Уг лавлагаа буюу тодорхойлолтод даатгуулагчийн даатгуулсан бүх төрөл, хэлбэр болон тэдгээр тус бүрээр даатгуулагчийн авч болох төлбөрийн үнийн дүнгийн дээд хэмжээг заавал тусгасан байна.⁴⁶

Мөн Луизана мужийн даатгалын эрх зүйн харилцаанд хэд хэдэн онцлог субъект оролцдог бөгөөд энэ талаар дор товч авч үзье.

Луизана мужийн Эд хөрөнгийн болон хохирлын даатгалын комисс

Луизана мужийн Даатгалын газрын дэргэд Эд хөрөнгийн болон хохирлын даатгалын комисс ажиллах ба тус байгууллагын гол чиг үүрэг нь Луизана муж дахь эд хөрөнгийн болон хохирлын даатгалын хүртээмж болон үнийн боломжит байдлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийж, түүн дээрээ үндэслэн хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар санал, дүгнэлт гаргахад оршино. Уг комисс нь мужийн сенат, өмгөөллийн холбоо, гал, хурдны замын аюулгүй байдал хариуцсан байгууллага, даатгагчдын холбоо, хэрэглэгчийн эрх, ашгийг хамгаалах байгууллага гэх мэт олон байгууллагаас томилсон төлөөлөгчдөөс бүрддэг байна. Энэхүү комиссын доор орон сууцны даатгалын асуудал хариуцсан онцгой хороо өөрийн

⁴⁴ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 1335-р зүйл.

⁴⁵ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 1338-р зүйл.

⁴⁶ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 1895-р зүйл.

хариуцсан асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.⁴⁷

Луизана мужийн орон сууцны даатгалын эрх зүй, түүний зохицуулалтын хүрээнд нийтийн орон сууцны даатгалын асуудал онцгойлох байр эзлэнэ. Тийм ч учраас нийтийн орон сууцны даатгалын зохицуулалтыг дор тусгайлан авч үзлээ.

Луизана мужийн Иргэний эд хөрөнгийн даатгалын корпораци

Луизана мужийн хууль тогтоогчид тус мужийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад эд хөрөнгийн даатгал тэр дундаа орон сууцны даатгалын асуудал чухал нөлөөтэй гэж үзсэний үндсэн дээр нийгмийн сайн сайхны төлөө зорилготой ашгийн бүс корпорацийг байгуулан ажиллуулах нь зүйтэй гэж үзжээ. Иргэний эд хөрөнгийн даатгалын корпораци сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах боломжгүй буюу чөлөөт зах зээлээс орхигдсон хэсгийг дэмжих зорилгоор Луизана мужийн нутаг дэвсгэр дээр байрлах амьдрах болон худалдааны зориулалттай орон сууцны даатгалын үйлчилгээ үзүүлдэг даатгагч компаниудтай хамтран ажилладаг байна. Тус корпорацийн орлого нь мужийн болон холбооны орлогын албан татвараас бүрэн чөлөөлөгдсөн байдаг.⁴⁸

2.3.2. Луизана мужийн нийтийн орон сууцны даатгал

Нийтийн орон сууц нь аминийн орон сууцаас өөр зүйл болохын хувьд нийтийн орон сууцны даатгал нь орон сууцны даатгалаас ялгаатай зүйл юм. Нийтийн орон сууц эзэмшигч нь бие даасан объектыг бүхлээр нь эзэмшээгүй харин объектыг тодорхой нэг хэсгийг эзэмшидгээрээ онцлог юм. Тийм учраас тухайн нэг объектын нийтийн эзэмшлийн хэсгийн даатгалыг оршин суугчид хамтран даатгуулдаг. Нийтийн орон сууц эзэмшигчид өөрийн эзэмшлийн нийтийн орон сууцны даатгалыг л ихэвчлэн хариуцдаг бөгөөд нийт объектын даатгалыг бүхэлд нь хариуцахгүй.⁴⁹ АНУ-ын Висконсин муж улсад нийтийн орон сууцны оршин суугч байшингийн бүрэн даатгалд хамрагдах үүрэггүй боловч өөрийн оршин байгаа нийтийн орон сууцны дөрвөн ханатай холбоотойгоор даатгалд хамрагдах ёстой. Мөн үүний дээр хувийн өмчийн даатгалыг ч хийлгэж болох юм.

Нийтийн орон сууцны даатгалын тусгай хэлбэрүүд:

- **Хувийн хариуцлагын даатгал.** Нийтийн орон сууцанд гарсан ямар нэгэн алдаанаас үүдэлтэйгээр хохирол болон шүүхээс төлөхийг шаардах хохиролыг даатгана;

⁴⁷ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 5 дугаар бүлэг.

⁴⁸ Луизана мужийн Даатгалын тухай хуулийн 2291-р зүйл.

⁴⁹ < http://topics.info.com/Condo-Insurance_1282 > (хамгийн сүүлд 2012 оны 3 сарын 05 шалгасан).

• **Орон сууцаа ашиглах боломжгүй болсноос үүдэлтэй гарах нэмэгдэл зардлын даатгал.** Тухайн нийтийн орон сууцанд хүн амьдрах боломжгүй болсноос үүдэлтэйгээр өөр орон сууцанд шилжин суурьшихад гарах зардлын даатгал;

• **Хохирлын үнэлгээний даатгал.** Заримдаа сууц өмчлөгчдийн холбоо нийтийн эзэмшлийн эд хөрөнгөтэй холбоотой маргааны үнэлгээг оршин суугчдаар төлүүлэх нь бий. Хэн нэгэн нийтийн орон сууцны нийтийн эзэмшлийн хэсэгт байх хугацаандаа ямар нэгэн хохирол амссан бол шүүхээс тухайн хүнд учирсан хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэдэг. Энэ үед сууц өмчлөгчдийн холбооны даатгалаас илүү гарсан хэсгийг оршин суугчдаар төлүүлэх болдог. Ийнхүү төлүүлэхээр болсон хэсгийн оршин суугчид оногдох хэсгийг мөн даатгуулж болно;

• **Мөнгөн дүнгийн даатгал ба эд хөрөнгийн даатгал.** Даатгуулагч даатгуулах эд зүйлийн үнэлгээгээ тухайн үеийн мөнгөн дүнгээр бодож даатгуулах эсвэл аливаа эрсдэл учирсан тохиолдолд тухайн даатгалын зүйлийг бодит хэлбэрээр нь шинээр солих хоёрын аль нэгийг сонгоно.

Сууц өмчлөгчдийн холбооны даатгалын шаардлага

Зарим төрийн байгууллага нийтийн орон сууц өмчлөгчдийн холбоог орон сууцны нийтийн зориулалттай хэсгийг заавал даатгахыг үүрэг болгодог. Ийнхүү даатгуулсны төлбөрийг оршин суугчид хувааж ашиглалтын төлбөр байдлаар төлнө. Энэхүү ашиглалтын төлбөр төлж байгаа даатгалд оршин суугчдын хувийн эзэмшлийн байр хамрагдахгүй. Оршин суугчид хүсвэл нэмж даатгуулж болно. Хоёр болон түүнээс дээш тооны байранд хамрагдах ханыг ихэвчлэн нийтийн өмч гэж үзнэ. Агааржуулагч гэх мэт тухайн нэг оршин суугчид хамаарах эд зүйлийг мөн хувийн даатгалаар даатгуулна. Даатгалын нарийвчилсан асуудлыг ихэвчлэн сууц өмчлөгчдийн холбоо бүр өөр өөрөөр зохицуулдаг.

Нийтийн орон сууцны даатгалд хамрагдах гэж байгаа хүн өөрийн харьяалагдах сууц өмчлөгчдийн холбооны хамрагдсан ерөнхий даатгалын гэрээг уншиж байшингийн яг ямар хэсэг даатгалд хамрагдсаныг тогтооно. Байшингийн ерөнхий даатгал ихэвчлэн хоёр янз байдаг:

• **Зөвхөн ханыг оруулсан даатгал.** Энэ төрлийн даатгал нь хувийн өмчийн байрны ханын дотор хэсгийг хамруулах боловч хананд тогтоосон эд зүйлийг оруулахгүй.

• **Бүгд багтсан даатгал.** Энэ төрлийн даатгал нь хувийн байрын хананд тогтоосон эд зүйлийг даатгасан байна. Энэ төрлийн даатгалд сууц өмчлөгчдийн холбоо нь хамрагдсан бол оршин суугчдад нэмэлт даатгалд хамрагдах шаардлага бараг байдаггүй.

Нийтийн орон сууцны даатгал нь орон сууцны даатгалаас илүүтэйгээр түрээслэгчийн даатгалын гэрээтэй төстэй байдаг. Учир нь нийтийн орон сууцны барилга гэхээсээ илүүтэйгээр барилга доторх эд зүйлийг даатгадаг байна. Тийм ч учраас орон сууцны даатгалтай харьцуулахад илүү хямд байдаг. Луизана мужын нийтийн орон сууцны даатгал үндсэн хоёр хэлбэртэй. Юуны өмнө оршин суугч өөрийн эд хөрөнгөө мөнгөн үнийн дүнгээр даатгуулж болно. Нөгөөтэйгүүр даатгуулагч өөрийн эд хөрөнгөө хохирол учирсан тохиолдолд шинээр сольж авахаар даатгуулж болно. Хоёр дахь төрөл нь илүү үнэтэй боловч ашигтай байдаг.⁵⁰ Мөн HO-6 төрлийн даатгал буюу хариуцлагын даатгалд даатгуулж болно. Энэ нь даатгуулагчийн нийтийн орон сууцанд байх хугацаандаа хэн нэгэн гэмтэх эсвэл ус алдах болон гал гарах гэх мэт азгүй тохиолдлын улмаас бусад оршин суугчийн эд хөрөнгөд хохирол учирсан тохиолдолд даатгуулагчийн хүлээх хариуцлагыг даатгадаг.

Луизана муж Нийтийн орон сууцны тухай актыг 1979 онд анхлан баталсан бөгөөд уг хуулиар сууц өмчлөгчдийн холбоо орон сууц өмчлөгчийг байранд орох анхны өдрөөс хэтрүүлэхгүйгээр эд хөрөнгийн болон ерөнхий хариуцлагын даатгалд хамруулах үүрэгтэй.⁵¹ Хэргээ оршин суугч даатгалд хамрагдахгүй гэж шийдсэн бол энэ талаарх мэдээллийг бичгийн хэлбэрээр тухайн байрны бүх оршин суугчдад мэдээлэх үүрэгтэй. Сууц өмчлөгчдийн холбооны дүрмээр оршин суугчдыг заавал даатгалд хамрагдахыг үүрэг болгож болох бөгөөд ямар ч тохиолдолд сууц өмчлөгчдын холбоо оршин суугчдын тухайн холбоо болон сууц өмчлөгчдийг хамгаалахад шаардагдах даатгалд хамрагдаж болно.⁵²

Оршин суугч эд хөрөнгийн болон хариуцлагын гэсэн хоёр төрлийн даатгалд даатгуулна. Эд хөрөнгийн даатгал нь нийтлэг даатгагддаг эд зүйлсээс гадна тухайн сууцанд оршин суугч өөрөө хийсэн аливаа засвар, сайжруулалтыг биет байдлаар хохирол учруулж болох аливаа тохиолдлын эсрэг даатгана. Даатгалын дүн нь аливаа хасагдвал зохих зардлыг хасаж тооцоход тухайн даатгагдсан эд хөрөнгийн үнийн дүнгийн 80%-иас багаггүй байна.⁵³ Хариуцлагын даатгал нь нийтийн орон сууцыг өмчлөх, ашиглахтай холбоотойгоор үүсэж болох аливаа амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохиролыг хамарсан байх ба үнийн дүн нь эрүүл мэндийн төлбөрийн даатгалыг оролцуулахад холбооны дүрэмд тогтоосон

⁵⁰ <<http://www.condoinsurance.com/louisiana.html>> (хамгийн сүүлд 2012 оны 3 сарын 05 шалгасан)

⁵¹ Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн А хэсэг, <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106574>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

⁵² Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн В хэсэг, <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106574>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

⁵³ Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн А хэсэг, 1-р зүйл <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106574>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

үнийн дүнгээс багагүй байна. Даатгалын үнийн дүнг сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх зөвлөлөөс тогтооно.⁵⁴

Сууц өмчлөгчийн холбоо нь тухайн орон сууцны сууц өмчлөгч бүр даатгалд хамрагдсан байх шаардлагыг хангуулна. Сууц өмчлөгчдийн холбооны байгуулсан даатгалын гэрээ нь сууц өмчлөгчийг хувиараа даатгалд даатгуулах эрхийг хязгаарлаагүй байна.⁵⁵ Даатгалын гэрээ байгуулсан даатгагч нь даатгуулагч болох сууц өмчлөгчдийн холбоо болон тухайн нийтийн орон сууцанд сууц өмчлөгч хэний ч хүссэн үед даатгалын гэрээний баталгаа болох гэрчилгээ болон санамж бичгийг гаргаж өгөх үүрэгтэй. Мөн даатгалын гэрээг цуцлах бол энэ тухай сууц өмчлөгчдийн холбоо болон сууц өмчлөгч бүрт албан ёсны шуудангаар мэдэгдсэнээс хойш дор хаяж 30 хоногийн дараа гэрээг цуцалж болно.⁵⁶

III. ДҮГНЭЛТ, САНАА

3.1. Дүгнэлт

АНУ-д даатгалын олон төрөл, хэлбэр байх ба түүний нэг нь орон сууцны даатгал. Орон сууцны даатгалын асуудал нийгмийн сайн сайхан, ард түмний хэвийн амьдарлын үндэс гэж үздэг учраас энэ нь зөвхөн эдийн засгийн асуудал биш нийгмийн алиг сонирхол бүхий асуудалд тооцогддог. Тийм ч үүднээс зарим төрлийн даатгалын байгууллага орон сууцны даатгалын үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байдаг. Мөн орон сууцны даатгал нь сайн дурын даатгал хэлбэрээр орших нь нийтлэг байдаг бөгөөд моргэйжийн зээлд хамрагдах, түрээслэх гэх мэт тохиолдолд орон сууцны даатгалд зайлшгүй хамрагдахыг хуулиар үүрэг болгосон байдаг нь тухайн салбар нийгмийн сайн сайхан, аюулгүй байдалд чухлаар тавигддаг асуудлуудын нэг болохыг бататгана.

Түүнчлэн, орон сууцны даатгал хариуцсан хэлтэс, нэгж даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад заавал байх ба энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг гүйцэтгэнэ. Байгалийн гамшигт ихээхэн өртдөг Луизана гэх мэт мужид тусгайлан татварын болон бусад хөнгөлөлтийг хэрэгжүүлдэг төрийн хөрөнгө оруулалт бүхий компани орон сууцны даатгалын үйлчилгээг орлого багатай, нийгмийн эмзэг бүлэгт хүртээмжтэй байлгах асуудлыг хариуцан ажилладаг аж.

⁵⁴ Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн А хэсэг, 2-р зүйл: <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106374>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

⁵⁵ Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн Е хэсэг: <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106374>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

⁵⁶ Луизана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлийн F хэсэг: <<http://legis.la.gov/lss/lss.asp?doc=106374>> (сүүлд шалгасан 2012 оны 3 дугаар сар 9)

Монгол Улсын Даатгалын тухай хуулиар даатгалын ерөнхий төрөл, хэлбэрийг зааж өгсөн боловч орон сууцны даатгалын асуудлаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Сайн дурын даатгалын хэлбэр” гэсэн 16 тоот тогтоолын хүрээнд орон сууцны даатгалыг Гэнэтийн осолын даатгал, Хөрөнгийн даатгал, Барилгын угсралтын даатгал, Хариуцлагын даатгал гэх мэт олон хэлбэрийн хүрээнд даатгахаар байна. Ийнхүү орон сууцны даатгал гэх тусгайлсан хэлбэр байхгүй нь дээр дурдсан олон хэлбэрийн даатгалын шинж чанарыг багтаасан энэхүү даатгалын онцгой бүтээгдэхүүн иргэдийн хувьд хэт үнэтэй байх, эсвэл энэ төрлийн даатгалын мөн чанар, агуулгынх нь хувьд зүй ёсоор хүртэхгүй байх сөрөг байдлыг дагуулж болох юм.

Монгол Улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд мөн л орон сууцны даатгалын нарийвчилсан зохицуулалт дутагдаж байна. Судлагдсан хоёр мужийн ижил төрлийн хуульд даатгалыг хэрхэн байгуулах, нийтийн зориулалттай талбайн даатгал, хувийн орон сууцны даатгал, тэдгээрийг даатгах процесс, даатгаагүй тохиолдолд үүсэх үр дагавар, нөхцөл байдал гэх мэт тусгай зохицуулалтыг тусгаж өгчээ. Иймэрхүү нарийвчилсан зохицуулалтыг хуульд суулгаж өгөх шаардлага нийтийн орон сууцны барилгажилт хүчтэй өрнөж байгаа Монголын өнөөгийн байдалд нэн хэрэгтэй байна.

3.2. Санал

Сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэсэн дүгнэлтийн хүрээнд дараах саналыг уламжилж байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль, хууль тогтоомжийн актаар орон сууцны даатгалын хэлбэрийг тусгайлан зохицуулж өгөх. Ингэснээр энэ асуудлыг хариуцсан тусгайлсан институт бий болох, салбар дахь нийтийн эрх ашгийг хамгаалах, зөв зохицуулах талаар судалгаа, шинжилгээ хийгдэж, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодитой нөхцөл бүрдэх;

- Даатгалын зорилгоор орон сууц гэдэгт ямар ямар зүйлийг оруулан тооцох ойлголтыг тодорхой болгох. Учир нь Монгол Улсын хувьд гэр, дөрвөн улирал тутамд нүүдэллэн буудаг, газарт барьсан хашаа, хороо гэх мэт онцлог орон сууцны зүйлс байдаг;

- Орон сууцны даатгал, тэр дундаа нийтийн орон сууцны даатгал хэрхэн хамрагдах, ийнхүү хамрагдаагүйгээс үүсэх үр дагаварын талаар нарийвчилсан зохицуулалтыг хууль

д тусгах.

Үл хөдлөх хөрөнгө, тулгамдсан асуудал



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Иргэний эрх зүйн тэнхмийн ахлах
багш, докторант Ц.Давхарбаяр

Эд юмсын эрх зүй нь харилцаанд оролцож байгаа этгээдүүд болох өмчлөгч, эзэмшигчийг бусад этгээдийн зөвшөөрөлгүй, хууль бус үйлдлээс хамгаалах эрх зүйн механизмыг бий болгодог билээ. Үүргийн харилцаа, түүндээ гэрээний үүргийн харилцаанд оролцож байгаа нэг тал үүргээ биелүүлэхгүй байх зэргээр нөгөө талын эрх ашгийг хөндөх байдлаас эд юмсын эрх зүй хамгаалагдсан (тусгаар) байдаг. Гэхдээ өмчлөгч, эзэмшигч нь өөрт байгаа эрхийн хүрээнд бусад этгээдтэй харилцаанд орох эрхтэй, уг эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн мэдлийн эд зүйлээ шилжүүлэх, бэлэглэх, барьцаалах зэрэгт бусдын эрхийг л хөндөхгүй байх нь гол зарчим болж байдаг юм.

Эрхээ хэрэгжүүлэх, бусдын эрхийг хөндөхгүй байх гэсэн гол эрх зүйн зохицуулалт нь зарим тохиолдолд хэрэгжихдээ зарчмаас гажих, бусдын эрхийг зөрчих үед иргэний эрх зүйн хамгаалалт төдийгүй, эрүүтийн эрх зүйн хамгаалалтыг шаарддаг. Иймээс эд юмс буюу өмчлөлийн зүйл буюу объект болж байгаа зүйлсийг өмчлөх этгээдийн хоорондын хамаарлын талаар, тодруулбал, үүргийн эрх зүй, эд юмсын эрх зүйтэй хэрхэн уялдаж, эрх нь хэдийд шилжсэнийг мэдэх нь зайлшгүй шаардлага болж гардаг.

Энэ зорилгоор, нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллагаар дамжуулан тодорхой өмчлөгч этгээдийн эрхийг хамгаалах баталгаажуулах нэгэн үйл ажиллагаагаар дамжуулан эд юмсын эрх зүйг тогтвортой болгох нэгэн гол үндэслэл бүрддэг. Уг ажиллагаа бүгдэд хангалттай

үнийн дүнгээс багагүй байна. Даатгалын үнийн дүнг сууц өмчлөгчдийн холбооны гүйцэтгэх зөвлөлөөс тогтооно.³⁴

Сууц өмчлөгчийн холбоо нь тухайн орон сууцны сууц өмчлөгч бүр даатгалд хамрагдсан байх шаардлагыг хангуулна. Сууц өмчлөгчдийн холбооны байгуулсан даатгалын гэрээ нь сууц өмчлөгчийг хувиараа даатгалд даатгуулах эрхийг хязгаарлаагүй байна.³⁵ Даатгалын гэрээ байгуулсан даатгагч нь даатгуулагч болох сууц өмчлөгчдийн холбоо болон тухайн нийтийн орон сууцанд сууц өмчлөгч хэний ч хүссэн үед даатгалын гэрээний баталгаа болох гэрчилгээ болон санамж бичгийг гаргаж өгөх үүрэгтэй. Мөн даатгалын гэрээг цуцлах бол энэ тухай сууц өмчлөгчдийн холбоо болон сууц өмчлөгч бүрт албан ёсны шуудангаар мэдэгдсэнээс хойш дор хаяж 30 хоногийн дараа гэрээг цуцалж болно.³⁶

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

3.1. Дүгнэлт

АНУ-д даатгалын олон төрөл, хэлбэр байх ба түүний нэг нь орон сууцны даатгал. Орон сууцны даатгалын асуудал нийгмийн сайн сайхан, ард түмний хэвийн амьдарлын үндэс гэж үздэг учраас энэ нь зөвхөн эдийн засгийн асуудал биш нийгмийн ашиг сонирхол бүхий асуудал тооцогддог. Тийм ч үүднээс зарим төрлийн даатгалын байгууллага орон сууцны даатгалын үйлчилгээ үзүүлэхийг хориглосон байдаг. Мөн орон сууцны даатгал нь сайн дурын даатгал хэлбэрээр орших нь нийтлэг байдаг бөгөөд мөргөйжийн зөөлд хамрагдах, түрээслэх гэх мэт тохиолдолд орон сууцны даатгалд зайлшгүй хамрагдахыг хуулиар үүрэг болгосон байдаг нь тухайн салбар нийгмийн сайн сайхан, аюулгүй байдалд чухлаар тавигддаг асуудлуудын нэг болохыг бататгана.

Түүнчлэн, орон сууцны даатгал хариуцсан хэлтэс, нэгж даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад заавал байх ба энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг гүйцэтгэнэ. Байгалийн гамшигт ихээхэн өртдөг Луизана гэх мэт мужид тусгайлсан татварын болон бусад хөнгөлөлтийг хэрэгжүүлэг төрийн хөрөнгө оруулалт бүхий компани орон сууцны даатгалын үйлчилгээг орлого багатай, нийгмийн эмзэг бүлэгт хүртээмжтэй байлгах асуудлыг хариуцан ажигладаг аж.

³⁴ Луизиана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлсийн А хэсэг, 2-р зүйлс <http://legis.la.gov/doc.aspx?doc=106374> (сүүлд шалтгаан 2012 оны 3 дугаар сар 9).

³⁵ Луизиана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлсийн Б хэсэг <http://legis.la.gov/doc.aspx?doc=106374> (сүүлд шалтгаан 2012 оны 3 дугаар сар 9).

³⁶ Луизиана мужийн Нийтийн орон сууцны тухай акт (1979), 1123.112-р зүйлсийн F хэсэг <http://legis.la.gov/doc.aspx?doc=106374> (сүүлд шалтгаан 2012 оны 3 дугаар сар 9).

Монгол Улсын Даатгалын тухай хуулиар даатгалын ерөнхий төрөл, хэлбэрийг зааж өгсөн боловч орон сууцны даатгалын асуудлаар тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн “Сайн дурын даатгалын хэлбэр” гэсэн 16 тоот тогтоолын хүрээнд орон сууцны даатгалыг Гэнэтийн осолын даатгал, Хөрөнгийн даатгал, Барилгын угсралтын даатгал, Хариуцлагын даатгал гэх мэт олон хэлбэрийн хүрээнд даатгахаар байна. Ийнхүү орон сууцны даатгал гэх тусгайлсан хэлбэр байхгүй нь дээр дурдсан олон хэлбэрийн даатгалын шинж чанарыг багтаасан энэхүү даатгалын онцгой бүтээгдэхүүн иргэдийн хувьд хэт үнэтэй байх, эсвэл энэ төрлийн даатгалын мөн чанар, агуулгынх нь хувьд зүй ёсоор хүртэхгүй байх сөрөг байдлыг дагуулж болох юм.

Монгол Улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд мөн л орон сууцны даатгалын нарийвчилсан зохицуулалт дутагдаж байна. Судлагдсан хоёр мужийн ижил төрлийн хуульд даатгалыг хэрхэн байгуулах, нийтийн зориулалттай талбайн даатгал, хувийн орон сууцны даатгал, тэдгээрийг даатгах процесс, даатгаагүй тохиолдолд үүсэх үр дагавар, нөхцөл байдал гэх мэт тусгай зохицуулалтыг тусгаж өгчээ. Иймэрхүү нарийвчилсан зохицуулалтыг хуульд суулгаж өгөх шаардлага нийтийн орон сууцны барилгажилт хүчтэй өрнөж байгаа Монголын өнөөгийн байдалд нэн хэрэгтэй байна.

3.2. Санал

Сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаанд үндэслэсэн дүгнэлтийн хүрээнд дараах саналыг уламжилж байна. Үүнд:

- Даатгалын тухай хууль, хууль тогтоомжийн актаар орон сууцны даатгалын хэлбэрийг тусгайлан зохицуулж өгөх. Ингэснээр энэ асуудлыг хариуцсан тусгайлсан институт бий болох, салбар дахь нийтийн эрх ашгийг хамгаалах, зөв зохицуулах талаар судалгаа, шинжилгээ хийгдэж, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодитой нөхцөл бүрдэх;

- Даатгалын зорилгоор орон сууц гэдэгт ямар ямар зүйлийг оруулан тооцох ойлголтыг тодорхой болгох. Учир нь Монгол Улсын хувьд гэр, дөрвөн улирал тутамд нүүдэллэн буудаг, газарт барьсан хашаа, хороо гэх мэт онцлог орон сууцны зүйлс байдаг;

- Орон сууцны даатгал, тэр дундаа нийтийн орон сууцны даатгалд хэрхэн хамрагдах, ийнхүү хамрагдаагүйгээс үүсэх үр дагаварын талаар нарийвчилсан зохицуулалтыг хууль

д тусгах.

Үл хөдлөх хөрөнгө, тулгамдсан асуудал



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Иргэний эрх зүйн тэнхмийн ахлах
багш, докторант Ц.Давхарбаяр

Эд юмсын эрх зүй нь харилцаанд оролдож байгаа этгээдүүд болох өмчлөгч, эзэмшигчийг бусад этгээдийн зөвшөөрөлгүй, хууль бус үйлдлээс хамгаалах эрх зүйн механизмыг бий болгодог билээ. Үүргийн харилцаа, түүндээ гэрээний үүргийн харилцаанд оролдож байгаа нэг тал үүргээ биелүүлэхгүй байх зэргээр нөгөө талын эрх ашгийг хөндөх байдлаас эд юмсын эрх зүй хамгаалагдсан (тусгаар) байдаг. Гэхдээ өмчлөгч, эзэмшигч нь өөрт байгаа эрхийн хүрээнд бусад этгээдтэй харилцаанд орох эрхтэй, уг эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн мэдлийн эд зүйлээ шилжүүлэх, бэлэглэх, барьцаалах зэрэгт бусдын эрхийг л хөндөхгүй байх нь гол зарчим болж байдаг юм.

Эрхээ хэрэгжүүлэх, бусдын эрхийг хөндөхгүй байх гэсэн гол эрх зүйн зохицуулалт нь зарим тохиолдолд хэрэгжихдээ зарчмаас гажих, бусдын эрхийг зөрчих үед иргэний эрх зүйн хамгаалалт төдийгүй, эрүүгийн эрх зүйн хамгаалалтыг шаарддаг. Иймээс эд юмс буюу өмчлөлийн зүйл буюу объект болж байгаа зүйлсийг өмчлөх этгээдийн хоорондын хамаарлын талаар, тодруулбал, үүргийн эрх зүй, эд юмсын эрх зүйтэй хэрхэн уялдаж, эрх нь хэдийг шилжсэнийг мэдэх нь зайлшгүй шаардлага болж гардаг.

Энэ зорилгоор, нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллагаар дамжуулан тодорхой өмчлөгч этгээдийн эрхийг хамгаалах баталгаажуулах нэгэн үйл ажиллагаагаар дамжуулан эд юмсын эрх зүйг тогтвортой болгох нэгэн гол үндэслэл бүрддэг. Уг ажиллагаа бүгдэд хангалттай

илэрхий, тодорхой байхаас хамаарч эд юмсын эрх хамгаалагдана. Гэхдээ эд юмсын эрх зүйд хамаарагдах бүхий л зүйлс ингэж хамгаалагдах боломжгүй байдаг нь *Нэгдүгээрт*: нийгэмд үзүүлэх байр сууриар нь авч үзвэл ач холбогдол багатай, зөвхөн тухайн этгээдийн хэрэгцээ, шаардлагыг хангах эд хөрөнгө, эд юмс цөөнгүй байдаг, *Хоёрдугаарт*: урьдчилан эрхийн байдлын талаар мэдээлэл авахыг шаарддаг, нийгэмд ч мэдээлэл нь шаардлагатай байдаг хөрөнгийг л хамруулах нь ач холбогдолтой байдаг байна.

Энэхүү нийтэд ил тод байх, мэдээлэл заавал шаардах хөрөнгө бол үл хөдлөх хөрөнгө байх бөгөөд үл хөдлөх хөрөнгийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий байдалтай холбоотой юм. Хөдлөх хөрөнгөтэй адилаар хялбар байдлаар шилжилт хөдөлгөөнийг хийх боломжгүй, зайлшгүй тусгай шаардлага шаардаж, тодруулбал, нэг гараас нөгөө гарт шилжих байдлаар шилжүүлэг хийгддэгээрээ, нөгөө талаар, үл хөдлөх хөрөнгө нь байрлал, байршилтай холбоотой шаардлагыг зайлшгүй шаарддагаараа хөдлөх хөрөнгийн зохицуулалтаас ялгагдах нэг гол үндэслэл болно.

Эртний Германы эрх зүйгээс улбаатай, үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэхдээ шүүх, эсвэл сүмд баталгаажуулах байдлаар хийгддэг байсан ажиллагаа¹ дундад зууны үеэс, хот суурин газарт үл хөдлөх хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг (*Auflassung*) тэмдэглэх тусгай номд бүртгэж байсан нь XVIII зуунаас илүүтэй боловсронгуй болох, шаардагдах хуулиудыг батлах зэргээр өнөөгийн үед нийтийн захиргааны байгууллагаар дамжин бүртгэгдэх, бүртгэлийн тусгай шаардлага тавих зэргээр өөрчлөгдөн хөгжиж иржээ. Англид үл хөдлөх хөрөнгө гэх нэр томьёо (*Real Estate*) олон зууны туршид хэрэглэгдэж байсан боловч үл хөдлөх хөрөнгийн бүртгэл (*registration of deeds*) 1925 оноос бий болсон байдаг.

Монгол Улс нь 1963 онд батлагдсан Иргэний хуульд 1990 онд оруулсан өөрчлөлтөөр, БНМАУ-д хувийн болон нийтийн өмч байж болохыг хүлээн зөвшөөрч, улмаар 62 дугаар зүйлд "өмчлөлийн зүйл болох эд хөрөнгө нь үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө гэж ялгагдах" талаар зааж оруулсан нь нүүдлийн аж ахуйг уламжлал болгон эрхэлж байсан монголчуудын эрх зүйн зохицуулалтанд орж ирсэн шинэлэг зохицуулалт, хандлагын үндэс болох заалт байсан юм. Мөн тухайн хуульд "үл хөдлөх хөрөнгөд газар, барилга байгууламж хамаарагдах ба үл хөдлөх хөрөнгийг төрийн эрх бүхий байгууллага бүртгэнэ" гэж заасан боловч энэ заалт өөрийн утгаараа Монгол Улс зах зээлийн харилцаанд шилжин орж, өмч хувьчлал явагдан, иргэд хувийн өмчтэй болсноор үл хөдлөх хөрөнгийн

¹ Шершеневич Г.Ф. Учебник русского гражданского права - М.: -СПАРК-, 1995. С.144

ойлголт боловсронгуй болох, бүртгэлийн үйл ажиллагааг хуульчлах гэх зэргээр шат дараалсан, бие биетэйгээ холбоотой ойлголтуудыг эрх зүйгээр зохицуулсан байдаг.

Гэхдээ үл хөдлөх хөрөнгө гэж үзэж буй газар, түүнд суурилсан барилга байгууламжийн асуудал салангид байснаар нийгмийн харилцаанд зарим үед снрөг нөхцөл байдал бий болж ирсэн байна.

1. Үл хөдлөх хөрөнгийн ойлголт 1963 оны Иргэний хуулиас улбаалан 2002 оны Иргэний хуульд илүү тодорхой тусгагдсан ба *Нэгдүгээрт*: үл хөдлөх хөрөнгө гэдэгт ямар ойлголт хамаарахыг, *Хоёрдугаарт*: үл хөдлөх хөрөнгө нь хоорондоо ямар хамааралтай байх, үүнээс үүдэн ямар эрхүүд үүсч болохыг заасан.

2. Үл хөдлөх хөрөнгийн нэг магадгүй суурь нь болох газрын тухай асуудал нь 2002 онд батлагдсан "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль" иар иргэд газар өмчлөх эрхтэй болсон бөгөөд уг хууль нь 2003 оноос эхлэн хэрэгжих болсон нь иргэд газар өмчлөх улмаар өмчлөлийн газартаа үл хөдлөх хөрөнгө барих, бүртгүүлэх зэргээр газар үл хөдлөх хөрөнгө болж хөдөлгөөнд орсон байдаг. Гэхдээ газрын өмчлөлийн зохицуулалт хожим бий болсон нь газар, барилга байгууламж нь тусдаа байх, бүртгэлд ч тус тусдаа бүртгэгдэх, үүнээс барилга байгууламж болох үл хөдлөх хөрөнгө, газрын эзэмшигч, өмчлөгч нарын хоорондын маргаан шүүхээр шийдвэрлэгдэх байдал цөөнгүй гардаг болжээ.

Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлаас анхаарал хандуулах зайлшгүй үзэгдлүүд гарч байгааг тоймлон авч үзвэл:

• Үл хөдлөх хөрөнгө гэдэг ойлголтыг нарийвчлах шаардлага зүй ёсоор гарч байна. Иргэний хуулийн 84.3-т "Газар, түүнээс салмагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс үл хөдлөх эд хөрөнгөд хамаарна" гэж заасан заалтаар бүхий л үл хөдлөх хөрөнгө гэх ойлголтыг авч үзэх боломжгүй болох нь нийгмийн харилцааг зохицуулан гарч байгаа олон нарийвчлалсан зохицуулалтай хуулийн зохицуулалтаас харагддаг юм. Барилгын тухай хуулийн 3.1.4-т "барилга байгууламж" гэж барилгын норм, дүрмийн дагуу боловсруулж магадлал хийгдсэн зураг төслөөр тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн барьсан орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, эрчим хүч, холбоо, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээг хэлнэ" гэсэн заалтын агуулгаас харахад дээрх ойлголтыг үл хөдлөх хөрөнгө гэж үзэх, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгэх асуудлыг зохицуулах шаардлага гарч ирж байна. Түүнчлэн Газрын тосны бүтээгдхүүний тухай хуулийн

4.1.3-т "агуулах" гэж газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, савлах, бөөний худалдаа эрхлэхэд зориулсан байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн цогцолборыг хэлэх бөгөөд уг агуулахыг газрын тосны үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компани бий болгох, түүнийг нь улсын комисс хүлээн авах зэрэг үйл ажиллагаа байхыг хуульд заасан атлаа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд хэрхэн бүртгэх нь тодорхойгүй байна.

• Үл хөдлөх хөрөнгийн маргаанд дуусаагүй барилгын асуудал зүй ёсоор анхаарал татаж байна. Дуусаагүй барилгыг барьцаанд тавих, дуусаагүй барилгын өмчлөх эрхийн гэрчилгээг гаргуулах нь Эд хөрөнгийн өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд тусгагдсан боловч тухайн гэрчилгээг олгохдоо дуусаагүй барилгыг тухайн үед нь худалдаж авч байгаа иргэдийн эрхийг хэрхэн хамгаалахыг орхигдуулснаас худалдаж авч, төлбөрөө төлснөөр өмчлөх эрх нь үүсдэг иргэд, хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ авч чадахгүйд хүрэх тохиолдол байна. Иймээс дуусаагүй барилгын хувьд, тухайн барилгыг барьж байгаа этгээдэд гэрчилгээ олгохдоо барилгын хувь хэмжээгээр л (үүнийг бодит байдлаар нь тодорхой болгож бүртгэх юм уу, эсвэл мөнгөн дүнгээр үнэлэн бүртгэлд тусгах) гэрчилгээ олгох, улмаар тухайн хэмжээгээрээ барьцаалах, иргэд бусад хувь хэсэгт нь өмчлөх зэргээр бүртгэлийн ажиллагааг төгөлдөржүүлэх шаардлага гарч байна.

• Үл хөдлөх хөрөнгөтэй зэрэгцэн гарч ирсэн бидний анхаарлын төвд байдаг нэгэн зохицуулалт бол ипотек буюу үл хөдлөх хөрөнгийн барьцааны асуудал байдаг. Барьцаа, үл хөдлөх хөрөнгийн барьцаа нь бусдын өмч дээрх эрх байдаг учраас үндсэн өмчлөгчийн эрхийг хэзээ ч хязгаардаж болохгүй юм. Гэтэл одоо хийгдэж байгаа барьцааны гэрээ, үүндээ банкны барьцааны гэрээ нь тухайн барьцааны гэрээ байгуулагдсанаар л үндсэндээ банк барьцааны эд хөрөнгийн өмчлөгч болчихсон мэт ойлголт үүсэх, үүнийг барьцааны гэрээнд тусгах зүйл манай практикт байна. Тухайлбал, барьцааны эрх нь бусдын хөрөнгө дээрх үүссэн эрх байдаг учраас барьцаалагч нь тухайн барьцааны хөрөнгийг өөрийн мэдэлд шууд шилжүүлэн авах боломжгүй, харин шүүхийн болон шүүхийн бус журмаар зайлшгүй худалдан борлуулж байж л сая барьцааны эрх дуусгавар болно. Гэтэл банк, түүнтэй ижил төрлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд зээлийн гэрээ, барьцааны гэрээнд "үл маргах журмаар барьцааны зүйлийг банкинд шилжүүлнэ" гэсэн заалтыг оруулан, улмаар гэрээний үүрэг биелэгдээгүй бол барьцаа хөрөнгийг шууд өөрсдөө дүр мэдэн захиран зарцуулдаг буруу зуршил, практик тогтож байгааг

анхаарууштай юм.

Түүнчлэн зээлийн гэрээний биелүүлэх үүрэг доголдох, тухайлбал: хугацаа хэтрүүлэх, тогтсон хугацаанд төлөгдөх мөнгөн төлбөрийг бүрэн төлөхгүй байх, огт төлөгдөхгүй байх зэрэгт банк нь барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээг өөрийн нэр дээр шилжүүлэх гэрээг барьцаалуулагчтай хийх, улмаар улсын бүртгэлийн байгууллагад хандан шилжилт хөдөлгөөн хийдэг практик байна. Явцын дунд зээлийн үүргийг зохих тал гүйцэтгэсэн бол дахин үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагч талдаа эргээд шилжих, эсвэл төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй бол шууд банкны өмчлөлд үл хөдлөх хөрөнгө үлдэх зэргээр барьцааны болон үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн зохицуулалтад үл нийцэх зүй тогтол бий болж байгаа нь гэрээний эрх зүй, иргэн болон үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн олон ойлголт, харилцаа, эрх зүйн зохицуулалтын мөн чанарыг алдагдуулсан үйлдэл болоод байна.

• Эд хөрөнгийг өмчлөх олон хэлбэр байдагтай уялдан, үл хөдлөх хөрөнгийг дундаа хамтран, дундаа хэсгээр өмчлөх зохицуулалт байдаг. Гэтэл үл хөдлөх хөрөнгийг дундаа хэсгээр өмчлөгч нар нь өөр өөрт ногдох хэсгээ тодорхойлж өгөөгүй, үүнийг тодорхойлж өгдгийг мэддэггүй байх зэрэгтэй уялдан, дундаа хамтран өмчилж байгаа этгээдтэй нэгэн адилаар бүртгэлд бүртгүүлдэг нь эцэст нь өмчлөлийн маргаан үүсгэх нэг үндэс болж байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

• Үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийн явцад шууд эзэмшил болон эзэмшлийн асуудал хөндөгддөг. Шууд эзэмшил нь эрх бүхий этгээд өөрийн хөрөнгөө тодорхой эрхийн хамтаар шилжүүлэх-түрээслэх, хөлслүүлэх, үнэ төлбөргүй ашиглуулах зэргээр хэрэгжиж байгаа бол одоо хэр хувьчлагдаагүй орон сууцны байранд амьдарч байгаа боловч уг байрны эзэмших эрхийн гэрчилгээ нь байхгүй, байгаа боловч эзэмшиж байгаа этгээдийн нэрээр бус байгаа зэрэг нь эзэмшлийн асуудлыг хөндөж байдаг.

Өмчлөгч мэтээр, эд юмсыг хууль ёсоор эзэмшиж байгаа этгээд нь өөрийн мэдлийн хөрөнгөнд түүнээс илүү "хүчтэй" давамгай эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөггүй болохыг К.Савиньг² бичсэн нь "хөрөнгийг мэдэлдээ авах нь түүнд зөвхөн нөлөөлөх боломж бүрдүүлэх төдий бус түүнд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг хязгаарлах" буюу хяналт тавих эрхийг ч бий болгохыг дурдсан байдаг.

Иймээс Иргэний хуулийн 104, 105 дутаар зүйлд эд хөрөнгийг хууль ёсоор эзэмшиж, ашиглаж байгаа этгээдэд өмчлөх эрх хэрхэн үүсэхийг зохицуулсан нь нэг талаар хууль ёсны эзэмшлийн үр дагавар болж

² Savigny K. Das Recht des Besizer, Gießen 1827, s 55, 2655 дам нийлэв.

байгаа тул өмчлөх эрх ба үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгээр эрх нь баталгаажиж байгаа этгээд болон эзэмшил ба тус үл хөдлөх хөрөнгийг тодорхой хугацаагаар эзэмшиж, ашиглаж байгаа этгээдийн хооронд үүсч байгаа маргаанд ч хамаарагдах, нөгөө талаар, хууль ёсны эзэмшигчийн эрхийг хамгаалах зохицуулалт болж байгаа нь Иргэний хуульд эд юмсын эрх зүй, түүнд эзэмшлийн асуудал зохицуулагдсаны ач холбогдрол гэж үзэх боломжтой юм.

Энэ бүтдээс дүгнэхэд үл хөдлөх хөрөнгө нь улс орны эдийн засгийн хөгжил, бэхжилтэнд нөлөөлөх хөшүүрэг болдгийн хувьд эрх зүйн зохицуулалтыг шинэчлэх, онолд суурилсан практик бий болгох шаардлага тавигдаж байгааг анхаарах, өөрчлөлт хийх нь зүй ёсны асуудал болж байна.

----- оОр -----

Форексийн бизнес түүний эрх зүйн зохицуулалт, шинэ үеийн тулгамдсан асуудал



ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн
багш магистр (LL.M) Э.Мөнхжаргал

УДИРТГАЛ

Орчин үеийн валют арилжааны систем 1973 онд Бретон Вудсын систем дуусгавар болсноос үүссэн. Дэлхийн II дайны төгсгөл буюу 1944 онд холбоотон улсууд тухайн үеийн дэлхийн хамгийн сайн хөрвөх чадвартай валют болох АНУ-н долларын ханшийг алтанд уяж нэг унц алт 35 америк долларын ханштай байхаар тооцож, бусад улс өөрийн улсын үндэсний валютын ханшийг америк доллартай тохирсон ханшаар уяж өгөхөөр гэрээ байгуулж Бретон Вудсийн системийг үүсгэсэн. Энэхүү гэрээнд ихэнх улс нэгдэж орсон бөгөөд ингэснээр алт, америк доллар болон бусад улсын валют хоорондын ханшны хэлбэлзэл багассан. 1973 онд АНУ-н Засгийн газар алтны америк долларын нэрлэсэн ханшийг чөлөөлж өгснөөр тухайн валютын ханш тухайн улсын улс төр, эдийн засгийн нөхцөл байдал валютын эрэлт, нийлүүлэлт, дотоодын мөнгөний бодлогоос шалтгаалан өөрчлөгдөх болсон. Ингэснээр банк, хөрөнгө оруулалтын сан, компани, инстити болон жижиг хөрөнгө оруулагчид валютын ханшны зөрөөнөөс ашиг олох зорилгоор форексийн арилжаанд оролцох болсон. Интернетийн эрин үеийн сүүлийн хэдэн жилүүдэд хувь хүмүүсийн хувьд форексийн зах зээлд оролцох боломж өргөжиж байна. Одоо үед хүн бүр ямар оронд амьдарч байгаагаас үл хамааран энэ зах зээлийн оролцогч болж байна. Нийгмийн энэхүү харилцаа манай оронд нэвтэрч, өргөжихийн зэрэгцээгээр сөрөг талууд гарсаар байна. Форексийн бизнесээр дамжуулан замлан хийх, энэхүү бизнест оруулсан ихээхэн хэмжээний хөрөнгөө алдсан, түүнээс эрүүгийн хэрэг үүсгэсэн гэх мэт.

Гэтэл өнөөг хүртэл энэхүү харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Эрх зүйн зохицуулалтгүй байх буюу хуулийн цоорхой байх нь цаашдаа ч олон сөрөг үр дагаврыг авчрах эрсдэлтэй байна.¹ Дэлхий дээр хувийн хөрөнгө оруулагчдын дунд форексийн зах зээл хөгжих нь дараах шалтгаанаас үүдэлтэй байдаг.

1. Өндөр ликвид чанар-Форексийн зах зээл дээр эргэлтэд байгаа активуудаас дийлэнх нь хамгийн өндөр ликвид чанартай мөнгө байдаг. Энэхүү өндөр ликвид чанар нь ямар ч хөрөнгө оруулагчдын хувьд дурын хэмжээний позицийг чөлөөтэй нээх, хаах боломжоор хангагддаг учир тэдний сонирхлыг ихээхэн татдаг.

2. Уян хатан түргэн шуурхай байдал-Форексийн зах зээл дээр 24 цаг ажилладаг тул түүнд оролцогчид хүлээх шаардлагагүй байдаг.

3. Бага өртөгтэй байдал-форексийн зах зээл нь зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийн үнийн зөрүүнээс гадна ямар ч хураамж зарлага байдаггүй.

4. Нэг төрлийн ханш тогтоох байдал-зах зээл дээрх өндөр ликвид чанараас болж хязгаарлалтгүй лотыг нэг ижил зах зээлийн үнээр хийж болно. Энэ нь хязгаартай тооны гэрээ тодорхой үнээр нэгэн цагт зарагддаг фьючерс болон бусад бирж дээр байдаг тогтвортой бус байдлаас сэргийлэх боломжийг олгодог.

5. Маржийн хийсвэр хэмжээ-Форексийн зах зээл дээр эзэлийн мөр "маржийн" хэмжээ харилцагч болон банк эсвэл брокерийн компанийн хооронд байгуулсан гэрээгээр тодорхойлогдож байдаг. Брокерийн компани харилцагчийг 1:30, 1:50 эсвэл 1:100-гаас бүрдсэн зах зээл рүү гарах гарцаар хангадаг. Жишээ нь, Оросын Холбооны Улсад форексийн зах зээл дээр үйлчилгээг 1:100 мөр хэмжээний хүрээнд тогтоосон.² Өөрөөр хэлбэл харилцагч 1000 долларын барьцаа тавиад 100000 долларын хэлцэл хийж болно гэсэн үг юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Форексийн бизнест оролцогч эхлээд өөрийн эсвэл гадаадын брокерийн компанитай холбогдож, брокерт данс нээлгэх шаардлагатай. АНУ-д энэ дансаар хүүг төлдөг бол хөрөнгө оруулалт нь Хөрөнгө оруулагчдыг хамгаалах тухай хуулиар хамгаалагдсан байдаг. Үүний дараа брокерийн компанитай гэрээ байгуулна. Хэрэв тухайн орны иргэн АНУ-н брокерийн гэрээ байгуулах бол гадаадын статусын тухай В8 сертификат бөглөх хэрэгтэй. Брокер хөрөнгө оруулагчийн орлогоос татвар авахгүй. Улмаар

¹ Санхүүгийн зохицуулах хороо, "2008 оны үйл ажиллагааны тайлан мэдээлэл", Ув., 2009 он.

² Азийн хөгжлийн банк, "Маржагийн хөрөнгө оруулагчдыг Монголд бий болгох эрх зүйн тулгамдсан асуудлууд" нэвтэлийн эмхтгэл, Ув., 2011 он.

харилцагчид хувийн номертой пароль илгээдэг. Үүний дараа брокер хөрөнгө оруулагчийг хэлцэл хийх шаардлагатай мэдээллээр хангана. Харилцагч зах зээлийн тухай мэдээллийг брокероор болон мэргэжлийн системээр дамжуулан авдаг. Валют худалдах, худалдан авах үйл ажиллагааг брокерт биржийн тушаал өгөх замаар хийдэг. Бүх арилжаа тусгай хуудсанд тэмдэглэн хөтлөгддөг. Харин брокерийн үйл ажиллагааг хянахын тулд дансны урсгал байдлыг харуулсан хуудас урьдчилан хөтөлдөг.

Ханшны өндөр өөрчлөлттэй валютыг худалдан авах замаар их хэмжээний зээлийн мөр ашиглах явдал нь энэ зах зээлийн өндөр орлоготой болгохын хамт өндөр эрсдэлтэй болгодог. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг фунт стерлинг, доллараар худалдах, худалдан авах ажилбарыг жишээ болгон авч үзье. Эхлээд брокерийн компанитай холбогдох бөгөөд тус брокерийн компани нь форексийн зах зээлтэй холбож тодорхой санхүүгийн мөрөөр хангана, хөрөнгө оруулагч 2000 долларын барьцаа тавьсан гэж үзье. Тэгвэл компани түүнд 1:100 мөртэй санхүүгийн хөшүүрэг (рычаг) олгоно. Энэ нь хөрөнгө оруулагч 2000 долларын барьцаа хөрөнгөдөө суурилож 200000 долларын арилжаанд оролцох эрхтэй болно. Түүнээс гадна брокерийн компани хөрөнгө оруулагчид валютын зах зээлийн талаарх бүх мэдээллийг өгнө. Жишээ нь, фунт стерлингийн доллартай харьцах ханшийн мэдээллийг шинжлээд фунтын ханш цаашид өснө гэж үзээд 200000 доллараар 1 фунт стерлинг 1.53 долларын ханшаар 130718 фунт стерлинг худалдан авсан гэж үзье. Харин 3 сарын дараа фунтын ханш өсч 1.63 доллар болсон бөгөөд энэ ханшаар дансан дахь фунт стерлингээ зарсан гэж үзвэл 13071 долларын ашиг олно. Хэдийгээр форексийн арилжаанаас хөрөнгө оруулагч их хэмжээний ашиг олох боломжтой ч алдагдалтай арилжаа байнга тохиолдож байдаг. Энэ нь эрх зүйн хувьд нарийн зохицуулалт хийх шаардлагыг бий болгож байдаг.

Форексийн арилжаанд оролцогч нь валютын зах зээлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, ханшийн өөрчлөлтийг оновчтой таамаглаж, тэдгээрт суурилсан валют худалдах, худалдан авах хүсэл зоригоо шуурхай хэрэгжүүлэх нь форексийн зах зээлд ашиг олох түлхүүр зарчим юм. Форексийн харилцаанд оролцоход валютын зах зээл дэх ханшны хэлбэлзлийн давтамжийг урт хугацааны турш ажигласан арилжаанд оролцогчийн туршлагаас гадна тухайн өөрчлөлтийн уг мөн чанарыг танин мэдэх, түүнд анализ хийх зах зээлийн ханшийн хэлбэлзэл, тухайн хэлбэлзлийн хэмжээ, ханш хэлбэлзэх магадлал зэргийг валютын ханшны суурь техник анализ хийх аргаар тооцоолох зэрэг санхүүгийн өндөр мэдлэг шаардагддаг.

ФОРЕКСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААТ

Форекс нь санхүүгийн шинэ үйлчилгээ учир түүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт хэрэгтэй. Өнөөдөр Монгол Улсад эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд Санхүүгийн зохицуулах хороо, Тагнуулын ерөнхий газраас их хэмжээний мөнгөөр энэхүү бизнесийг хийж байгаа хүмүүсийг хянадаг талаар Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан залуу судлаачдын бага хуралд нэгэн илтгэгч өгүүлсэн байна. Пост социалист зарим оронд ч мөн эрх зүйн зохицуулалт байхгүйгээс 2007-2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеэр олон бизнес дампуурч эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Оросын Холбооны Улсын хувьд форексийн арилжааны үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй. Гэхдээ тус улсын форексийн зах зээлийн 90 хувийг удирддаг форексийн 7 компани нийлж АНУ-н үндэсний форексийн холбоо (NFA) 2 төстэй (KROUFR)- гэх холбоог байгуулсан. Энэхүү холбоогоор өөрсдийн үйл ажиллагааг зохицуулан, зохион байгуулж байна. Монгол Улсад 2008 оны Дэлхийн эдийн засгийн хямралын үеийн валютын ханшны савлагаа уналтын үеэр форексийн бизнес эрхлэгч хэд хэдэн этгээд дампуурсан. Үүнтэй холбоотойгоор эрүүгийн хэрэг үүсгэсэн байдаг. Гэхдээ эдгээр хэргийг хэд хэдэн өөр байдлаар зүйлчилсэн байгаа бөгөөд зарим нь шийдвэрлэгдсэн байна. Үүнээс үзэхэд эрх зүйн зохицуулалтгүй байгаа ч бодит амьдрал дээр эрүүгийн болоод иргэний маргаанууд шийдвэрлэгдсээр байна. Гэхдээ шүүхийн практик нэг мөр болоогүй байна. Жишээ нь: 2008 оны Монгол Улсын иргэн М форексийн бизнес эрхэлж байсан ба Дэлхийн эдийн засгийн хямралын үеэр ихээхэн хэмжээний алдагдалд оржээ. Үүний улмаас 1.3 орчим тэрбум төгрөгийн алдагдалд орсон байна. Улмаар эрүүгийн хэрэг үүсгэхэд прокурор түүнд Эрүүгийн хуулийн 148-р зүйлд заасан ял төлөвлөсөн байна. Гэтэл энэ хэрэг өнөөг хүртэл бүрэн шийдвэрлэгдээгүй зүйлчлэлийн хувьд маргаантай хэвээр байсаар байна. Аливаа ниймийн харилцаа бий болж түүнээс үүдэн гэмт хэрэг хүртэл гарч байгаа нь яах аргагүй анхаарал татах сэдэв болж байна.

ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААТ

Форексийн арилжаа АНУ-д олон жил хөгжиж байгаа бөгөөд түүнийгээ дагаад эрх зүйн зохицуулалт нь ч боловсронгуй болж байна. АНУ-д форексын үйл ажиллагааг Dodd-Frank Wall Street Reform and Consumer Protection Act-р зохицуулдаг. Тус хуульд заасны дагуу форексын зах зээл дээр Бараа бүтээгдэхүүний фьючерс худалдааны хороо (Commodity Futures Trading Commission)-д бүртгүүлсэн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулах

эрхтэй. Тус хороо нь АНУ-н конгрессоос байгуулагддаг. Форексын үйлчилгээтэй холбогдох дүрэм, журам баталж, хэрэгжилтийг нь хангах чиг үүрэгтэй.

Форексын үйл ажиллагаа явуулах эрхтэй хуулийн этгээдүүд Үндэсний фьючерсийн холбоо (national futures association)-г үүсгэн байгуулсан. Тус холбоо нь бараа, бүтээгдэхүүний фьючерс худалдааны хорооноос баталсан дүрэм, журмын хүрээнд гишүүн хуулийн этгээдүүдэд тавигдах нөхцөл шаардлага, дүрэм, журам баталж, мөрдүүлэх чиг үүрэгтэй. Dodd-frank Wall Street and consumer protection act-д заасны дагуу дараах хуулийн этгээд Үндэсний фьючерсын холбоонд бүртгүүлсний үндсэн дээр форексийн үйлчилгээ эрхлэх эрхтэй. Үүнд:

1. Санхүүгийн байгууллага (банк хадгаламжийн холбоо г.м);
2. Даатгалын компани болон тэдгээрийн хараат,охин компани;
3. Санхүүгийн холдинг компани;
4. Хөрөнгө оруулалтын холдинг компани;
5. Үнэт цаасны брокер, дилерийн компани тэдгээрийн хараат болон охин компани;
6. Бараа, бүтээгдэхүүний брокер дилерийн компани;
7. Валют арилжааны компани.

Дээрх компаниуд нь үндсэн үйл ажиллагаатайгаа хавсран форексийн үйлчилгээ эрхэлдэг.

Dodd —frank wall street reform and consumer protection act —р форексийн үйлчилгээ эрхэлдэг компанийн үйл ажиллагааг зохицуулсан байна.

Хэрэв тухайн үйлчлүүлэгч форексийн арилжаанд идэвхтэй оролцдог бол дээрх мэдээлэл дээр нэмж арилжаалагдах хэлцэл, эсхүл валют, хэлцлийн тавигдсан үнэ, огноо, дуусах огноо, тухайн улиралд худалдан авсан, зарсан, гүйцэтгэгдсэн эсхүл хугацаа нь дууссан форексийн бүх опционы талаарх мэдээллийг явуулна. Мөн үйлчлүүлэгчидээ өдөр бүр өмнөх өдрийн хийгдсэн арилжааны талаарх мэдээлэл болон дараа өдрийн хийгдэх арилжааны мэдээллээр хангах үүрэгтэй. Дараа өдрийн хийгдэх арилжааны талаарх мэдээлэлд дараах зүйлийг тусгана.

Тухайн хэрэглэгчийн бүртгэлийн дугаар:

1. Арилжааны үнийн жагсаалт, хэрвээ эдгээр арилжаанд оролцохыг хүсвэл тухайн арилжаатай холбоотой суутгагдах бүх шимтгэл, хураамжийн хэмжээ;
2. Зарах эсхүл худалдан авахаар захиалга өгөгдсөн арилжааны эсхүл валютын үнэ, тухайн захиалга хүчинтэй байх эцсийн огноо;
3. Тухайн компани нь онлайн эсхүл хэрэглэгчийн зөвшөөрсөн арга хэлбэрээр өдөр бүрийн мэдээлэл болон улирлын баталгаажуулалтыг хүргүүлэх үүрэгтэй.

Форексийн үйлчилгээ эрхлэх компани дараах үйл ажиллагааг зохицуулсан журамтай байх шаардлагатай.

- Зохицуулах байгууллагаас эрх авсан форексийн үйлчилгээ эрхлэх ажилтанг сонгон шалгаруулж авах;

- Валют худалдах болон худалдан авах захиалга, вэб сайт болон зар сурталчилгааны материалыг батлах зэрэг олон нийтгэж харилцах ажиллагаанд мониторинг хийх;

- Хэрэглэгчийг хангаж буй мэдээлэл нь ойлгомжтой цаг хугацаа алдаагүй, бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхэд шалгалт хийх;

- Хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэх;

- Хэрэглэгчийн дансан дахь форексийн хэлцэлүүдэд анализ хийх.

Зохицуулах байгууллага нь форексийн үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай IT системийн стандартыг баталж мөрдүүлнэ. Форексийн үйлчилгээний компани нь сүлжээний аюулгүй байдал, тухайн үйл ажиллагаанд шаардлагатай хүний нөөц, техник хэрэгслийн хангалттай байдал, зээлийн болон эрсдлийн менежментийн хяналт, үйлчлүүлэгчийн данс болон захиалгын гэрээг хадгалах, өөрийн электрон худалдааны platform-ийн хэвийн үйл ажиллагааг хангах журмыг Үндэсний фьючерсийн холбооноос гаргасан журамд нийцүүлэн өөрийн дотоод журмыг батлах үүрэгтэй. Үндэсний фьючерсийн холбоонд бүртгүүлсэн форексийн үйлчилгээний компанийн ажилтан жил бүр тус компанийн электрон худалдааны систем нь зохих стандартыг хангасан эсэхэд шалгалт хийнэ. Форексийн үйлчилгээ эрхлэх компани нь дараах шаардлагыг хангасан байх шаардлагатай.

1. Үйлчлүүлэгчдийн захиалга болон дансны мэдээллийн нууцлалыг хангах үүрэгтэй бөгөөд тус үйл ажиллагаа компанийн баталсан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтныг томилоно;

2. Үйлчлүүлэгчийн захиалга болон захиалгын гүйцэтгэлийн илтгэлийг үйлчлүүлэгчид тухай бүр хүргэх хүний нөөц, техник хэрэгсэлтэй байх, захиалга болон түүний гүйцэтгэлийн талаар үйлчлүүлэгчээс ирсэн гомдлыг тухай бүр шийдвэрлэх;

3. Үйлчлүүлэгчийг тус компанийн хүлээх эрсдлийн дээд хэмжээнээс хэтэрсэн эрсдэл болон бусад хэрэглэгчид эрсдэл учруулж болзошгүй арилжаанд орохоос сэргийлэх, үйлчлүүлэгчийн данс, төлбөрийн чадваргүй болохоос өмнө автоматаар дампуурлын нөхцөл байдлыг мэдэгдэх, дансны үлдэгдлээс хамаарч оролцож болох арилжааны үнийн дээд хэмжээг тогтоох бөгөөд уг хэмжээнд хүрсэн тохиолдолд захиалга цуцлагдах;

4. Форексийн үйлчилгээний компани нь үйлчлүүлэгчийн захиалга

болон дансны үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг бүртгэж хадгалах үүрэгтэй;

5. Захиалга өгсөн хэлцлүүдийн бүртгэл (захиалга ирүүлсэн болон гүйлгээ хийгдсэн огноо зэрэг захиалга дээр агуулагдсан мэдээлэл).

Мөн тус компаний арилжааны систем нь арилжааны дэлгэц дээрх үнийн өөрчлөлт бүр, хамгийн богино хугацаанд гарсан өөрчлөлтийн хугацаа, тухайн үнэ, хугацаанд арилжигдсан худалдааны хэмжээ болон арилжаа болгоны үнийг тодорхойлоход ашигласан арга, хэрэглэгчийн захиалга дэлгэцэн дээр хүрэхэд системийн харуулсан үнийн хэмжээнээс өөрөөр биелсэн захиалга болон үнийн өөрчлөлтийг харуулсан тайлан зэргийг харуулсан өдөр тутмын тайланг гаргаж байх үүрэгтэй. Форексийн үйлчилгээний компани дараах үйл ажиллагаа зохицуулсан журмыг баталж, мөрдөнө.

1. Өөрийн компаний болон холбогдох этгээдийн захиалгаас өмнө үйлчлүүлэгчийн биелэгдэх боломжтой захиалгыг биелүүлдэг байх;

2. Үйлчлүүлэгчийн захиалгыг биелүүлэхээс бусад тохиолдолд тухайн компанид ирсэн үйлчлүүлэгчдийн захиалгын нууцлалыг хамгаалах;

3. Тухайн компани нь өөр форексийн үйлчилгээний компанийн холбогдох этгээдэд данс нээхгүй байх.

Форексийн үйлчилгээний компани нь төлбөрийн чадваргүй болсон хэрэглэгчийн алдагдлаас өөрийн компанийг болон бусад үйлчлүүлэгчийн дансан дахь мөнгөн хөрөнгийг хамгаалах зорилгоор эрсдлийн сан байгуулах үүрэгтэй. Тус эрсдлийн санг бүрдүүлэхдээ гадаад валютын төрлөөс хамаарч арилжааны үнийн дүнгийн тодорхой хувиар өөр өөрөөр тогтоодог. Жишээ нь: (Фунт стерлин, Швейцарийн франк, Канадын доллар, Японы иен, Евро, Австралийн доллар, Шинэ Зеландын доллар, Шведийн крон, Норвегийн крон, Данийн крон зэрэг гол валютын арилжаанд урьдчилан тооцоолсон арилжааны үнийн дүнгийн 2%, бусад валютын арилжаанд 5%-г шимтгэл авч эрсдлийн санд төвлөрүүлдэг.

Форексийн үйлчилгээний компани нь өөрийн нээсэн данс болгоноос тодорхой хэмжээний шимтгэл авна. Арилжааны шимтгэлийг дараах байдлаар тооцож авна.

1. Фунт стерлин, Японы иен, Канадын доллар, Шведийн франк, Евроний цэвэр ашгийн 6 хувь;

2. Бусад валютын цэвэр ашгийн 20 хувь.

Форексийн үйлчилгээний компани нь үйлчлүүлэгчийн дансан дахь мөнгөн хөрөнгө, данс нээсэн үйлчлүүлэгчийн тоо болон үйлчлүүлэгчид

төлөх мөнгөн хөрөнгийн хэмжээг харуулсан бүртгэл хөтлөх шаардлагатай. Эдгээр мэдээлэл болон бусад санхүүгийн мэдээллийг долоо хоног бүр Үндэсний фьючерсийн холбоонд хүргүүлэх үүрэгтэй. Үүнийг холбоо хяналтандаа байлгаснаар зах зээлийг хянах боломжтой болдог байна.³

САНАЛ

1. Форексийн бизнесийн эрх зүйн орчныг бий болгож энэ бизнес эрхэлж байгаа хүмүүс болон тэдгээрийг зохион байгуулж байгаа компаниудын бодит эрсдлийг багасгах;

2. Эрх зүйн орчныг бий болгохдоо тодорхой хяналтын болоод зохицуулалтын эерэг үр дүнд хүрэх аргуудыг хэрэглэх, хяналтын сайн тогтолцоог бий болгох;

3. Энэхүү эрх зүйн орчныг бүрдүүлэх хүртэл Төрийн эрх бүхий байгууллага (Санхүүгийн зохицуулах хороо г.м.т.т.)-д тодорхой үүргийг өгч уг зах зээлийг ойрын хугацаанд зохицуулах;

4. Энэ бизнесийг эрхэлж байгаа хүмүүсийн тоог тодорхой болгох, өндөр хэмжээний мөнгө эргэлдүүлж байгаа хүмүүсийн нэрсийг нээлттэй болгох, Мэргэжлийн холбоо хэлбэрээр зохион байгуулах;

5. Энэхүү бизнесийн үйл ажиллагаанаас үүссэн эрүүгийн гэмт хэрэг гаргахад хэрхэн зүйчлэх, ямар байдлаар шийдвэрлэх талаар нэг мөр болоогүй шүүхийн практикийг нэг мөр болгох, энэ тал дээр судлаачдын санал, дүгнэлтийг хүлээн авах зорилгоор үйл ажиллагааг явуулах,

6. Иргэдийн мэдлэг мэдээллийг сайжруулах.

ДҮГНЭЛТ

Нийгмийн хөгжлийг дагаад хууль, эрх зүй хөгжих нь зайлшгүй болсон өнөөгийн нөхцөлд асуудлыг урьдчилан харж шийдвэрлэх гэхээсээ шинэ харилцааг гарсан даруйд нь нэн даруй зохицуулах шаардлага хийгээд бодит байдал байна. Ийм хэрэгцээ үүссэн салбаруудын нэг нь форексийн зах зээл юм. Энэхүү зах зээлийг зохицуулалтгүйгээр орхивол хадгаламж зээлийн хоршоодын дараагаар орох хэмжээний хохирол учрах магадлалтай гэж судлаачид үзэж байна. Ийм нөхцөл байдал ч 2008 оны эдийн засгийн хямралын үед пост социалист гэгддэг зарим оронд бий болсон. Иймээс энэ нөхцөл байдлаас сургамж авч бид энэхүү харилцааг зохицуулах хэрэгтэй.

³ National Forex Association "Information journal-2010" NY city, 2011 year

Залилан мэхлэх гэмт хэрэг



**ХЗҮХ-гийн Эрүүгийн эрх зүй,
криминологийн секторын эрдэм
шинжилгээний ажилтан Х.Өсөх**

Монгол Улс зах зээлийн эдийн засагтай орон болж хөгжиж байгаагийн хэрээр эдийн засгийн гэмт хэрэг түүн дотроо бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэргийн гаралт хохирлын хэмжээ жил ирэх тутам өсч байна. Залилан мэхлэх гэмт хэргийн гол онцлог нь гэмт этгээд бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгийг өөрийн мэдэлд авч, анхнаасаа эргэж хэзээ ч өгөхгүй гэсэн санаа бодол төрсөн байдаг.

Сүүлийн жилүүдэд үйлдэгдэж буй залилангийн хэргүүдийн дотроос визний залилангийн хэрэг хэрэг ихсэх хандлагатай байна. Энэ нь иргэдийн ямар ч аргаар хамаагүй гадаадад гарч ажиллах хүсэл сонирхлыг нь далимдуулан гэмт этгээдүүд компани, төрийн бус байгууллагын нэр барьж олон зуугаар нь гадаадад ажилд зуучилна гэж бүртгэн онц их хэмжээний хохирол учруулж иргэдийг хохироох болсон.

Залилан мэхлэх гэмт хэрэг нуугдмал байх, бүртгэгдээгүй байх шинж зонхилох бөгөөд хууль хяналтын байгууллагууд тоож үзэхгүй байх, ихэнх тохиолдолд иргэний нэхэмжлэлийн журмаар шийдвэрлүүлэхээр явуулдаг зэргээс болж уг гэмт хэргийн хүрээ сүүлийн үед өсөх хандлагатай байна. Залилан мэхлэх гэмт хэргийн нэг онцлог нь дийлэнх тохиолдолд үргэлжилсэн шинжтэй байдаг. Гадаадынханы эртнээс тодорхойлсон гэнэн цайлган, хүнд итгэмтгий, тусархаг..... монголчууд маань өөр хоорондын харилцаандаа итгэлцэл найдварыг маш их хүндэлдэг. Бусдад итгэх, хэт итгэх нь олон сайн талтай боловч зарим нэг бусармаг этгээд энэ байдлыг ашиглаж гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломжийг олгодог сөрөг үр дагаварт хүргэдэг байна.¹

БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ЗАЛИЛАН МЭХЭЛЖ АВАХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ

Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн Тусгай ангийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт хамаардаг. Залилан мэхлэх гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нийтлэг шинжийг агуулахаас гадна өөрийн гэсэн онцлогтой нь уг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжээр илэрдэг². Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 148 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг тодорхойлсон эрүүгийн эрх зүйн гурван хэм хэмжээг хуульчилсан³. Жич: Эрүүгийн хуульд 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн өөрчлөн найруулгаар Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэгт 148.4.Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн зохицуулалт нэмэгдсэн.

Залилан мэхлэх гэмт хэрэг нь ихэвчлэн танил тал, найз нөхдийн хүрээнд үйлдэгдэж байгаа учир энэ төрлийн гэмт хэргийн хүрээ тэлэгдсээр байна. Үнэгүй бяслаг зөвхөн хулганы хавханд л байдаг гэдэг үт бий. Анзаарагдахгүй хэрнээ залилангийн шинжтэй олон хэрэг газар аваад байна. Жишээ нь, сүүлийн үед автовокзалуудын хяналтын пост дээр өдөрт нийм төрлийн хэрэг 4-5 бүртгэгдэж байна. Хөдөө орон нутгаас эцэг эхчүүд нь Улаанбаатарт сурч оюутан хүүхдүүдээ дайгдуулсан мах, төрөл бүрийн хүнсний зүйл, хувцас хунар, бэлэн мөнгө зэргийг хууль бус, хулгайн жижиг оврын автобусууд дундаас нь шамшигдуулах болжээ. Сонгинохайрхан дүүргийн автовокзалын хяналтын байцаагчид ирсэн гомдлын дагуу шалгах бүрт хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэлд биш огт танихгүй хэн нэгэнд эд зүйлээ дайгаад явуулчихсан тохиолдолд их гарах болжээ. Тиймээс иргэд нэг газраас нөгөө газар руу эд зүйлээ тээвэрлүүлэхдээ жолоочийн ажлын үнэмлэх, компанийн лого, дүрэмт хувцас зэргийг сайтар шалгаж байх хэрэгтэйг холбогдох хүмүүс, жолооч нар анхааруулж байна. Мөн утасны дугаар авлаа гээд эд зүйлс чинь хүрэх газартаа найдвартай очихыг нягталж үзэх хэрэгтэй. Энэ мэт хэрэг өдөрт 4-5 удаа гарч байгаа нь микро автобусны үйлчилгээний залилан дэлгэрээд байгааг сануулж байна. Залилан хийж байгаа этгээд нь өөрийгөө тендерийн микро, хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний жолооч мөн гэж хэлээд утасны дугаар, өгч, эд

² Д.Адьяабаяр, “Залилан мэхлэх гэмт хэрэг” сургалтын гарын авлага, Ув., 2008 он, 31 дэх тал.

³ Мөн тэнд.

зүйлийг нь аваад дээрээс нь хөлс гэж 3000-5000 төгрөг авдаг байна.⁴

Монгол Улсын дээд шүүхээс 2006 оны 12 дугаар сарын 21-нд Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж эвч шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар гэсэн 51 тоот тогтоол гаргасан боловч тухайн тогтоолын заалтыг удирдлага болгож хэргийг зүйлчлэн шийдвэрлэх асуудлын талаар төдийлөн нэг мөр ойлголт бий болохгүй байгаагаас эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаад эцэст нь хэрэгсэхгүй болгож иргэний журмаар асуудлыг шийдэх аль эсвэл иргэний хэрэг үүсгэн шалгасан асуудалд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах зэрэг учир ойлгомжгүй байдал нэлээдгүй байна.

Жишээ:

Иргэний эрх зүйн харилцааны банк, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулсан боловч өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзан хамтран үүрэг гүйцэтгэгчийнхээ итгэлийг эвдсэн үйлдэл нь иргэний журмаар хянан шийдвэрлэвэл зохих иргэний маргаан болохыг ялгалгүй шийдвэрлэсэн хэргийн нэг нь. Ц.Б нь бусадтай хамтран өмнө нь банкны барьцаанд тавьсан орон сууцыг барьцаанд тавьсан гэдгээ нуун далдалж, барьцаанд тавиагүй гэж хохирогч Ж.С-д итгүүлэн уг байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан зээлийн гэрээ байгууллаа гэж хууран мэхэлж түүнээс 18,900,000 төгрөгийг залилан мэхэлж авсан гэх хэргийг Орхон аймаг дахь Сум дундын шүүхийн шүүхийн 2009 оны 9 дүтээр сарын 1-ний өдрийн 134 дүгээр цагаатгах тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бөгөөд иргэний хэрэг байна гэсэн үндэслэлгүй дүгнэлт хийж, хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж, давж заалдах шатны шүүх уг цагаатгах тогтоолыг хэвээр үлдээсэн нь Ц.Бгийн үйлдлийг ялгалгүй шийдсэн байна.

Д.Э нь бүлэглэн 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, 2005 оны 2 дугаар сарын 7-ны өдрүүдэд шунахайн сэдэлтээр өөрийн ажиллаж байсан Х банкны Чингэлтэй дүүрэг дэх салбараас гурван удаагийн үйлдлээр 55 сая төгрөгийг орон сууц өмчлөх эрхийн хуурамч бичиг баримт барьцаалан хуурч мэхлэх аргаар залилан мэхэлж авсан хэрэгт холбогджээ. Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэгт зааснаар 5 жил 1 сар хорих ял шийтгэж ... шийдвэрлэжээ. Харин давж заалдах шатны шүүх ялтан, тэдгээрийн өмгөөлөгчдийн гаргасан гомдлыг үндэслэн 2009 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 742 дугаар магадлалаар шийтгэх тогтоолын

⁴ http://niigem.zaluu.com/index_med.php?kl=181

тогтоох хэсэгт шүүх ял шийтгэснийг хүчингүй болгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж шийдвэрлэжээ. Хэрэгт авагдсан 2004 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 40 дүгээр шийтгэх тогтоолоос үзвэл орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээ болон өмчлөх эрхтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагааг хуурамчаар бүрдүүлж түүнийгээ ашиглан банкнаас зээл нэрээр хууран мэхлэж, мөнгө авдаг байсан ба үүнийг давж заалдах шатны шүүх анхааралгүй ямар үндэслэлээр гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзсэнээ тайлбарлалгүй банкны барьцаанд тавьж байгаа үл хөдлөх хөрөнгө нь өөрөө бодитойгоор байхгүй, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ нь хуурамчаар үйлдэгдсэн, тухайн үл хөдлөх эд хөрөнгөд үүрэг ногдуулсан эсэхийг нотолсон баримт болох эрхийн улсын бүртгэлийн лавлагаа хуурамч байхад иргэний хэрэг болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Сүүлийн үед банк, албан байгууллага, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, ломбард, валют солих газар зэрэг газруудад орчин үеийн техник технологи нэвтрэн хяналтын камертай болсноор хуурамч мөнгө, баримтаар тухайн газруудаас мөнгө залилан мэхэлж авсан гэмт этгээдүүдийн дүрс зураг хадгалагдсанаар цаг алдахгүй гэмт этгээдүүдийг эрэн сурвалжлах болсон.

ХУУРАМЧ ЧЕКЭЭР ЗАЛИЛАН МЭХЛҮҮЛЭХ ЭРСДЛЭЭС СЭРГИЙЛЭХ

Хэн нэгний гар утас, и-мэйлээр “Та гар утасны сериал дугаараараа 1.000.000 ам.доллар хожлоо, та бидэнтэй холбогдоно уу” гэсэн захиа ирдэг. Хэрвээ та овог нэр, төрсөн огноо, гэрийн хаяг, шуудангийн хаяг, холбоо барих утас зэргийг и-мэйлээр явуулбал шагналын урьдчилгааны шимтгэл нь DHL болон бусад шуудангаар 20,000 ам.доллар хүртэл дүнтэй Американ Экспресс банкны бэлэглэл, жуучлалын хуурамч, алдагдсан болон хүчингүй чекүүдийг ирүүлдэг бөгөөд энэхүү шимтгэлийг гадаад руу буцаан шилжүүлсний дараа 1.000.000 ам.долларыг шилжүүлнэ хэмээн итгүүлдэг. Иргэд хүлээн авсан чекээ арилжааны банкуудад очиж солиулан, улмаар чекийг явуулсан этгээд рүү олон улсын мөнгөн гуйвуулгаар бэлэн мөнгийг шилжүүлдэг. Гэвч бодит байдал дээр манай иргэд ямар нэгэн мөнгө хожоогүй бөгөөд гэмт этгээдүүдийн хуурамчаар үйлдсэн чек, хууль бус замаар олж авсан бэлэн мөнгөний чекийг сольж өгөөд хохирсон байдаг аж.

Үүнийг олон улсад Нигерийн залилан гэдэг бөгөөд гэмт этгээдүүд нь хуурамч нэр, хаягтай бичиг баримттай, интернэтээр хохирогчтой харилцаж байдаг тул илрүүлэх үйл ажиллагаа явуулахад туйлын хүндрэлтэй байдаг байна.

Нөгөө талаас дэлхий нийтийн гэмт хэргийн хандлагыг ажиглахад сүүлийн жилүүдэд гэмт хэрэгтнүүд үйлдлийн арга барил, хэлбэрээ илэрхий өөрчилж, буу барьж, баг өмсөж дээрэм хулгай, луйврын гэмт хэрэг үйлдэхээс илүүтэйгээр identity theft буюу хувь хүний мэдээллийг хулгайлах, хууран мэхлэх замаар цуглуулж, улс үндэстэн дамнасан залилан мэхлэх, луйврын гэмт хэрэг үйлдэхдээ өргөнөөр ашигладаг болоод байгаа нь хувь хүн, Монгол Улсын иргэн таны болон таны гэр бүл, үр хүүхдүүдийн талаарх мэдээлэл гэмт хэргийн сртөнцөд ямар их үнэ цэнэтэй болоод байгаа нь ойлгомжтой юм.⁵

КОМПЬЮТЕР, ТЕЛЕМАРКЕТИНГИЙН ЗАЛИЛАН

Мэдээллийг худалдах хэрэгсэл байнга өөрчлөгдөж, хүмүүс бие биетэйгээ солилцоо хийх арга телемаркетинг шуудангаар шилжүүлэх хэлбэрээр солигдох болсон. Энэ нь зөвхөн телефон төдий бус, сүүлийн үед интернэт ашиглан явагдах болсон нь энэ зуунд хурдацтай хөгжих магадлалтай байна. Шинэ төрлийн мэдээллийн хэрэгслийг сонгох боломж нэмэгдэхийн сацуу хэрэглэгчийн сонголт өсөөд зогсохгүй, ашиг олохын тулд шинэ технологийг нэвтрүүлэх арга замыг хайх, гэмт зорилгоор ашиглах явдал нуугдаж байна.

Сүүлийн үед урьдчилгаа болгон мөнгө, эд хөрөнгө залилан авах, компьютер ашиглах зэрэг аргаар бусдын эд хөрөнгө болон түүнийг эзэмших эрхийг хууль бусаар олж авах залилан мэхлэх шинэ хандлага буй болжээ.

Интерполын ажлын хэсгийн боловсруулсан эмхтгэлд компьютерын гэмт хэргүүдийг QA (хууль бусаар нэвтрэх, олж авах) QD (комьютерийн мэдээллийг өөрчлөх) QF (комьютерын залилан), QR (хууль бусаар хуулбарлах), QS (комьютерын ажиллагааг тасалдуулах), QZ (комьютерийн бусад гэмт хэргүүд) гэж 6 ангилжээ.

⁵ Цагдаагийн байгууллагын албан хаагчид арилжааны банкнаас сэлж бүхий худалдан авалт хийхдээ талаар 2012 оны 4 сарын 9-ний өдрөөс хойш Улаанбаатар хотын үйлчилгээний томоохон цэгүүд болох "Скай" их дэлгүүр, Улсын их дэлгүүр, "Централ таур" дэх дэлхийн томоохон брендийн бараа, бүтээгдэхүүн зардаг дэлгүүрүүд зэрэг газруудаас нийт 100,000 гаруй ам.долларын картаар худалдан авалт хийхээр оролдсон болонч түүнээс эзрм нэг тохиолдол нь зөвшөөрөгдөж ойролцоогоор 45.0 сая орчим төгрөгийг худалдан авалт хийгдсэн байсныг тогтоосон байна. Дээрх дэлгүүрүүдийн хамгаалалтын камеруудаас сэлж бүхий этгээдүүдийн дүрс бичлэгийг авч үзэхэд эзр төрхтэй, 25-30 орчим насны гурван эрэгтэй хүн байжээ. Тэд Малайз Улсын иргэд байжээ. Тэдний авч явсан цуна, хувцас, гэр цүнхтэй нь үзэж хийхэд 51 ширээг хуурамч карт илэрчээ.

- QFC-мөнгөний автоматыг залилах;
- QFF-компьютерээр хуурамч баримт хийх;
- QFG-Тоглоомын автоматыг залилах;
- QFM- оруулах гаргах программ;
- QFR-төлбөрийн хэрэгслүүдийг ашиглан залилах;
- QFT- телефоны залилан;
- QFZ-Компьютерийн бусад залилан зэрэг гэмт үйлдлийн⁶хамруулсан

байна.

Хүснэгт 1. Монгол Улсын хувьд мэдээлэл аюулгүй байдлын ажиллагаанд 2009, 2010 онд доорх хэрэг үйлдэгдэж байжээ.

2009 онд					
Эүйл, хэсэг	Хэрэг №	ЭН Үүсгэсэн	ЭН гарсан огноо	Хэрэг гарсан газар	Утга
227.1	20831642	2009.01.15	2008.10.05	Баянзүрх дүүрэг.	Айвенхо Майнз Монголиа ИНК-ийн цалин хөлсний хэмжээг харуулсан вэб сайт тавьсан байна.
2010 онд					
228.1. Компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, бирлуулах - Хүндэвтэр,	21032284	2010.02.10	2009.09.16 07:10:00	16000 Баянгол дүүрэг, 7-р хороо, Төв орон нутагт.	А нь сансар интернет хэвлэлийн компьютер мэдээлэл сүлжээнд хууль бусаар нэвтэрсэн
228.1. Компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэх, бирлуулах - Хүндэвтэр,	21033525	2010.08.20	2010.08.08 10:00:00	16000 Баянгол дүүрэг, 17-р хороо, Төв орон нутагт.	БГД, 18 хороо "Х" компани динжиком ххк интернетийн сүлжээнд дураараа холболт хийж айлуудад интернет таньсан байна.

⁶ Залилан мэхлэх гэмт хэрэг, сургалтын гарим авлага УБ 2008 он 81 дэх тал.

226.1. Компьютерийн мэдээлэл, программыг нэрчлэх, эндэх, сүйтгэл - Хүндэтгэл,	21041125	2010.10.07	2010.09.20 11:00:00	15000 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Төв орон нутагт,	2009.12.24-нд халгаламжийн хүү дутуу бодсон, 2009.3-р сард "тэнгэрийн таалаа сан" тбб-ны ланснаас 6000000 төгрөг хуурамч гарын үсгээр өгсөн
---	----------	------------	------------------------	--	---

ГАР УТАСНЫ ЗАЛИЛАН МЭХЛЭЛТИЙГ ИЛРҮҮЛЭХ

Монгол Улсын хувьд зөвшөөрөлгүй гар утасны хэрэглээ, тохиргоог өөрчлөх, хуулбарлах үйл ажиллагааг хуулиар хориглоогүй бол АНУ-ын хувьд 1993 оноос "Үүрэн холбооны залилан мэхлэлт гэж хуулийн зүйлээр хариуцлага тооцдог болжээ."⁷

Залилан мэхлэлтийг илрүүлэх

Үйлчилгээний компани залилан мэхлэлтийг илрүүлэхээс өмнө үүрэн холбоо хэрэглэгч тодорхой шинж тэмдгийг ашиглан, тухайн үйлдлийг илрүүлэх боломжтой байдаг. Шинж тэмдэгүүдэд:

- Олон удаа утас андуурч залгах буюу таслах;
- Гадагш залгаж ярихад хэцүү болох;
- Дуут захиаг сонсоход түвэгтэй болох;
- Хүлээн авсан дуудлага гэнэт ярьж байгаа дохио авах буюу

дугаарт холбогдох байнга залгадаг хүнээс өөрийн дугаар уруу ярихад хэцүү байдал учирсан эсэхийг асуух;

- Залгаагүй дугаар төлбөр тооцоон дээр бичигдсэн байх.

АНУ-д Гар утасны залилан мэхлэлттэй тэмцэх зорилгоор 1991 онд Үүрэн холбооны залилан мэхлэлттэй тэмцэх алба байгуулагджээ. Уг алба нь мөрдөн байцаалтад туслах үүрэгтэйгээс гадна судалгаа явуулж, олон нийтэд үүрэн холбооны залилан мэхлэлтээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулдаг байна.⁸ Хэрэглэгчийн хувьд, тэмцэхэд маш хэцүү буюу найдваргүй гэж болно. Технологийн өндөр мэдлэгтэй хулгайчид агаа дахь ямар ч долгионыг барьж мэдээлэл авч чаддаг байна.

⁷ Wireless: Phoneprient to protect Cellular Users in GTE Wireless, Gulf Coast Cambridge Telecom Report, June 30, 1997

⁸ Blair, K. Wireless Crime -Fighting will Put Cameras throughout Gulf Breeze. PersonalNewsJournal.com

Үүнээс урьдчилан сэргийлэх тодорхой хэдэн арга байдаг. Үүнд:

- Өөрийн үүрэн холбооны гэрээг машин буюу бусад газар ил орхихгүй байх;
- Хамгаалалтын программ суулгах;
- Боломжтой бол үүрэн холбооны антенныг машинаас авч байх;
- Албан ёсны зөвшөөрөлтэй засварын ажилтнаар гар утсаа засуулж, шалгуулж байх;

Техник технологийн дэвшлийг гар утасны хамгаалатанд өргөнөөр ашиглах болсоноор гар утсыг шинжих, хуулбарлах үйл ажиллагааг бууруулах боломжтой бөгөөд тухайн гэмт үйлдлийг хуульчлан зааж өгсөнөөр гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох нөхцөлийг бүрдүүлж өгнө.

ДҮГНЭЛТ

Залилан мэхлэх гэмт хэргийн гол онцлог нь гэмт этгээд бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгийг өөрийн мэдэлд авч, анхнаасаа эргэж хэзээ ч өгөхгүй гэсэн санаа бодол төрсөн байдаг боловч мөн гэрээгээр хүлэсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшингч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ⁹ гэж тайлбарласан байдаг.

Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ иргэний эрх зүйн харилцааны эзэлийн гэрээг ашиглан ут гэмт хэргийг үйлдэж байна. Гэхдээ залилан мэхлэх гэмт хэргийн объектив талын 1 шинж болох хуурч мэхлэх үйлдлийг Иргэний хуулийн 59 дүгээр зүйлийн Хууран мэхэлж хийсэн халцлаас ялгаж харах шаардлагатай.

Залилан мэхлэх арга нь жил ирэх тусам арга нь улам нарийсч, нууц далд хэлбэртэй явагдаж байна.

Иргэдтэй орон сууцны захиалгын гэрээ байгуулж, мөнгийг урьдчилан аваад гэмт этгээд иргэдийн итгэл эвдэн мөнгийг өөр зориулалтаар ашиглаж үрэгдүүлэх.

Визний ангилал өөрчлөх, визний сунгалт хийх, оршин суух зөвшөөрөл олгох болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны 02

⁹ Улсын дээд шүүхийн 51 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэг

дугаартай тэмдэг зэргийг ашиглах зорилгоор хуурамчаар үйлдэж улмаар гадаадын иргэний гадаад паспортад (уг дардаснуудыг) дарж өгөх зэргээр иргэдийг залилан мэхлэх явдал ихсэж байна. Сүүлийн үед эдийн засагчид залилангийн хэрэг их үйлдэх болсон. Энэ нь цалингийн зээл хуурамчаар олгох явдал юм. Залилан мэхлэх гэмт хэрэг ихсэж байгаа нь нийгмийн үзэгдэлд сөргөөр нөлөөлж иргэд хоорондын итгэх итгэлийг байхгүй болгож байна.

Залилан мэхлэх, завших үрэгдүүлэх гэмт хэрэг нь онлайн, интернет хэлбэрээр бусдыг хуурч мэхлэх, хуурамч гүйлгээ хийх, хуурамч байгууллага бий болгох, гэмт хэргээ далдлахыг тулд санаатайгаар болон зохиомлоор дампуурах, сүлжээний бизнес, гоо сайхны болон гадаад улсаас уран зураг, эм бэлдмэл оруулж ирэх зэргээр шатлал бүхий сүлжээ үүсгэж бусдыг их хэмжээгээр хохироох, бусдын дансыг ашиглах, албан тушаалын (сүүлийн үед банк санхүүгийн салбарт) давуу байдлаа ашиглах, байгууллагынхаа нууц код, тэмдэгтийг хэрэглэх, хуурамч гүйлгээ хийх замаар үйлдэгдэж байна. Эдийн засаг, банк санхүүгийн салбарын үйл ажиллагаанд тавих хяналт сул, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт дутмаг зэрэг нь эдгээр гэмт хэрэг гарах суурь шалтгаан болж байна. Зар сурталчилгаа, түүний хяналтгүй байдал, эрх зүйн зохицуулалт байдгүй зэрэг нь хохирогчдыг энэ төрлийн гэмт хэрэгт ихээр өртөж хохироход хүргэж байгаа төдийгүй цаашид бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх үндсэн нөхцөл болж байна.

САНАЛ

- Залилангийн хэргийг шалгахдаа иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан уу эсвэл залилан мэхлэх гэмт хэрэг үү гэдгийг тогтоохдоо эрх зүйн харилцаагаа зөв тогтоох шаардлагатай.

- Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан иргэний эрх зүйн гэрээ, хэлцлийг иргэний эрх зүйн зээлийн гэрээ болон түүнтэй төстэй гэрээний харилцаа, хууран мэхэлж хийсэн хэлцлийг байгуулахдаа хандсан субектив санаа зорилго, сэдэлтийг нарийн тогтоох ёстой.

- Харилцаанд оролцогчдын санаа, зорилго, хүсэл зоригийг зөв тогтоох ёстой.

- Хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэлж шалгах шаардлагатай.

- Олон улсын банк хоорондын мөнгөн гуйвуулгыг чанаржуулж хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

- Интернэтийн орчин дахь интернэттэй банк (мобайл банк) зэргээр дамжин иргэдийн гээгдүүлсэн хуурамч үнэмлэхээр данс нээлгэдэг явдлыг

өндөр хяналттай болгох.

- Мөн иргэд хоорондын гэрээгээр халхавчлаж залилан хийдэг явдал ихсэх болсон үүнийг хэрэгт авагдсан нотлох баримтаар шалгах хэрэгтэй.

- Эдийн засаг, банк санхүүгийн байгууллагын хяналтыг сайжруулах.

- Зар сурталчилгаанд хяналт тавьж, эрх зүйн зохицуулалтыг нь сайжруулах.

- Гар утсаар мэдээлэл алдагдаж болзошгүй тул үүнийг зохицуулсан эрх зүйн зохицуулалт бий болгох.

----- оОо -----

хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Хугацаагүй хорих ял ба түүнийг эдлүүлэхэд анхаарах зарим асуудал



ШШГЕГ-ын хэлтсийн дарга, дэд
хурандаа, докторант Ц.Очгэрэл

Дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байгаа цаазаар авах ялыг хэрэглэх эсэх талаар улс орон болгон харилцан адилгүй бодлого баримталж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар цаазаар авах ялыг практикт болон хуульчлан халсан 140 гаруй орон байгаа талаар судлаачид тэмдэглэжээ.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтад ялын дээд хэмжээ буюу эрүүгийн ялын онцгой төрөл болох цаазаар авах ялыг оногдуулах тодорхой тохиолдлуудыг заан тодорхойлсон байгаа хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 онд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх талаар албан ёсны мэдэгдэл хийсэн, мөн “Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай” хуулийг Улсын Их Хурлаас 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр хэлэлцэн баталснаар Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагын өмнө цаазаар авах ялыг халахтай холбоотой шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээх эрх зүйн үндэс баталгаажсан гэж үзэж болно.

Ийнхүү Монгол Улс нь цаазаар авах ялыг халах бодлогыг хуулиар баталгаажуулсан энэ цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөс “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” санаачилсан

бөгөөд уг төсөлд тусгаснаар ялын шинэ хэлбэрийг “Бүх насаар хорих ял” хэмээн тодорхойлж, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулагдсан байна.

Эрдэмтэн, судлаачдын зүгээс ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг онцгой ял хэмээн тодорхойлж ойлгодог ба нэгэнт цаазаар авах ялыг халах тохиолдолд сольж хэрэглэх ял нь эрүүгийн эрх зүйн зарчимд нийцсэн төдийгүй улс орны эрүүгийн ялын бодлогод сөрөг нөлөөлөл үзүүлэхээргүй шинжийг агуулсан байх нь зүйн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, эрүүгийн ялын аливаа төрөл, хэмжээ нь ял оногдуулж буй гэмт үйлдлийн нийгмийн хор аюул, шинж чанарт тохирсон байхын зэрэгцээ эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахуйц шинжийг агуулсан байх ёстой гэсэн үг юм.

Бүх насаар хорих ялыг хуульчлан тогтоохын өмнө зайлшгүй анхаарвал зохих нэг зүйл нь олон улсад хэрэглэгдэж байгаа “Бүх насаар хорих-Хугацаагүй хорих” гэсэн хоёр ойлголтын хооронд ялгаа бий эсэхийг нарийвчлан тогтоох нь зүйтэй болов уу. Үг зүйн утгаар нь шинжилж үзвэл “Бүх насаар нь хорих” гэдэг нь тухайн ялтанд ямар нэг өршөөл, хөнгөлөлт байхгүйгээр насан эцэс болтол хорих ял эдлэх агуулгыг илэрхийлж байгаа бол “Хугацаагүй хорих” нь хуульд заасан хорих ялын хугацаанаас илүү хугацаагаар ял оногдуулах, тодорхой хугацааны дараа ялаас чөлөөлөх боломж үүсч болох санааг агуулж байна гэж үзэж болох юм. Иймээс эрүүгийн эрх зүйн зарчмын үүднээс ял шийтгэгдсэн этгээдэд хүмүүнлэгийн үүднээс хандаж боломж олгох, итгэл найдвар үлдээх эсэх нь энэхүү хоёр төрлийн нэршлээс хамаарах мэт ойлголт төрж байна.

Нөгөө талаас, эрүүгийн ялын бодлогын үр нөлөөгөөр нь ял шийтгэлийн хамгийн хүнд төрөл болох хорих ялын дээд хязгаар хэмээн тооцож, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, нийгмийн аливаа харилцаанд онц их хэмжээний хохирол учруулсан этгээдэд цээрлүүлэх шинж чанартайгаар зайлшгүй оногдуулж болох ял гэж үзвэл “Бүх насаар хорих ял” гэж тогтоох нь илүү тохиромжтой байх хувилбар гарч байна. Энэ нь хохирогчийн сэтгэл зүйд үйлдсэн гэмт хэрэгт тохирсон ял оногдуулах буюу ял шийтгэл гарцаагүй, оновчтой байх талаар зохих нөлөөлөл үзүүлж болох талтай.

Эндээс “Бүх насаар хорих-Хугацаагүй хорих”-ын аль ч нэршлээр хэрэглэсэн тухайн ялтанд тодорхой ял эдлэх хугацааны дараа зан төлөв, хандаагын хувьд болон хууль журамд нийцүүлэн биеэ авч явах байдал зэргээрээ эсрэгээр өөрчлөгдөх боломж олгох нь эрүүгийн хариуцлагын зорилго хангагдах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хүнлэг ёсыг сахих, хүний эрхийг дээдлэх зарчимд нийцсэн зохицуулалт болох юм.

Иймд эрүүгийн ялын бодлого, хүмүүнлэгийн зарчмын аль алиныг

хослуулах замаар ялын дээд хэмжээг “Бүх насаар хорих ял” хэмээн тодорхойлохын зэрэгцээ тодорхой хугацаа тогтоож тухайн ялтанд төрийн өршөөл, энэрэлийг хүртэх боломж олгох асуудлыг хамтад нь хуульчлах нь зүйтэй юм.

Түүнчлэн хорих ялын шинэ төрөл хэмжээг хуульчлан тогтоохын өмнө одоогийн боловсруулагдаж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, тус салбарт хийгдэж буй бодлогын өөрчлөлттэй уялдуулан авч үзэх шаардлага гарч ирж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар хамтран боловсруулж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга нь шүүхийн бүхий л төрлийн шийдвэрийн бислэлтийг нэг мөр, бодит хэлбэрээр хангаснаар эрүүгийн ял эдлүүлэх буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Тухайлбал, хорих ял эдлүүлэх чиглэлээр хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн буюу гэмт зан үйл, хандлагыг өөрчлөх, нийгмийн идэвхтэй гишүүн болгон чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлын зөв тогтолцоо бий болгох, хорих ял шийтгэгдсэн этгээдийг албадан хөдөлмөрлүүлэх, улмаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үр дүнтэй барагдууладаг нөхцөлийг бүрдүүлэх зэрэг үндсэн үзэл баримтлалуудыг тусгаж өгсөн.

Хорих ял эдлүүлэх дэглэмийн хувьд эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад илүү тохиромжтой хэлбэр буюу нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхээр тусгасан нь ял эдлүүлэх тогтолцоон дахь сөрөг үр дагавар болох хоригдогсод гэмт зан үйлд дадлагажих, шоронжих нөлөөллийг багасгахад чухал нөлөөтэй гэж үзсэн.

Энд нэг зүйлийг зориуд онцлон тэмдэглэхэд нээлттэй болон хаалттай дэглэмийн алинд ялтныг ял эдлүүлэх асуудал нь цэвэр ялтны хувийн байдлаас шалтгаалах ба тухайн ялтны зан үйл, ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль, тогтоомжид нийцүүлэн биеэ авч яваа байдал нь хэдий чинээ зөв хандлагыг агуулж байна тэр хэмжээгээр илүү нээлттэй, хуулийн болон эрхийн урамшуулалтай хэлбэрээр ял эдлэх боломжийг олгох, эсрэгээрээ хорих байгууллагын дотоод дэг журмыг зөрчсөн, гэмт буюу сөрөг зан үйлээ өөрчлөхөд идэвхтэй ханддаггүй, ял эдлэх хугацаанд хөдөлмөрлөх, суралцах, төлөвших үүргээ биелүүлж чадахгүй байгаа, бусдад сөрөг нөлөөтэй ялан хаалттай буюу эрхийн тодорхой хязгаарлалттай, хуульд заасан хөнгөлөлт, боломжууд нь хаагдсан нөхцөлд ял эдлэх явдал нь энэхүү тогтолцооны гол онцлог юм.

Бүх насаар хорих ялын талаар хуулийн төсөл санаачлагчийн зүгээс тодорхойлохдоо тусгай гянданд буюу ганцаарчлан хорихоор урьдчилан

тооцож байгаа энэ үед гяндан буюу ял эдлүүлэх чангаруулсан нөхцөл, түүний нэршлийн талаар саналаа хуваалцъя гэж бодлоо.

Гяндан буюу хорих ангийн төрөл, дэглэмийн алинд ч үл нийцэх хэлбэрийг арилгах нь шинээр боловсруулж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэг шинэ зохицуулалт юм. Гяндан хэмээх ойлголт нь эртнээс улс орнуудын ял эдлүүлэх системд хорих ял эдлүүлэх, цагдан хорих чиг үүргийн аль алинийг гүйцэтгэж ирсэн, хатуу хяналт, нөхцөл бүхий хорих байр гэсэн ойлголтоор хэрэглэгдэж ирсэн байдаг.

Шинэ үеийн Монгол Улсын хорих ял эдлүүлэх тогтолцоонд гянданд ял эдлүүлэх чиглэл нь 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуульд анх тусгагдсан бөгөөд тухайн үеийн ЗСБНХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйгээс хуулбарлагдан орж ирсэн гэж судлаачид үздэг.

Өнөөдрийн байдлаар шүүхийн практикт онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт үйлдлийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан гянданд ял эдлүүлэхээр тогтоож байгаа ба ял эдлүүлэх хамгийн хатуу хяналт, цээрлэл, хязгаарлалттай нөхцөл хэмээн ойлгож хэрэглэж байна. Тэгвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудад зааснаар бол гяндан нь хорих анги биш, ял эдлүүлэх дэглэмийн нэг төрөл ч биш байхаар ойлгогдож хэрэглэгдсээр өнөөдрийг хүрчээ.

Судлаачдын тодорхойлж буйгаар болон дэлхийн бусад орнуудын туршлагаас харвал хорих ял эдлүүлэх ажиллагааг цэгцтэй, үр дүнтэй зохион байгуулахад хорих ялыг эдлүүлж буй нэгж (хорих анги)-ийн бүтэц, зохион байгуулалт, нөхцөл журам, үйл ажиллагааны зохион байгуулалт, хяналт, эрхийн хязгаарлалтын онцлог зэрэг нь ялын зорилготой уялдсан байх нь чухал ач холбогдолтой гэдгийг харуулж байна.

Иймд хорих ял эдлүүлэх төрөл дэглэмийг нээлттэй, хаалттай хэмээх томьёололд бүхэлд нь багтаах замаар гяндан хэмээх ойлгомжгүй төрлийг өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Харин хувийн болон үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас шалтгаалан хяналт-хамгаалалт, эрхийн хязгаарлалтын хувьд чангаруулсан нөхцөл бүхийн хорих ангийг “Хаалттай” хэмээх томьёололоор тодорхойлж ял эдлүүлэх нөхцөл, журмаа тогтоох шаардлагатай юм.

Нээлттэй, хаалттай гэсэн дэглэмийн ялгаатайгаар хорих ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах тохиолдолд хаалттай дэглэм нь тухайн ялтны хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлогоос шалтгаалан ганцаарчлан болон 4 хүртэл тооны хоригдогчийг хамтад нь хорих өрөөний системд

ял эдлүүлэхээр тооцох нь илүү үр дүнтэй байх боломжтой юм. Ингэвэл хорих ял эдлүүлэх ажиллагааг ялтны хувийн байдал болон үйлдсэн гэмт хэргийн байдлыг харгалзан зохион байгуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ хяналт-хамгаалалтын болон нийгэмшүүлэх, хөдөлмөрлүүлэх, бие даан ухамсарлуулах арга хэмжээ үр дүнтэй, ялгамжтай явагдах боломж нээгдэнэ.

Дэлхийн улс орнуудад цаазаар авах ялыг халах бодлого хэрэгжихийн зэрэгцээ ямар төрлийн ялаар сольж хэрэглэж байгааг судалж үзвэл бүх насаар буюу хугацаагүй хорих ялыг сонгон хэрэглэх явдал түгээмэл байгаа нь ажиглагдаж байна.

Тиймээс “Бүх насаар хорих ял”-ыг Монгол Улсын хувьд хуульчлан хэрэгжүүлэхдээ бидний боловсруулж буй хаалттай дэглэмд ганцаарчлан эдлүүлэх ба тодорхой хугацааны дараа ял эдлүүлэх нөхцөлийг ялтны хувийн байдлыг харгалзан хөнгөрүүлэх зарчмаар эдлүүлэх саналыг дэвшүүлж байна.

Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй холбоотой дараагийн нэг асуудал нь ял шийтгэгдсэн этгээд чухам хичнээн жилийн хорих ял эдэлсний дараа түүнд ял эдлэх дэглэмээ хөнгөрүүлэх, эрх чөлөөт амьдралд гарах боломж олгох вэ гэсэн зарчмын шинжтэй зохицуулалт юм.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд хорих ял шийтгэгдсэн этгээд оногдсон ялын 50 хувийг эдэлсэн тохиолдолд ял эдлэх дэглэмийг хөнгөрүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэж байгаа. Өөрөөр хэлбэл, оногдуулсан ялын тал хувийг эдэлсний дараа тухайн ялтны зан төлөв, хандлага буюу хөдөлмөрлөх, суралцах, төлөвших явцын үр дүн харагдана гэж тооцож байна гэсэн үг.

Харин “Бүх насаар хорих ял” шийтгэгдсэн ялтны хувьд хуулиар тогтоосон хугацааны дараа тухайн ялтны нийгмийн хор аюул буюу гэмт зан үйл арилсан байх шаардлагатай зэрэгцээ нийгэмд гарч тодорхой хугацаанд эрүүл, зөв амьдарлаар амьдрах итгэл найдвар үлдсэн байх шаардлагатай юм.

Монгол эрэгтэй хүний дундаж нас 64.9 байгаа талаар Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2010 оны Хүний хөгжлийн индекс дурджээ. Эндээс “Бүх насаар хорих ял”-аар шийтгэгдсэн ялтны ял эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх, тухайн ялтны нийгмийн хор аюул арилсны дараа эрх чөлөөт амьдралд гарах боломжийг нээж өгсөн зохицуулалтыг бий болгохдоо монгол хүний дундаж насалттай харьцуулахын зэрэгцээ бусад үр дагаварыг тооцон үзэх нь зүйтэй.

“Бүх насаар хорих ял”-аар шийтгэгдсэн ялтны эрх зүйн хөнгөлөлтийг хүний дундаж насалт ба хүнлэг ёсны зарчмыг харгалзан тогтоохдоо ял

эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх хугацааг шийтгэгдсэнээс 20 жил, нийгэмд гарах хугацааг ял эдлэх нөхцөл хөнгөрснөөс 5-10 жилээс илүүгүй, шийт 25-30 жил байхаар зохицуулж болох гаргалгаа харагдаж байна. Гэхдээ энэхүү хуулийн заалтыг зан үйл, хандлага, төлөвлөөрөө өөрийгөө бүрэн харуулж чадсан, нийгмийн хор аюул нь арилсан ялтанд хэрэглэхээр тодотгож өгөх шаардлагатай.

Үүнээс гадна "Бүх насаар хорих ял"-ыг эмэгтэйчүүд, хүүхдүүдэд оногдуулахгүй байх нь ардчилсан төрийн үнэт зүйл болох хүний эрхийг дээдлэх, хүнлэг ёсыг сахих зарчимд нийцэх юм.

Дээрх судалгаа, дүгнэлтэй холбогдуулан "Бүх насаар хорих ял"-ыг хаалттай буюу эрхийн хязгаарлалт, хяналт-хамгаалалтын хувьд чангаруулсан нөхцөлд эдлүүлэх чиглэлээр дараах саналыг оруулж байна:

1. Хорих өрөөний стандарт, хамгаалалтын техник хэрэгслийн байгууламжийг тусгайлан тогтоож өгөх;

2. Хорих өрөөнд ганцаарчилан хорих ба тодорхой хугацааны ялыг эдэлсний дараа ял эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх;

3. Эмнэлэгийн бүхий л төрлийн тусламж үйлчилгээ болон бусад сэтгэл зүй, зан үйлийн арга хэмжээ, хууль зүйн тусалцаа зэргийг зөвхөн хорих байранд үзүүлэхээр зохицуулах;

4. Бүх насаар хорих ял эдлүүлэх байрыг төвлөрсөн халаалт, дулааны шугамд холбогдсон байхаар буюу төв суурин газар байгуулж, тэнд ажиллах албан хаагчдын нийгмийн асуудлыг хамтад нь шийдвэрлэхээр тооцох;

5. Хорих байрны байгууламжид удирдлагын байр, техникийн хяналтын болон шуурхай бүлгийн байр, уулзалтын өрөө, эмнэлэгийн тусламжийн болон урьдчилан сэргийлэх өрөө, сэтгэл зүй, нийгмийн ажлын нөлөөллийн өрөө, угаалга ариутгалын цэг, хямралт байдлын үед ашиглах байр зэргийн хамт цогц байдлаар байгуулах;

6. Хорих өрөөнөөс гаргах, оруулах, бусад хоригдогчтой харьцах ажиллагааг тусгай хэрэгсэл, нэмэлт хамгаалалттай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

7. Бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээд нас барсан тохиолдолд ар гэр хүсэлт гаргасан бол цогцсыг ар гэрт шилжүүлэх ба ар гэрээс хүсэлт гаргаагүй бол 5 хоногийн дараа хорих байрны захиргаа зардлыг гаргаж оршуулахаар зохицуулах;

8. Эрхийн бусад хязгаарлалтын хувьд:

- Ар гэртэй утсаар ярих нь 3 сард нэг удаа байхаар;
- Удаан хугацааны уулзалт олгогдохгүй;

- Түр хугацааны уулзалт жилд нэг удаа;
- Жилд 2 удаа захидал, илгээмж хүлээж авах, явуулах;
- Шашны болон уламжлалт зан үйл, сэтгэл зүйн засал үйлчилгээнд тодорхой хуваарьтай хамрагдах;
- Хорих байранд зориулалтын цэгт, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн хөдөлмөр эрхлүүлэх;
- Нэрийн дансанд мөнгө байршуулан ашиглах, хорих өрөөнд хувийн эд зүйл хэрэглэхийг хориглох;
- Салхилуулах болон биеийн хөдөлгөөнт дасгалыг 7 хоногт 3-аас доошгүй удаа хийлгэх;
- Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах журамд хамрагдахгүй байх;
- Хоригдогчид зориулсан аудио болон видео мэдээлэл түгээх хэрэгсэлийг хязгаарлалттайгаар ашиглах;
- Ном, сонин, сэтгүүлийг тодорхой хязгаарлалттайгаар ашиглах;
- Эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг үйлчилгээнд 7 хоногт нэг удаа хамрагдах зэргээр зохицуулж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Дээрх нөхцөл, журам болон эрхийн хязгаарлалтыг зохицуулсан ерөнхий заалтыг Эрүүгийн хуульд "Бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээдийг хаалттай дэглэмд ял эдлүүлэх ба эрхийн хязгаарлалтыг тусгайлан тогтооно" гэж тусгаж өгөх боломжтой. Түүнчлэн бүх насаар ял эдлүүлэх байранд мөрдөх журмыг дээрх бодлого чиглэлд нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн баталж мөрдүүлэх нь одоогийн баримталж буй хууль, тогтоомжид нийцэх юм.

Энэхүү өгүүлэл нь судлаачийн зүгээс өөрийн судалгаа, дүгнэлтэд тулгуурлан бичиж, санал дэвшүүлсэн бичвэр бөгөөд ямар нэг албаны байр суурь илэрхийлээгүйг дурдахын зэрэгцээ сонирхсон хэн боловч санаа, бодлоо хуваалцахыг хүсье.

Сөрөг нэхэмжлэл

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
ахлах багш, докторант Д.Хуяг



I. СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ

Нэхэмжлэгчээс хариуцагчид холбогдуулан гаргасан нэхэмжлэлээс хамгаалах үндсэн хэрэгсэл бол нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй татгалзлалаа тайлбарын хэлбэрээр гаргадаг байна. Сөрөг нэхэмжлэл нь нэхэмжлэгчээс хариуцагчид хандан гаргаж байгаа материаллаг эрх зүйн шаардлагад өгч байгаа материаллаг эрх зүйн татгалзал юм. Хариуцагч нь сөрөг нэхэмжлэл гаргаж нэхэмжлэгчийн шаардлагыг эсэргүүцэж өөрийн байр сууриа хамгаалахыг хичээдэг.

Сөрөг нэхэмжлэл гэдэг нь үндсэн нэхэмжлэлтэй хамтруулан шийдвэрлүүлэхээр хариуцагчаас нэхэмжлэгчид гаргаж байгаа материаллаг эрх зүйн шаардлагыг хэлнэ гэж тодорхойлж болох боловч энэ талаар хуульч, судлаачид янз бүрээр байр сууриа илэрхийлдэг. Үүнийг авч үзвэл:

ОХУ-ын дэд доктор А.А.Ференс-Сороцкий “Сөрөг нэхэмжлэл гэдэг нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхны нэхэмжлэлтэй хамтруулан шийдвэрлүүлэхээр хариуцагчаас шүүхэд гаргаж байгаа түүний бие даасан шаардлагыг хэлнэ”¹, дэд доктор И.М.Пятилетов “Сөрөг нэхэмжлэл гэдэг нь нэгэнт эхэлсэн иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаас өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор нэхэмжлэгчид хандан гаргаж байгаа хариуцагчийн бие даасан шаардлагыг хэлнэ”², дэд доктор Н.И.Масленникова “Сөрөг нэхэмжлэл гэдэг нь хариуцагчаас тухай хэрэгт шүүхэд хандан нэхэмжлэгчийн анхны нэхэмжлэлтэй хамтруулан шийдвэрлүүлэхээр хариуцагчийн гаргаж байгаа

бие даасан шаардлагыг хэлнэ”³, ХБНГУ-ын хуульч Юпп Ёоахимиский “Сөрөг нэхэмжлэл гаргах нь үндсэн нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөхөөс татгалзах буюу эсэргүүцэл гаргах арга хэрэгсэл биш харин хэд хэдэн эрх зүйн маргааныг нэг дор шийдвэрлэх боломжийг бүрдүүлдэг хүчин зүйл юм”⁴, хуульч А.Доржготов “Хариуцагч нэхэмжлэлийг гардан авсны дараа үндсэн нэхэмжлэлтэй хамтруулан шийдвэрлүүлэхээр нэхэмжлэгчид хандан гаргаж байгаа нэхэмжлэлийн хариу шаардлагыг сөрөг нэхэмжлэл гэнэ”⁵, хуульч З.Мөнхжаргал “Хуульд зааснаар хариуцагчийн иргэний процессын эрхийн нэг нь нэхэмжлэгчийн эсрэг сөрөг нэхэмжлэл гаргах боломж юм. Өөрөөр хэлбэл, хариуцагчаас нэхэмжлэгчид хандан гаргаж байгаа бие даасан шаардлагаа анхны нэхэмжлэлийн хамт хэлэлцүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргаж байгааг сөрөг нэхэмжлэл гэж ойлгож болно”⁶

Шүүхийн статистикийн тоо баримтаас үзэхэд Нийслэл, дүүргийн шүүх 2008 онд нийт 10872 иргэний хэрэг шийдвэрлэсний 1.2%-д нь буюу 127 хэрэгт сөрөг нэхэмжлэл гаргажээ. Үүнээс 16,5% нь буюу 21 хэргийн сөрөг нэхэмжлэлийг хангаж, 18,3% нь буюу 24 хэргийн сөрөг нэхэмжлэлийн зарим хэсгийг нь хангаж, 42,6% буюу 54 хэргийн сөрөг нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, үлдэх 28 хэрэг буюу 22,7%-ийг нь ИХШХШ тухай хуулийн 74, 106, 117 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэжээ. Нийслэлийн шүүхийн давж заалдах шатны иргэний шүүх хуралдаанаар 2008 онд 738 хэрэг хянан шийдвэрлэсний 8,2% буюу 61 хэрэг нь сөрөг нэхэмжлэлтэй хэрэг байна. Улсын дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар 2008 онд Нийслэлийн давж заалдах шатны иргэний шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн 208 хэрэг хянагдсаны 16 хэрэг нь сөрөг нэхэмжлэлтэй хэрэг байжээ. Дээрх шийдвэрлэсэн ба хянагдсан сөрөг нэхэмжлэлтэй хэргүүдэд дараах алдаа дутагдал гарчээ. Тухайлбал:

1. Баянзүрх дүүргийн шүүхийн 2008 оны 1015 тоот захирамжтай Гүнж-Эх ХЗ хоршоог нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд биш гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ сөрөг нэхэмжлэлтэй хэргийг хэрэгсэхгүй болгоогүй;

2. Баянгол дүүргийн шүүхийн 135 дугаар шийдвэртэй хэргийн сөрөг нэхэмжлэлийн зарим шаардлагыг шүүх хуралдаанаас гаргасан шийдвэрээр хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн нь буруу болсон;

3. Баянгол дүүргийн шүүхийн 919, Сонгино хайрхан дүүргийн шүүхийн

³ Ред. В.В.Ирков. Гражданский процесс. М.1999. С.250-251.

⁴ Юпп Ёоахимиский, “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар”. Уб., 2004 он, 129-131 дэх тал.

⁵ Ред.Т.Мөнхжаргал, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги”. А.Доржготов Уб., 2011 он, 152-153 дахь тал.

⁶ З.Мөнхжаргал, “Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, Ерөнхий анги”. Уб., 2005 он, 229 дэх тал.

9 ба 12 тоот шийдвэртэй хэргийн сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэхдээ тухайн сөрөг нэхэмжлэл үүсгэсэн маргааныг нь зохицуулсан хуулийг хэрэглэх байтал, сөрөг нэхэмжлэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохицуулж буй заалт болох хуулийн 73 дугаар зүйлийг баримтлан хэргийг шийдвэрлэсэн нь буруу болжээ.⁷

II. ИХШХШ ТУХАЙ ХУУЛИЙН 73 ДУГААР ЗҮЙЛИЙН (СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛЭ) ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

1. Сөрөг нэхэмжлэл нь ердийн нэхэмжлэлийн нэгэн адил зөрчигдсөн эрхийг сэргээх;

2. Сөрөг нэхэмжлэлийн үндэслэл шаардлагыг үндсэн нэхэмжлэлийн үндэслэл шаардлагатай хамт шийдвэрлүүлэх зорилготой.

Үндсэн нэхэмжлэлтэй хэрэг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагч сөрөг нэхэмжлэлийг гаргасан байх, нэхэмжлэлийн бүрдүүлбэрийг хангасан байх шаардлагатай.

Шүүх сөрөг нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэхдээ хоёр иргэний хэрэг үүсгэх байтал нэг иргэний хэрэг үүсгэж ажиллагаа явуулж нэг маргаанаар асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж, нэхэмжлэгчийн үндсэн нэхэмжлэлдээ дурдсан нотлох баримтыг хариуцагч нотлох баримтын хувьд ашиглах боломжтой болж, үндсэн нэхэмжлэлтэй сөрөг нэхэмжлэлийг хамтруулан хэлэлцсэнээр харилцан холбоотой 2 нэхэмжлэлийн шаардлагыг нэг шүүх хуралдаанаар шийдвэрлэж, нэг хэргийн талаар бие биедээ харшлах 2 шийдвэр гарахаас урьдчилан сэргийлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эмх цэгцтэй, шуурхай явуулах ач холбогдолтой болно.

III. СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛИЙГ ШҮҮХ ХҮЛЭЭН АВАХ НӨХЦӨЛ

ИХШХШ тухай хуулийн 72 дугаар зүйлийн 2-т “Сөрөг нэхэмжлэлийн шаардлага үндсэн нэхэмжлэлийн шаардлагатай тооцогдох байвал шүүх сөрөг нэхэмжлэлийг үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд тэдгээрийг хамтруулан шийдвэрлэх эсэхийг шүүх шийдвэрлэнэ” гэж заасан ба энд дурдсан сөрөг нэхэмжлэлийн шаардлага үндсэн нэхэмжлэлийн шаардлагатай тооцогдоно гэдэгт юу ойлгох вэ гэдэг асуудал гарч байна. Хариуцагчаас шүүхэд хандан нэхэмжлэгчид тавьсан шаардлага болгон сөрөг нэхэмжлэл болохгүй. Хуульд зааснаар зөвхөн хоорондоо тооцогдох боломжтой шаардлагыг шүүх сөрөг нэхэмжлэлийн журмаар үндсэн нэхэмжлэлтэй хамтатган шийдвэрлэж болно. Үндсэн

⁷ Нийслэлийн шүүхийн эвлэмж. 2009-10-27. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 73 дугаар зүйл буюу сөрөг нэхэмжлэлийн талаар. 17-18 дахь тал.

нэхэмжлэлийн шаардлагатай тооцогдох боломжтой гэдэг нь Иргэний хуулийн 238 дугаар зүйлд заасан харилцан шаардлага бүхий үүргийг тооцож дуусгавар болгох зохицуулалтад хамаарах нөхцөлийг хэлнэ. Мөн зүйлд заасан "бусад тохиолдолд" гэдэгт юу хамаарах вэ гэдгийг авч үзвэл шүүхийн практик, хуульч, судлаачид дараах ойлголт буюу нөхцөл байдлыг хамааруулан ойлгодог байна.

1. Сөрөг нэхэмжлэлийн шаардлага нь үндсэн нэхэмжлэлтэй нэг төрлийнх, эсхүл нэг маргаантай асуудалтай холбоотой байх. Жишээ нь:

(a) Нэхэмжлэгч бусдын хууль бус эзэмшлээс өөрийн өмчлөлийн орон сууцыг чөлөөлүүлэхийг хүссэн нэхэмжлэлийг шүүхэд гаргасан. Харин хариуцагч нэхэмжлэгчийн уг орон сууцыг өмчлөх эрхийн гэрчилгээг хүчингүйд тооцуулах тухай сөрөг нэхэмжлэл гаргасан;

(b) Нэхэмжлэгч өв залгамжлалаар хүлээн авсан эд хөрөнгийг бусдын өмчлөлөөс гаргуулан авах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргасан байхад хариуцагч нэхэмжлэгчийн өв залгамжлах эрхийн гэрчилгээг хуулийн хүчин төгөлдөр бусад тооцуулах тухай сөрөг нэхэмжлэл гаргасан.

2. Хэрэв шүүх сөрөг нэхэмжлэлийг хангах боломжтой гэж үзсэн тохиолдолд үндсэн нэхэмжлэлийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй бол шүүх тэдгээрийг хамтруулан шийдвэрлэнэ. Жишээ нь:

(a) Нэхэмжлэгч түрээсийн гэрээний үүргийг эерхсөнөөс учирсан хохирлыг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан байхад хариуцагч уг түрээсийн гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай сөрөг нэхэмжлэлийн шаардлага гаргасан

(b) Нэхэмжлэгч хүүхдийн тэтгэлэг гаргуулах тухай нэхэмжлэл гаргасан байхад хариуцагч эцэг тогтоолгох тухай сөрөг нэхэмжлэл гаргасан;

3. Үндсэн болон сөрөг нэхэмжлэлийн хооронд харилцан холбоо байгаа бөгөөд тэдгээрийг хамтатган хянан хэлэлцэж шийдвэрлэх нь маргааныг түргэн шуурхай, үнэн зөв шийдвэрлэхэд ач холбогдолтой бол шүүх мөн тэдгээрийг хамтруулан шийдвэрлэнэ. Жишээ нь:

(a) Нэхэмжлэгч гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл гаргасан байхад хариуцагч нэхэмжлэгчээс хүүхдийн тэтгэлэг гаргуулах ба хамтран өмчлөх эд хөрөнгийг хуваалгах тухай сөрөг нэхэмжлэл гаргах.

(b) Нэхэмжлэгч хүүхдийн тэтгэлэг тогоолох нэхэмжлэлийн шаардлага гаргасан байхад хариуцагч хүүхдийг өөрийн асрамжинд шилжүүлэхийг хүссэн сөрөг нэхэмжлэлийн шаардлага гаргасан.

Дээрх жишээнүүдээс үзэхэд сөрөг нэхэмжлэлийн шийдвэрлэлт нь

үндсэн нэхэмжлэлийн шийдвэрлэлтэд ямар нэг хэмжээгээр нөлөөлөхөөр нөхцөл байна.

IV. ШҮҮХЭД СӨРӨГ НЭХЭМЖЛЭЛ ГАРГАХ ХУГАЦАА

ИХШХШ тухай хуулийн 73 дугаар зүйлийн 1-д “Үндсэн нэхэмжлэлтэй хамт шийдвэрлүүлэхийн тулд хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж заасан ба уг зүйлд заасан хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах “хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө” гэсэн заалт нь оновчгүй, шүүх хуралдааныг түргэн шуурхай явуулах зарчимд нийцэхгүй байна гэж үзнэ. Сөрөг нэхэмжлэлээр тусгайлан иргэний хэрэг үүсгэдэггүй, сөрөг нэхэмжлэлийг шийдвэрлэх хугацаа нь үндсэн нэхэмжлэлтэй хэргийн хуульд заасан хугацаанд хамаарах тул хариуцагч сөрөг нэхэмжлэлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа дуусаж байх үед гаргавал сөрөг нэхэмжлэлд холбогдуулан зохигчдоос нотлох баримт шуглуулах ажиллагаа цаг хугацааны хувьд хязгаарлагдмал болж зохигчдийн мэтгэлцэх эрхийн зарчим бүрэн хэрэгжих боломжийг алдагдуулах талтай. Мөн ИХШХШ тухай хуульд шүүгч иргэний хэрэг үүсгэснээс хойш нэхэмжлэлийг нийслэлд 7 хоног, орон нутагт 14 хоногийн дотор гардуулан өгөхөөр заасан ба энд шүүгч хариуцагчид эдлэх эрхийг нь түүний дотор сөрөг нэхэмжлэл гаргах эрхийг нь (хуулийн 26.3) танилцуулан өгч байгаа учир сөрөг нэхэмжлэл гаргах эрхийг хариуцагчид хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаанд бэлтгэх хүртлэх хугацаанд буюу хариуцагч нэхэмжлэлийг гардан авсанаас хойш 14 хоногийн дотор гаргах эрхийг нь ИХШХШ тухай хуульд заах ёстой гэж үзэж байна. Энэ нь талуудыг мэтгэлзэх боломжоор хангах, нэхэмжлэгч хариуцагчийн шаардлагыг няцаах баримтыг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

САНАЛ

1. ИХШХШ тухай хуульд “Сөрөг нэхэмжлэл” гэсэн тодорхойлолт оруулах.

2. Мөн хуулийн 72.2 дугаар зүйлд “Хариуцагч нэхэмжлэлийг гардан авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргах эрхтэй” гэж зааж өгөх.

3. Мөн хуулийн 73 дугаар зүйлийн 1 дэхь хэсгийн “хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхээс өмнө” гэснийг хасах.

4. Мөн хуульд 73¹ дугаар зүйл “Сөрөг нэхэмжлэл гаргах нөхцөлүүд” гэсэн шинэ зүйл нэмэх.

Профессор Юрий Ильич Скуратовын 60 насны ой тохиож байна



Энэ жил хууль зүйн доктор, профессор Юрий Ильич Скуратовын 60 насны ой, мөн түүний багш, эрдэм шинжилгээний ажлын 40 жилийн ой тохиож байна.

Энэхүү эрхэм нь амьдралын агуу их эрч хүчтэй, бүтээлч, зорилготой, эрдмийн өргөн мэдлэгтэй, өндөр мэргэшсэн, өөрийн мэргэжилдээ үнэнч нэгэн юм.

Ю.И.Скуратов нь 1952 оны 6 дугаар сарын 3-ны өдөр ЗСАБУ (ОХУ-ын Буриад Улсын нэр хуучнаар)-ын Улаан-Үдэ хотод мэндэлжээ.

1969 онд 42 дугаар дунд сургуулийг дүүргэж Свердловскийн Хууль зүйн сургуульд элсэн 1973 онд онц дүнтэй төгсжээ. Тэрээр онц сурахаас гадна шинжлэх ухаанд үнэн сэтгэлээсээ шимтэж, эрх зүйн асуудалд үндэс суурьтай, нарийн хандагаараа бусдаас ялгарч байжээ.

Оюутны "Төр, эрх зүй"-н дугуйланд нэгдүгээр дамжаанаасаа эхлэн явж байсан ба хожим нь 1973-1975 онд сэргийлэхийн тусгай батальонд алба хашсаны дараа аспирантурт элсжээ.

Скуратовын эрдэмийн ажлын диссертацийг профессор Судницын Юрий Григорьевич удирджээ. Профессор Судницын нь өнөөдрийг

хүртэл "сонгодогт" тооцогддог бүтээлүүдийн зохиогч билээ.

Скуратов Ю.И нь өөрийн удирдагчийн итгэлийг эвдэлгүй хугацаанаасаа өмнө 1977 онд үндэсний бүрэн эрхт байдлын асуудлаар диссертациаа хамгаалжээ. Харин 1987 онд тэрээр шинжлэх ухааны докторын диссертациаа хамгаалж Зөвлөлт Холбоот Улсын хамгийн залуу хууль зүйн шинжлэх ухааны доктор болжээ.

1977-1989 оны хооронд Юрий Ильич их, дээд сургуульд багш, дэд профессор, профессор, Төр, захиргааны эрх зүйн тэнхмийн эрхлэгч, Свердловскийн Хууль зүйн сургуулийн хамгийн том факультет болох Шүүх-прокурорын факультетын деканаар ажиллажээ. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн эрх зүйн тэнхмийн профессор болжээ.

1989 онд ЗХУ-ын Коммунист намын Төв хороонд шилжин хууль санаачлах болон эрх зүйн асуудлаарх хэлтсийн даргаар ажиллаж байсан. Харин 1991-1992 онд Дотоод хэргийн сайд Виктор Баранниковын ахлах зөвлөхөөр ажиллаж байжээ.

Юрий Ильич эрдэм шинжилгээний ажлыг практиктай гайхалтайгаар хослуулаж чаддаг нэгэн. Тухайлбал, тэр ЗХУ-ын Дээд зөвлөлийн коммунист-депутатуудын хуулийн төсөл боловсруулах ажилд идэвхтэй оролцож байсан бөгөөд ОХУ-ын шинэ Үндсэн хуулийн төсөл, прокурорын байгууллагын тухай, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн төсөлд тус тус оролцож байжээ.

Иймээс 1993 оноос ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын харьяа Хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх асуудлаарх эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгийн захирлаар ажиллаж, мөн тус хүрээлэнгийн коллегийн гишүүн нь байжээ. Энэ хугацаанд суралцаж байсан олон аспирант "тус хүрээлэн нь шинжлэх ухааны өндөр түвшний суурь судалгаатай хослуулсан, мэргэжлийн ур чадвартай, оюунлаг, найрсаг уур амьсгалтай байсан" талаар дурссан байдаг.

Дөч дөнгөж гарсан Юрий Ильич хариуцлагатай, гүйцэтгэл нь үр дүнтэй, хүсэл тэмүүлэлтэй, аливаад өөрийнхөөрөө ханддаг, шударга, "хууль зүйн" албанд үнэнч зэрэг чанараараа өөрийгөө зөвхөн эерэг талаасаа харуулан мэргэжлийн хамтын нийгэмлэгээс хүндэтгэлийг олж чаджээ.

Юрий Ильич Скуратов 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2000 оны 4 дүгээр 19-ний өдрийг хүртэл ОХУ-ын Ерөнхий прокуророор ажиллаж байжээ.

Хэдий Юрий Ильич ажлын ачаалал ихтэй, хомс зав чөлөөтэй ч "бага" Эх орон болох Буриад Улсаа хэзээч мартаж байгаагүй юм. Буриадаас гаралтай Ю.И.Скуратов нь буриадад хууль зүйн боловсролын байгууллагыг байгуулах нэн шаардлагатай байгааг ойлгож байсан ба 1994 онд түүний санаачлагаар Буриадын Улсын их сургуулийн Түүхийн ухааны факультетын дэргэд эрх зүйн салбарыг байгуулсан байна. Гурван жилийн дараа буюу 1997 онд энэхүү салбар нь бие даасан Хууль зүйн факультет болсон. Энэ факультет нь Буриадын Улсын анхны бөгөөд тухайн үед цорын ганц факультет байсан. Түүний хичээл зүтгэлээр хууль зүйн боловсролын суурь тавигдан хөгжсөөр байгаа бөгөөд Буриадын Улсын их сургууль нь хууль зүйн боловсрол авч болох ОХУ-ын Дээд боловсролын тэргүүлэх байгууллагын нэг юм.

2000 оны 11 дүгээр сард Юрий Ильич бүс хоорондын нийгэм, улс төрийн хууль хамгаалах "Шударга ёс ба хуулийн төлөө" хөдөлгөөнийг үүсгэн байгуулж хожим нь "XXI зууны эрх зүйн технологи" төрийн бүс олон нийтийн сан байгуулжээ. Энэ байгууллага нь эрх зүйн болон олон улсын эрх зүйн түвэгтэй асуудлыг шийдвэрлэхээс гадна Төрийн Дум, Холбооны Зөвлөлд хэлэлцүүлэхээр бэлтгэж буй холбооны хуулийн төсөлд шинжлэх ухааны шинжилгээ хийх чиг үүрэгтэй.

Үүнээс гадна Юрий Скуратов нь эрдэм шинжилгээний, багшийн болон олон нийтийн зэрэг олон ажил хийдэг. Тухайлбал, Юрий Скуратов Буриадын Улсын их сургуулийн профессор, аспирант, хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилогчдын эрдэм шинжилгээний удирдагч, ОХУ-ын Нийгмийн ухааны улсын их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүй, Захиргааны болон Олон улсын эрх зүйн тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байна.

Юрий Ильичийн одоо эрхлэж буй чухал алба нь Буриадын Улсын их сургуулийн "ОХУ ба Ази Номхон далайн бүсийн орнуудын харилцан ажиллагааг эрх зүйн хувьд хангах төв"-ийн захирлын алба юм. Түүний удирдлагад шинжлэх ухаан ба эрдэм шинжилгээ, практикийн олон арга хэмжээ зохион явуулсан. Тухайлбал, ОХУ-ын болон Монгол Улсын эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын асуудлаар дугуй ширээний уулзалт (2009 оны 2 дугаар сард Улаанбаатар хотод, 2009 оны 4 дүгээр сард Улаан-Үдэ хотод), Хил дамнасан гол, мөрөн хамгаалах асуудлаар семинар (2011 онд Улаанбаатар хотод) зэрэг арга хэмжээ зохиож байв.

Эдгээр эрдэм шинжилгээний хүрээнд хийгдэж буй арга хэмжээнээс цар хүрээгээрээ илүү нь жил болгон зохион явуулдаг “Ази Номхон далайн бүсийн орнуудын төр ба эрх зүйн тогтолцоо” сэдэвт бага хурал юм. Энэ жил ээлжит бага хурлын дөрөв дэх удаагийн хурлыг зохион байгуулж буй бөгөөд Үндсэн хуулийн эрх зүйн онол, практикийн асуудалд анхаарлаа хандуулсан сэдвийг сонгожээ.

Энэ төвийн болон Ю.И.Скуратовын өөрийнх нь хүчин чармайлтаар ОХУ болон Монгол Улсын хууль зүйн салбарын хамтын ажиллагааны болон манай хоёр улсын хууль тогтоомжийн харилцан зохицлын олон асуудлыг шийдвэрлэж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн урилгаар Ю.И.Скуратов нь Монгол Улсад зочилж байсан ба монголын талаарх олон сайхан дурсажтай билээ.

Юрий Скуратов нь 130 гаруй эрдэм шинжилгээний бүтээл турвисан ба их, дээд сургуульд зориулсан ОХУ-ын Үндсэн хуулийн эрх зүйн сурах бичгийн хамтран зохиогч болон бусад олон бүтээлийг турвин гаргасан. Тухайлбал, түүний хянан тохиолдуулснаар ОХУ-ын Эрүүгийн хуулийн тайлбарыг таван удаа эрхлэн гаргажээ.

Мөн түүний бичсэн “Владың амийг хэн сгүүтгэв” роман бестселлер болсон ба энэ романыг түүний анд Академич Ж.Амарсанаа монгол хэлнээ хөрвүүлжээ.

Бид нэрт эрдэмтэн, нийгмийн нэрт зүтгэлтэн, өөрийн салбартаа мэргэжилтэн Юрий Ильич Скуратовд насны ой тохиож буйд чин сэтгэлээсээ баяр хүргэж, эрүүл энх, эрдэмийн их амжилт хүсэн ерөөж байна.

----- uOo -----

“Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын конвенци” сэдэвт сургалт, семинар зохион байгуулав

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн сектор, Тагнуулын ерөнхий газрын Кибер, аюулгүй байдлын газар хамтран 5 дугаар сарын 17-ны өдөр “Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын конвенц” сэдэвт сургалт, семинарыг зохион байгуулав. Тус сургалтад урилгаар Европын консулын Кибер гэмт хэргийн конвенцийн хорооны нарийн бичгийн дарга Александр Сегер хүрэлцэн ирж хичээл заасан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын газар, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газар, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний тагнуулын академи. Харилцаа холбооны зохицуулах хороо, МУИС-ийн Хууль зүйн сургууль болон бусад их8 дээд сургуулийн төлөөлөл оролцлов.



Сургалтад Кибер, аюулгүй байдлын газрын орлогч дарга С.Ширбазар “Монгол Улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээ” сэдвээр, Эрүүгийн цагдаагийн газрын ажилтан Батхүү “Кибер гэмт хэрэгтэй тэмцэж буй байдал” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж Европын консулын Кибер гэмт хэргийн

конвенцийн хорооны нарийн бичгийн дарга Александр Сегерийн хичээл заажээ. Сургалтаар Кибер гэмт хэргийн Европын конвенцийн талаарх ойлголт, хууль сахиулах байгууллагууд хэрхэн хамтарч ажиллах, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэхэд анхаарвал зохих асуудлууд, процедурын хууль болон мөрдөн шалгагчид ашиглах хэрэгслүүдийн талаар мөн хууль сахиулах чиглэлийн олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаа, Будапештийн конвенцид нэгдэн орсон улсуудын туршлага, энэхүү конвенцийн ач холбогдол болон саад бэрхшээлийн талаар манай хуульчид, мэргэжилтнүүдэд хичээл заахын хажуугаар манай улсын хувьд энэ төрлийн гэмт хэрэгтэй хэрхэн тэмцэх, урьдчилан сэргийлэх, кибер аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар харилцан санал солилцжээ.

----- оОо -----

Хууль зүй, дотоод хэргийн яамны нээлттэй өдөрлөг болов

“ Ардын засаг-Ард түмэнтэйгээ хамт” аяны хүрээнд Хууль зүйн, дотоод хэргийн яамны нээлттэй өдөрлөг 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдөр болов. Өдөрлөгийн нээлтэд хүрэлцэн ирсэн дэд сайд В.Удвал “ХЗДХЯ” нь өнгөрсөн жил 100 жилийн ойгоо тэмдэглэн өнгөрүүлсэн. Манай яамны харьяа 12 агентлаг бий. Тухайлбал, Хууль зүйн үндэсний хүрээлэн судалгаа, эрдэм шинжилгээний олон ажил хийсэн бол Хил хамгаалах ерөнхий газар бидний аюулгүй байдлыг хангахын төлөө



үйл ажиллагаа явуулдаг билээ. Энэ байгууллага өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд их ажил хийсэн. Мөн Архивын цогцолбор байгуулж, төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг барьж байна. Нийт агентлаг, салбарынхаа албан хаагчдын нийгмийн асуудалд гол анхаарлаа хандуулж ажиллалаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 500 гаруй албан хаагчдын орон сууцыг хувьчилж өгсөн. Түүнчлэн хоригдож буй хүмүүст мэргэжил олгох зорилготой сургалт, үйлдвэрлэлийн төвийг нээсэн” гэжээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгч, эрхлэн гаргадаг “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, “Хууль зүйн мэдээ” сонин, Хууль зүйн мэдээлэл эмхтгэлүүдийг тарааж, номын худалдаагаар үйлчилсэн бол Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн

иргэдийн гарынх нь дардсыг цаасан дээр буулган өгч байв.

ХЗДХЯ-наас иргэдэд төрсний гэрчилгээ, нас баралтын гэрчилгээ, итгэмжлэл, улсын бүртгэлийн гэрчилгээ зэрэг бичиг баримтыг үнэ төлбөргүй нотариатаар баталж өгсөн. Мөн УБЕГ-аас бүх төрлийн лавлагааг олгожээ. Үүнээс 130 гаруй иргэд төрсний гэрчилгээний лавлагаа авсан тухай албаны хүн мэдээлэв.



ЦЕГ-аас 200 гаруй иргэдэд ял шийтгэлтэй эсэх тодорхойлолтыг гаргаж үйлчилжээ. Мөн жолооны үнэмлэхээ хаяж гэсэн, үрэгдүүлсэн материалын хүсэлтийг 50 гаруй иргэдээс хүлээн авчээ.

Өдөрлөгт Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газар, Архивын ерөнхий газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Дотоод хэргийн их сургууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагууд оролцож үйл ажиллагаагаа ард иргэдэд танилцуулсан юм.

“Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болов

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулиас санаачлан Хүмүүнлэгийн ухааны их сургууль, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хуралд БНХАУ, ОХУ-ын Буриад Улс болон Монголоос хууль зүйн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан судлаачид оролцож илтгэл хэлэлцүүлсэн юм.

2000-2012 оны хооронд Монголоос гадаад болон дотоодын их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан 70 орчим судлаач байгаагаас 28 эрдэмтэн тус хуралд өөрсдийн судалгааны сэдвээрээ илтгэл хэлэлцүүлсэн нь хурлын онцлог байв.



“Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын зорилго нь хууль зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг дэмжих, шинэ судлаачдын хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг бусдад таниулах байв.

Тус хурлын ач холбогдол нь хууль зүйн салбарт сүүлийн үед гарсан судалгаа шинжилгээ, үзэл баримтлал, шинэ хандлагыг олон нийтэд таниулах, хамтран ажиллаж байгаа байгууллагуудтай эрдэм судлалын ажлын туршлага солилцох, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх, багш, оюутан судлаачдын үйл ажиллагааг эрчимжүүлэх, судалгаа, шинжилгээний зохих дадлага, туршлага эзэмшүүлэх, сургалт, судалгааны ажлаа нийтэд хүртээлтэй болгоход оршино.

“Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал болов

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургуулиас санаачлан Хүмүүнлэгийн ухааны их сургууль, ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэн, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран “Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 2012 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хуралд БНХАУ, ОХУ-ын Буриад Улс болон Монголоос хууль зүйн доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан судлаачид оролцож илтгэл хэлэлцүүлсэн юм.

2000-2012 оны хооронд Монголоос гадаад болон дотоодын их сургуульд хууль зүйн докторын зэрэг хамгаалсан 70 орчим судлаач байгаагаас 28 эрдэмтэн тус хуралд өөрсдийн судалгааны сэдвээрээ илтгэл хэлэлцүүлсэн нь хурлын онцлог байв.



“Эрх зүйн үзэл баримтлал, шинэ хандлага” олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын зорилго нь хууль зүйн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагааг дэмжих, шинэ судлаачдын хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг бусдад таниулах байв.

Тус хурлын ач холбогдол нь хууль зүйн салбарт сүүлийн үед гарсан судалгаа шинжилгээ, үзэл баримтлал, шинэ хандлагыг олон нийтэд таниулах, хамтран ажиллаж байгаа байгууллагуудтай эрдэм судлалын ажлын туршлага солилцох, эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх, багш, оюутан судлаачдын үйл ажиллагааг эрчимжүүлэх, судалгаа, шинжилгээний зохих дадлага, туршлага эзэмшүүлэх, сургалт, судалгааны ажлаа нийтэд хүртээлтэй болгоход оршино.

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



ISSN 2226-9185



9 772226 918001